



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



MONGOLIAN SOCIETY FOR
RANGE MANAGEMENT

МОНГОЛД МАЛЧДЫН ТОГТВОРТОЙ АМЬЖИРГААГ ТЭДНИЙ ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Улаанбаатар 2010



МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХОЛБОО

МОНГОЛД МАЛЧДЫН ТОГТВОРТОЙ АМЬЖИРГААГ ТЭДНИЙ ХАМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Ө. Батсайхан, Ханс П. Бинсвангер-Мкхизе,
Раффаел Химмелсбах, Карл Шүүлер

2010 он



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development
and Cooperation SDC**

Швейцарийн Хөгжлийн Агентлаг санхүүжүүлэв.

МОНГОЛД МАЛЧДЫН ТОГТВОРТОЙ
АМЬЖИРГААГ ТЭДНИЙ ХАМТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГААР ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Зохиогч: Ө. Батсайхан, Ханз П. Бинзвангер-Мкхизе,
Раффаел Химмелсбах, Карл Шүүлер

Хянан
тохиолдуулсан: Ц.Сүхтулга

Дизайнер: Б.Чулуунсүрэн

“Сэлэнгэпресс” ХХК-ийн хэвлэх үйлдвэрт эхийг бэлтгэж хэвлэв.



Өмнөх үг

Монголд малчдын тогтвортой амьжиргааг тэдний хамтын үйл ажиллагаагаар дээшлүүлэх боломж байна уу?

Дээрх асуултанд хариу олохоор судалгааны баг ажлаа гүйцэтгэжээ.

Малчдын “Амьжиргаа”-ны талаарх өргөн хэмжээний судалгааны хавсрага хэсэг болон хийгдсэн энэхүү судалгаанд “хамтын үйл ажиллагаа болон хамтын байгууллага нь монгол орны малчдын амьжиргааг сайжруулах хийгээд бэлчээрийн доройтлыг бууруулахад чухал үүрэгтэй байж чадах” эсэхэд анхаарал хандуулан ажиллажээ.

Юуны өмнө нэг нутаг бэлчээрээ ашиглаж ирсэн малчид уламжлалдаа тулгуурлан нутаг дэвсгэрт үндэслэгдсэн Бэлчээр Ашиглалтын Хэсгийг (БАХ) Монгол орны зарим нутгуудад байгуулан үр дүнтэй ажиллаж байгааг энд дурьдах нь зүйтэй болов уу.

Хамтын нийгэмлэгийн зохион байгуулалттай болон зохион байгуулалтгүй малчдын хоорондын ялгаатай талыг судлахын зэрэгцээ орон нутгийн хамтын байгууллагын эдийн засаг, техник, засаглалын тогтолцооны болон хууль эрхзүйн орчныг энд нарийвчлан судалжээ.

Мөн малчдын хамтын байгууллагын тогтолцооны хэлбэрүүдийг судлах, нутаг дэвсгэрт үндэслэгдсэн хамтын нийгэмлэгийн тогтолцооны аргагүйг тайлбарлах, бэлчээртэй холбоотой одоогийн хүчин төгөлдөр хууль эрхзүйн баримт бичгүүдийг судлахын зэрэгцээ засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны гүйцэтгэх үүргийг тодорхойлох зэрэг ажлыг гүйцэтгэсэн байна.

Төрийн дэмжлэг болон сайн удирдлага малчдын хамтын нийгэмлэгийн тогтвортой оршин тогтнох болон үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад чухал үүрэгтэй хэмээн тайланд дүгнэсэн байна.

Төсөл дуусгавар болсон ч үйл ажиллагааг нь цааш үргэлжлүүлэн авч явах сумын ТББ-ын хүрээнд БАХ-

ийн тогтолцоо бий болж хөгжиж буй тул Малчдын Бүлгүүдийн хангаж чадахгүй байгаа тогтвортой байдлын зарим нөхцөлүүдийг хангаж байгаа юм.

Судалгааны таамаглал: Нутаг дэвсгэрт үндэслэгдсэн малчдын хамтын байгууллага \ бүлэг нь доорх нөхцөлийг хангаснаар бэлчээрийн болон МАА-н тогтвортой менежментийг бүрдүүлэх юм. Үүнд нэгд, бүлэг бие даасан байх хоёрт, орон нутгийн засаг захиргааны дэмжлэгийг хүлээсэн байх, гуравт, төслийнхөө буюу хамтын үйл ажиллагаандаа санхүүгийн туслалцаа болон техникийн зөвлөлгөө авах боломжтой байх зэрэг юм.

Нутаг дэвсгэрт үндэслэгдсэн малчдын хамтын нийгэмлэгийн тогтолцоо нь сүүлийн 4 жилийн хугацаанд Монголд туршигдсан учир одоогоор дээрх таамаглалыг эцэслэн хүлээж авах эсвэл татгалзах боломжгүй юм. Харин хамтын нийгэмлэг байгуулагдах хурд болон явцыг үнэлж дүгнэх, тогтвортой байж чадахуйц өөр боломжит загваруудын хамрах хүрээ ба эрчмийг судлах, мөн хамтын байгууллын үр дүнд хүрэх, тогтвортой байх нөхцөлүүдийг судлах нь зүйтэй юм.

Малчдын эдийн засгийн хүндрэлтэй асуудлыг хадгаламжийн болон маркетингийн хоршоо байгуулах байдлаар шийдвэрлэж мөн байгаль орчны хэвийн байдал хангахад хамтын үйл ажиллагаа ач холбогдолтой болохыг тайланд тэмдэглэжээ.

Экологийн тэнцвэрт орчин болон эдийн засгийн найдвартай байдал нь малчдыг малын тоо толгойгоо бэлчээрийн даацтайгаа нийцүүлэхэд хөтлөх болно хэмээн үзжээ.

Энэхүү судалгаа нь Монголын малчдын хамтын зохион байгуулалтын байгууллын талаар, өөрчлөлтөд хэрхэн дасах тэдний төлөвлөгөөний талаар илүү тодорхой ойлголт өгөхөөс гадна энэ салбарын хандивлагчдын нэгдсэн бодлого болон бодлогын хэлэлцүүлэгт шаардлагатай мэдээллийг бүрдүүлсэн хэмээн найдаж байна.

Ногоон Алт болсон бэлчээр мөнхөд ногоон байг.

Швейцарийн Хөгжлийн Агентлагийн
Суурин төлөөлөгч

Феликс Феллман

Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооны
Гүйцэтгэх захирал

Д.Дорлигсүрэн



Зохиогчдын тухай

Өсөхийн Батсайхан (Ph.D.) нь чөлөөт судлаач бөгөөд Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургуулийн Эдийн засаг-бизнесийн сургуультай хамтран ажилладаг. Орон нутгийн иргэдийн хөгжил, бэлчээрийн менежмент, хөдөө аж ахуйн бодлогын шинжилгээ, хөрөнгө оруулалтын төслүүдийн эдийн засаг-санхүүгийн шинжилгээ, бүтэц-зохион байгуулалтын хөгжлийн чиглэлээр ажилладаг.

Холбогдох хаяг: batsaikhan@gmail.com

Ханс Бинсвангер-Мкхизе (Ph.D.) нь хөдөө аж ахуйн хөгжлийн нэрт эдийн засагчдын нэг юм. Дэлхийн банкинд олон жил ажилласан бөгөөд одоо Өмнөд Африкт бие даасан зөвлөх, тус улсын Тшваны технологийн их сургуулийн шинэтгэлийн эдийн засгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн өргөмжилт профессороор ажиллаж байна. Мөн Америкийн хөдөө аж ахуйн эдийн засгийн холбоо, Шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийн Америкийн холбооны гишүүн бөгөөд Хөдөө аж ахуйн эдийн засагчдын олон улсын холбооноос Элмхирстийн медаль авсан төдийгүй “Эдийн засагт хэн нь хэн бэ” жагсаалтанд оржээ.

Тэрээр маш олон сэдвээр бүтээл туурвисан юм: технологийн эрин түүний нөлөөллийн эдийн засаг, хөдөө аж ахуйн механикжуулалт, Африкийн фермерийн системийн үүсэл хөгжил, эрсдэлийн үе дэх фермерийн зан төлөв, хөдөө аж ахуйн нийлүүлэлтийн хариу үйлдэл, хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтанд хөдөөгийн санхүүжилтийн нөлөө, хөдөө аж ахуй дахь үйлдвэрлэлийн харилцаа, газрын хуримтлал шинэтгэлийн талаарх дэлхийн түүх, мал аж ахуй –газар тариалангийн бодлогын улс төрийн эдийн засаг, хөдөө аж ахуй хүнсний бодлого, газрын бодлого шинэтгэл, орон нутгийн иргэдийн хөгжил, хөдөөгийн хөгжлийн стратеги, ДОХ-той тэмцэх арга зам.

Холбогдох хаяг: binswangerh@gmail.com

Раффаел Химмелсбах (Докторант) нь Швейцар улсын Лаузаннегийн их сургуульд төрийн бодлогын чиглэлээр докторийн зэрэг горилогчоор суралцдаг. Тэрээр байгалийн нөөцийн системийн засаглал, шинжлэх ухаанд үндэслэсэн бодлогын зөвлөлгөө чиглэлээр судалгааны ажил хийдэг.

Холбогдох хаяг: raffael.himmelsbach@gmail.com

Карл Шүүлер нь Швейцарийн хөгжлийн агентлагт байгалийн нөөцийн менежмент, орон нутгийн иргэдийн хөгжил, цөлжилттэй тэмцэх асуудлуудыг хариуцсан зөвлөхөөр ажилладаг. Швейцарийн хөгжлийн агентлагийн Монгол дахь салбарт 2007 оноос хойш ажиллаж байна.

Холбогдох хаяг: karl.schulersdc@gmail.com



ГАРЧИГ


Өмнөх үг	3	IV. Судалгааны арга зүй	19
Зохиогчдын тухай	4	• Нөхцөл сонгох	19
Нэр томъёоны хураангуй.....	6	• Ярилцлагын арга, тоон мэдээллийг шинжлэх	19
Хураангуй, дүгнэлт.....	7	• Судалгаанд явахад бэлтгэх, ярилцлагын хуваарь гаргах	20
I. Оршил	10	V. Судалгааны үр дүн	21
• Монголын бэлчээрийн мал аж ахуйн хямрал	10	• Судалгаанд хамрагдсан бүсүүдийн онцлог	21
• Бүтэц, зохион байгуулалтын уналтыг хэрхэн даван туулах вэ.....	11	• Мал маллагаанд гарсан өөрчлөлт.....	22
• Нутгийн иргэдэд түшиглэсэн бэлчээрийн менежментийг хөгжүүлэх хандивлагчдын аргууд.....	11	• Малчдын байгууллага байгуулах, ажиллуулахад гардаг хүндрэл	25
• Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн үр дүн, тогтвортой байдал	11	• Малчид өөрсдийн байгууллагаа хэрхэн ойлгож байна вэ.....	26
II. Монголд санал болгож буй малчдын нутаг дэвсгэрт тулгуурласан байгууллага	13	• Эдийн засаг, бэлчээрийн менежментийн үйл ажиллагаа.....	27
• Бэлчээр ашиглагчдын хэсгийн тогтолцоо	13	• Байгууллагын үр дүн, тогтвортой байдалд гарсан дэвшил.....	32
• Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн холбоо (БАХХ)	13	• Хүндрэлтэй БАХ-ийн нутаг дэвсгэрээс гадагш нүүх.....	34
• БАХ-ийн тогтолцооны урт хугацааны зорилго	13	• Малын тоог хянах	35
• БАХ болон БАХХ-ны амжилт, тогтвортой байдлын нөхцөлүүд.....	14	Ном зүй	37
• Бэлчээр ашиглагчдын хэсгийн тогтолцоонд гарах хүндрэлүүд	14	Хавсралт.....	37
III. Хамтын үйл ажиллагаа болон малчдын амьжиргаа ..	15	• A I: Бэлчээрийн ургамлын динамикийн тэнцвэрт, тэнцвэрт бус экологийн загвар	37
• Хандивлагчдын төслүүд.....	15	• A II: Судалгаанд хамрагдсан сумууд.....	38
• Малчдын бүлгүүд болон Бэлчээр ашиглагчдын хэсгүүд	18		



Нэр томъёоны хураангуй

English	Тодорхойлолт	Монгол
Access right	Нөөц хүртэх эрх	Хүртэх эрх
Aimag	Монгол Улсын аймаг	Аймаг
Bag	Нутгийн захиргааны хамгийн бага нэгж, хотын хороотой адил	Баг
Customary rights	Тухайн нутагт амьдардаг бүлгийн соёлоор дамжин гарч ирж буй эрх	Уламжлалт эрх
Exclusive use right	Байгалийн нөөцийг ашиглах давуу эрх (хүний, хүмүүсийн тодорхой бүлгийн, эсвэл байгууллагын)	Давуу эрхээр ашиглах
Facilitating NGO	БАХ/БАХХ-г байгуулж, үйл ажиллагааг нь явуулахад чиглүүлэх үүрэг бүхий Монголын бэлчээрийн менежментийн холбооны байгуулсан ТББ	Идэвхжүүлэгч ТББ
Green Gold (GG-PEM)	Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэй хэрэгждэг Ногоон алт бэлчээрийн экосистемийн менежмент төсөл	Ногоон алт (НА-БЭМ)
Herder Group (HG)	Нийтлэг эрх ашигтаа үндэслэгдэн гарч ирсэн малчдын албан болон албан бус бүлгүүд	Малчдын бүлэг (МБ)
MSRM	Монголын бэлчээрийн менежментийн холбоо	МБМХ
Ownership	Өмчлөл гэдэг нь нөөцийг давуу эрхээр ашиглах, удирдах эрх бөгөөд гуравдагч этгээдэд нөөцийг дамжуулах эрхтэй байдаг	Өмчлөл
Otor	Нөөц бэлчээрийн зорилгоор ашиглах нэмэгдэл бэлчээрийг хэлнэ	Отор
Pasture-user group (PUG)	Тухайн байгалийн нөөцийг (бэлчээрийн газар, усны нөөц гэх мэт) ашиглах эрх бүхий малчдын бүлгийг хэлнэ	Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)
Association of Pasture User Groups (APUG)	Сум, аймаг, улсын төвшин дэх бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн холбоо	Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн холбоо (БАХХ)
Pasture-user group system	Орон нутгийн захиргаа, чиглүүлэгч ТББ, бусад үйлчилгээ үзүүлэгчдийн тусламжтайгаар бэлчээрийн газар, мал аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх замаар малчдын тогтвортой амьжиргааг дэмждэг БАХ, БАХХ-ны нутаг дэвсгэрт тулгуурласан тогтолцоо	Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн тогтолцоо
Property right	Өмчлөлийн эрхтэй адил	Хөрөнгийн эрх
Possession	Гуравдагч этгээдэд дамжуулах эрхгүйгээр тодорхой хугацаанд нөөцийг (бэлчээр гэх мэт) ашиглах, удирдах давуу эрх	Эзэмшил
Soum	Аймгийн доор байдаг нутгийн захиргааны нэгж, хотын дүүрэгтэй адил	Сум
Sustainable Livelihood Project (SLP)	Дэлхийн банкаас санхүүжүүлж буй амьжиргаа болон бэлчээрийн менежментийн хөтөлбөр	Тогтвортой амьжиргаа төсөл (ТАТ)
Use right	Тодорхой байгалийн нөөцийг ашиглах эрх (бэлчээрийн газар, ус, түлш, мод, гэх мэт. Заавал давуу эрх байх шаардлагагүй)	Ашиглах эрх

Зураг 1: Судалгаанд хамрагдсан сумд





Хураангуй, дүгнэлт

Мал аж ахуйн салбар Монгол Улсын үндэсний нийт бүтээгдэхүүний (ҮНБ) 20.6 хувийг үйлдвэрлэж, ажиллах хүчний бараг 40 хувь нь тэнд ажиллаж байна. Тус улсад нүүдлийн болон хагас нүүдлийн чиглэлээр цөлөөс эхлээд үржил шимт ойт хээр хүртэлх экологийн бүх бүсэд төрөл бүрийн хэлбэрээр мал маллаж байна. Дэлхийн II дайны дараагаас эрчимтэй эхэлсэн аж үйлдвэрийн хөгжил, хотжих үйл явцтай зэрэгцэн хөдөөд эдийн засгийн хувьд идэвхтэй хүн амын эзлэх хувь эрс буурсан. Гэвч 1990-ээд оны эхээр төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед энэ хандлага эсрэгээр өөрчлөгдсөн байна. Улсын хөрөнгө оруулалт, хангамжийн цар хүрээ багассанаар зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед эдийн засгийн хямрал, ажилгүйдлийн төвшин эрс өсч хот суурин газар амьдарч байсан олон оршин суугч амьдрахын эрхэнд мал маллахаар хөдөөг зорьж байжээ. Мөн энэ үетэй давхцан нэгдлийн тогтолцоо задран унаж, мал хувьд шилжсэн юм. Нэгдэл нь хөдөөгийн хүн амын нийгмийн халамжинд онцгой үүрэгтэй байсан бөгөөд нэгдлийн тогтолцоо задран унаснаар нийгмийн болон мал аж ахуйн салбарт үзүүлэх үйлчилгээ үгүй болж, тэр үеэс эхэлж өссөн ядуурал одоо ч буурахгүй байсаар байна. Нэгдэл нь нийгмийн үйлчилгээ, техникийн туслалцаа үзүүлээд зогсохгүй нүүдлийн мал аж ахуйг удирдах бүтэц, зохион байгуулалтын үндсэн механизм нь байлаа. Нэгдлүүд бэлчээр хуваарилах, улирлын сэлгээ хийх зэрэг бүхий л үйл ажиллагааг удирдаж байсан юм. Гэтэл энэ систем өөрчлөгдөж, урьд нь чөлөөтэй нүүх эрх нь хязгаарлагдмал байсан малчид шинэ үндсэн хуулиар дуртай газар руугаа чөлөөтэй нүүх болсноор бэлчээрийн хяналттай тогтолцооноос дур зоргоор ашиглах тогтолцоонд шилжсэн юм. Аймаг, сум, багийн захиргааны удирдлагын дор бэлчээрийн газрыг ашиглах хууль эрх зүйн орчин бий болсон ч эдгээр оролдлогууд нь бэлчээр ашиглалтыг зохицуулах үр дүнтэй, ашигтай арга байсан гэдэг нь харагдахгүй байна.

Өнөөдөр Монгол Улсад бэлчээрийн доройтол, хөдөөгийн ядуурал гэсэн хоёр хямрал зэрэг гарч ирээд байгаа нь илхэн байна (Монголын бэлчээрийн менежментийн холбоо, 2009). Ургамлын нөмрөг, тэдгээрийн төрөл зүйлийн талаар 1960-аад оноос хойш хийсэн судалгаа тэр үеэс хойш бэлчээрийн доройтол шугаман (ibid) хандлагатай байгааг харуулжээ. Мөн үүнтэй зэрэгцээд Монголын хэмжээнд цаг уурын дулаарал шугаман хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. Ингэхлээр, бэлчээрийн доройтолд дараах хоёр хүчин зүйл нөлөөлж байх магадлалтай юм: цаг уурын өөрчлөлт, 1990-ээд онд бэлчээрийн менежментийг зохицуулах бүтэц уналтанд орсон. Гэвч бидэнд байгаа тоон мэдээллээс үзэхэд бэлчээрийн төлөв байдалд цаг уурын өөрчлөлт илүү нөлөөлж байна уу эсвэл бүтэц, зохион байгуулалтын уналт илүү нөлөөлж байна уу

гэдгийг тодорхой салгаж харах бололцоо байхгүй тул эдгээр хоёр хүчин зүйл хоёулаа нөлөөлж байна гэсэн дүгнэлтэнд хүрэх болж байна.

Ядуурлын сүүлийн үеийн хандлагуудыг харахад хөдөөд 2002/03 болон 2007/08 онуудын хооронд хүний ядуурлын индекс 42.7 хувиас 49.7 хувь болж 7 хувиар өссөн байгаа нь одоогийн байдлаар хөдөөгийн хүн амын тал хувь нь ядууралд байна гэсэн үг юм (Дэлхийн банк 2005, 2009). Ядуурлын тооцоог хийсэн эдгээр жилүүд нь дэлхийн эдийн засгийн хамгийн их өсөлтийн үеүдийн нэгэнтэй нь, Монголын эдийн засгийн хурдан өсөлтийн үетэй давхцаж байгааг нь тайлбарлахад нилээд бэрхшээлтэй байна (Монгол улсын Үндэсний статистикийн газар, 2009). Иймд ядуурал, дэлхийн эдийн засгийн хямралын үе хоёр зэрэг тохиочихоод байгаа өнөө үед Монголд мал аж ахуйн тогтвортой тогтолцоог бий болгох нь чухал, яаралтай ажил болжээ.

2004 оноос хойш Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт бэлчээрийн экосистемийн менежмент төсөл нь (Ногоон алт) нутгийн иргэдэд түшиглэсэн бэлчээрийн менежментийн үйл ажиллагаа, өвөл, хаврын тэжээл бэлтгэх, малын ашиг шимийг дээшлүүлэх, орлогын өөр эх үүсвэрийг бий болгоход малчдыг дэмжин ажиллаж байна. Ногоон алт төсөл нь малчдыг бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн зохион байгуулалтанд оруулж, улмаар энэ бүтцийг орон нутгийн захиргааны бүтцэд оруулах аргыг эрчимтэй туршсаар иржээ. Олон жилийн уламжлалын дагуу нэг газар нутгийн бэлчээрийг ашигладаг малчид нийлж бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийг байгуулдаг. Энэ нь тухайн газар нутгийн малчдыг БАХ-т заавал хамруулан газар нутгийн хил зааг бий болгож, сумын захиргаагаар баталгаажуулсан тогтолцоо юм. Тухайн БАХ-ийн газар нутагт байдаг бүх малчид гишүүн болох ёстой. Ингэснээрээ БАХ-ийн бэлчээрийн менежментийн чадавхад сөргөөр нөлөөлдөг гишүүн, гишүүн бусчуудын хоорондын зөрчилдөөнийг арилгадаг. БАХ нь нэгдэл биш, харин өөрсдийн нутаг дэвсгэрт явуулах үйл ажиллагааны бэлчээрийн менежментийн төлөвлөгөө (БМТ)-г хамтаараа хийх, хэрэгжүүлэх, хянах зорилго бүхий бие даасан байгууллага юм. БАХ-үүд орон нутгийн захиргааны дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд одоохондоо Ногоон алт төслөөс арга зүйн зөвлөгөө, хэсэгчилсэн санхүүжилтийн дэмжлэг аван ажиллаж байна. Бэлчээрийн менежментийн энгийнээс эхлээд төвөгтэйг хүртэлх бүхий л үйл ажиллагааг малчид хамтаараа хэрэгжүүлсээр эцсийн зорилго болох бэлчээрийнхээ даацад малынхаа тоог тохирууж чаддаг болох тэрхүү хамгийн хүнд ажлыг ч хамтаараа хийдэг болно гэж Ногоон алт төсөл үзэж байна. Сумын хэмжээнд БАХ-үүд нийлж Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн холбоо (БАХХ)-г байгуулдаг. БАХХ нь ажлын цомхон орон тоотой ажилладаг бөгөөд БАХ-үүдэд арга зүйн зөвлөгөө



өгөх, Ногоон алт төсөл дууссаны дараа БАХ-үүдийн үйл ажиллагааг зохицуулан авч явах баталгаа болох ёстой.

Тогтвортой амьжиргааны зайлшгүй урьдчилсан нөхцөл болох БАХ-үүдийн хамтаараа суралцах чадавхыг үнэлэхэд энэ судалгаа гол анхаарлаа хандууллаа. Ялангуяа энэ судалгаагаар БАХ-үүдийн хамтын үйл ажиллагаанд үндэслэсэн тогтолцоо нь (1) бэлчээр болон малын чанарыг сайжруулснаар тогтвортой амьжиргааг бий болгоход чухал хувь нэмэр оруулж чадаж байна уу, (2) бэлчээрийн тогтвортой менежментийг бүрдүүлэхэд төдийлөн сайн үр дүнгээ өгөхгүй байгаа хууль эрх зүйн хүрээг орлох нөгөө хувилбар нь болж чадах нь уу гэдэг асуултыг хөндөх явдал байлаа.

Энэ хоёр үндсэн асуултад хариулахын тулд Монголд байдаг агро-экологийн нийт таван бүсээс дөрвөн бүсийн эдийн засаг, экологийн хувьд өөр өөр зургаан газраас чанарын нөхцөлт судалгааг авсан юм. Чанарын судалгааг нийтдээ 22 суманд хийхдээ бэлчээрийн доройтол, түүний шалтгааны талаар малчдын санал бодол, ойлголт, малчдын хамтын байгууллагуудыг бий болгож цаашид үйл ажиллагааг нь явуулахад гарах хүндрэлүүд, заавал хамтаараа хэрэгжүүлдэг болон эсвэл ганц нэгээрээ хэрэгжүүлж болдог бэлчээрийн менежмент, улирлын нүүдэл, малын ашиг шимийг дээшлүүлэх үйл ажиллагаануудыг асууж судаллаа. Энэ судалгаагаар мөн холбогдох мэргэжилтнүүдийн саналд үндэслэн малчдын хамтын байгууллагуудын тогтвортой байдал, үүрэг хариуцлагын шалгууруудыг гаргаж одоо байгаа малчдын хамтын байгууллагууд ямар хэмжээнд эдгээр шалгууруудыг хангаж байгааг тодорхойлов. Бас малчдын санал бодлыг: (а) улирлын сэлгээ болон отор хийх, гэнэтийн гамшгийн үед нүүхэд бэлчээр ашиглагчдын тогтолцооны нөлөө ямар байх, (б) ирээдүйд малын тоог хязгаарлахад энэхүү тогтолцоо аль хэр нөлөөлж чадах эсэх гэсэн асуултаар авч үнэлгээ өгсөн юм.

“Ногоон алт” нь бэлчээрийн хамтын менежмент болон малчдын амьжиргааг дээшлүүлэх албан ёсны гишүүнчлэлтэй байгууллагыг байгуулахад нь малчдыг дэмжин ажилладаг Монголын цорын ганц хөтөлбөр биш юм. Гэвч бусад төслүүд нийтлэг ашиг сонирхолдоо үндэслэсэн малчдын сайн дурын гишүүнчлэл бүхий тухайн нөхцөл байдалд тохирсон малчдын бүлгийг (МБ) байгуулах замаар орон нутгийн иргэдийн хөгжлийг дэмжих арга барилыг баримталдаг. Малчны бүлгийн арга нь бүрэн төгс, хамгийн зөв арга бас биш. МБ-ийн гишүүд нь орлого нэмэгдүүлэх, бэлчээр болон малын чанарыг сайжруулахад хамтран ажилладаг. БАХ-ээс ялгаатай зүйл нь гэвэл МБ нь засаг захиргааны бүтэн нэг нэгжийг хамардаггүй бөгөөд зарим нэг нь бэлчээр ашиглах гэрээг сумын захиргаатай байгуулсан байдаг тул нутаг дэвсгэрт тийм ч хүчтэй үндэслэсэн байдаггүй. МБ-үүд үйл ажиллагаа явуулдаг сумуудад БМТ байдаг ч сумын захиргаа санаачлан хийдэг бөгөөд хэрэгжилтийг нь ч удирдан зохион байгуулдаг ажээ. БАХ-ийн гүйцэтгэх үүргийг үнэлэхийн тулд дээр

дурдсан шалгууруудын дагуу МБ-үүдийг БАХ-үүдтэй харьцууллаа.

Малчид болон бусад холбогдох талуудаас авсан ярилцлагаас үзэхэд БАХ-үүд тэнцвэрт болон төвийн бүсийн холимог бэлчээрийн менежментийн бүсэд (Хавсралт А. I-ээс тодорхойлолтыг үз) бэлчээрийн менежментийн болон нүүдлийн төлөвлөгөөнүүдийг хийх, хэрэгжүүлэхэд малчдыг бүрэн зохион байгуулан ажиллаж чадна гэдэг нь харагдаж байлаа. Гэтэл МБ-үүдэд ийм чадавх маш бага байгаа нь харагдаж байна. Учир нь тэдгээр нь БАХ-үүд бэлчээрийг хянаж буй төвшинд хүртэл бэлчээрийг хянаж чадахгүй байна. Суманд байгуулагдсан БАХХ шиг байгууллага идэвхтэй ажиллаад байвал БАХ-үүд үүргээ тогтвортой гүйцэтгээд байх боломж байна. Мөн төрийн дэмжлэг болон сайн удирдлага БАХ-үүдийг үүргээ тогтвортой, үр дүнтэй гүйцэтгэхэд ихээхэн нэмэр болно гэдэг нь судалгаанаас тодорхой харагдаж байлаа. Хол, олон нүүдэл хийдэг, бэлчээрийн тэнцвэргүй тогтолцоотой говь, хээрийн бүсэд БАХ малчдын хэрэгцээг хангах боломж бага харагдлаа. Энэ бүсийн малчид БАХ-ийг бэлчээрийн бүтээмжийг дээшлүүлэх зөв зүйл гэж үзэхгүй байгаа юм. Үнэхээр шинжлэх ухаан ч тэр, малчид ч тэр тэнцвэргүй тогтолцоонд бэлчээрийн доройлтыг үүсгээд байгаа хүчин зүйл нь малын нягтаршил болон бусад менежментийн хүчин зүйлүүд биш гэж үзэж байна. Энэ нь цөлийн бүсэд яг адилхан бөгөөд тэр бүсийг бид судлаагүй болно.

БАХ-ийн тогтолцоо эрчимжих тусмаа хамтын хөдөлмөр шаарддаг болон шаарддаггүй бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд илүү тохиромжтой болж байна. Энэ нь нэг талаасаа БАХ-ийн үйл ажиллагааг дэмжин ажилладаг орон нутгийн малчдын ТББ-ыг бий болгосонтой, нөгөө талаас том хэмжээтэй БАХ-үүд дээрх үйл ажиллагааг удирдан авч явах илүү чадвартай байдгийг харуулах юм. Мөн үүний нэгэн адилаар төсөл дууссанаас хойш үйл ажиллагаа нь буурдаг МБ-тэй харьцуулахад БАХ байгуулагдаж хэсэг хугацаанд үйл ажиллагаа явуулсны дараа тогтвортой байдлын илүү олон нөхцөлүүдийг хангаж байна. Одоогийн байдлаар БАХ-үүд төслийн дэмжлэгийг авч түүгээрээ үйл ажиллагаа явуулаад хөгжлийн тодорхой шатанд хүрээд байгаадаа ихээхэн баяртай байдаг юм байна. Иймд төслийн дэмжлэггүй бол МБ, БАХ хоёр яаж ажиллах вэ? гэдэг талаар шууд харьцуулалт хийхэд бэрхшээлтэй байна. Төслийн үйл ажиллагааг цааш нь үргэлжлүүлэн авч явах суман дээр байгаа ТББ-ын хүрээнд БАХ-ийн тогтолцоо бий болж хөгжиж буй тул МБ-үүдийн хангаж чадахгүй байгаа тогтвортой байдлын зарим нөхцөлүүдийг хангаж байгаа юм.

Одоогийн байдлаар ган, зуд гэх мэт цаг агаартай холбоотой байгалийн эрсдэлийг даван туулах чадвар Монголын алс нутгуудаар сул байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь, гантай зун болонгуут мал тарга хүч сайн аваагүй дээрээ өвөл муу болбол онд орохгүй болно гэдэг хүлээлтээр алс нутгийн малчид малаа намар бөөнөөр нь зарахыг хичээж байна.



Энэ үзэгдэл нь зах зээл дээр хэт нийлүүлэлтийг бий болгож туранхайвтар мал үнэ хүрэхгүй байх аюулд хүргэдэг болох нь ажиглагдлаа. Энэхүү үнийн уналт нь малаа олноор нь зарах гэсэн алс нутгийн малчдад нөлөөлөөд зогсохгүй бүх Монгол Улс даяар нөлөөлдөг байна. Махны үнэ малчдын дотроо бодож байсан босго үнээс доогуур оронгуут малчид малаа зарахаа больж тарга хүч муутай олон малтай өвөлжсөнөөс болж малын болон төлийн хорогдол эрс нэмэгдэх аюултай байна. Гэтэл хот, томоохон суурингуудын ойр байдаг малчид өвөл малаа бага хорогдуулж байна. Тэд төвлөрсөн зах зээлээс тэжээл худалдан авч малаа бордсоноор бололцооны тарга хүчтэй малыг хавар үнэтэй борлуулж чадаж байгаа юм.

Өнгөрсөн 10 жилд бэлчээрээ сэлгэж нүүхээс илүү усны олдцыг дагаж нүүдэг болсон нь мал маллах арга барилд гарсан үндсэн өөрчлөлт гэж судалгаанд хамрагдагсад үзэж байна. Говь, хээрийн бүс нь уул толгод багатай, тэгш гадаргуутай тул малчид чөлөөтэй нүүх бололцоотой болдог бөгөөд энэ нь тус бүсэд хамтын хөдөлмөрийн санаачлагуудыг гаргаж ажиллахад бэрхшээл учруулдаг ажээ. Эндээс харахад бэлчээрт хил зааг татаж, түүний дотор малаа маллахад газрын гадаргын тогтоц, жилийн доторх нүүдлийн хэрэгцээг бууруулдаг бэлчээрийн тэнцвэрт нөхцөлүүд чухал үүрэгтэй байдаг байх нь. Хамтын хөдөлмөрийг идэвхжүүлэх стратегийг тал хээрийн бүсэд дахин эргэн харах, аймаг, сумын захиргаатай зөвшилцөн гаднаас ирдэг малчдын улирлын чанартай нүүдлийг бууруулах арга замыг олох шаардлагатай байна. Говь, хээрийн болон тал хээрийн бүсийн бэлчээрийн менежментийн асуудал нилээд төвөгтэй тул бусад бүсийнхээс нилээд ялгаатай малчдын хамтын байгууллагын загварыг бий болгох хэрэгтэй юм байна гэж үзлээ.

Сүргийн хэмжээ, түүний бүтцэд гарсан өөрчлөлт нь бэлчээрийн доройтлын шалтгаан болдог гэж үзэж байгаа газар нутгийн малчид малын тооны өсөлт, ялангуяа ямааны тооны өсөлт бэлчээрийн доройтлын үндсэн шалтгаан гэж ойлгож байна. Харин сонирхолтой нь шинжлэх ухааны үндэслэлтэй тооцсон бэлчээрийн доройтлын үнэлгээ, малчдын бэлчээрийн даацыг үнэлж буй байдал хоёрын хооронд багагүй зөрүү байна. Жишээ нь, маш их доройтсон гэж эрдэмтдийн үзэж байгаа газарт малчид доройтол дунд зэрэг гэж үзэх, эсвэл бүр эсрэгээр хэлж байна. Энэхүү бэлчээрийн төлөв байдлыг үнэлсэн шинжлэх ухааны үнэлгээ, малчдын үзэл бодлын зөрүүг цаашид судлах шаардлагатай. Өмнөд Африкийн жишээнээс үзэхэд малчдын үзэл бодол, ургамлын үнэлгээний судалгаа харьцангуй сайн тохирч байсан байна (Весүлс, Ланг 2010).

БАХ болон МБ-үүд үйл ажиллагаагаа явуулахад нилээд хэдэн хүчин зүйл сөрөг нөлөө үзүүлдэг байна. Судалгаа авсан ярилцлагуудад дүн шинжилгээ хийхэд хэдийгээр зарим эргэлзээ ихтэй малчид БАХ байгуулах эхний үе шатад оролцдоггүйг эс тооцвол МБ болон БАХ-ийг байгуулахад хялбар байдаг юм

байна. Харин малчны байгууллагын үйл ажиллагааг явуулахад маш бэрхшээлтэй гэж хариулжээ. МБ-үүд идэвхгүй байдлаасаа болж уналтанд ордогч төсөл дууссаны дараа тэдгээрийг идэвхжүүлээд аваад явах ТББ суман дээр үлддэггүй тул тэдгээрийн үйл ажиллагаа зогсонги байдалд ордог байна. Мөн МБ-ийн бэлчээр ашиглах эрх, бас МБ-ийн үр дүнд олдож байгаа үр шимийг хүртэхэд гишүүн болон гишүүн бусчуудын хооронд гардаг зөрчил ихээхэн бэрхшээл учруулдаг байна.

Малчдын байгууллагууд харьцангуй шинэ байгаа тул дараах дүгнэлтийг шууд хийхэд болгоомжтой хандах ёстой ч МБ-үүдийн тогтвортой ажиллах байдал нь БАХ-үүдийнхээс харьцангуй бага байна. Энэ хоёр байгууллага хоёулаа тэдгээрийн хүчийг дайчлах, үйл ажиллагаагаа төлөвлөхөд нь туслах, техникийн тусалцаа үзүүлдэг идэвхжүүлэгч байгууллагаас ихээхэн хамааралтай нь ажиглагдлаа. МБ, БАХ-үүд тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь учирдаг нийтлэг хүндрэл гэвэл санхүүгийн тогтворгүй байдал, гишүүн бусчуудтай харилцах тодорхой журам, бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлийн зохион байгуулалт зэрэг болно. Харин идэвхжүүлэгч ТББ нь сайн удирдлагатай, орон нутгийн захиргаатайгаа ажлын сайн харилцаатай байвал МБ, БАХ-үүдийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байна. Мөн малчны байгууллага үйл ажиллагаа удаан явуулсан байх тусмаа сайн ажиллаж байгаа нь харагдлаа.

БАХ-ийн үйл ажиллагааны улмаас бэлчээрийн бүтээмж дээшилж, даац нь сайжирсан ч одоо байгаа малаа багтааж чадахгүй, малын тоогоо хязгаарлахгүй бол болохгүй гэдгийг малчид өөрсдөө ойлгосны үр дүнд малын тоог хязгаарлаж болно гэдэг нь олон газар ажиглагдаж байлаа.

Энэ судалгаагаас дөрвөн зүйл харагдаж байна. Юуны өмнө, өөр өөрийн газрын гадаргын тогтцын онцлогоос хамаарч экологийн бүсүүд малчдын нийгмийн зохион байгуулалтанд нөлөө үзүүлж байна. Цөлөрхөг хээрийн бүсэд малчдын хамтын үйл ажиллагааг дэмжих нь ойт хээр, өндөр уулын бүсийнхээс хэцүү. Харин тал хээрийн бүсийн хувьд сайн ч биш муу ч биш, энэ хоёр хязгаарын хооронд байна. Хоёрдугаарт, бэлчээрийн менежмент, улирлын нүүдлийн асуудлыг зохицуулах ажлыг газар нутгийн байдалд тохирсон малчдын байгууллагууд орон нутгийн захиргаатай хамтран хийвэл илүү үр дүнтэй. Гуравдугаарт, малчдын хамтын байгууллага нь түүнийг идэвхжүүлэх ТББ гэх мэт тодорхой байгууллагын тусламжтайгаар сайн ажиллана. МБ-үүдэд одоохондоо ийм дэмжлэг байдаггүй тул төсөл дууссаны дараа үйл ажиллагаа нь зогсонги болж байна. Энэ тогтолцоог яаж байнгын болгох нь төслүүдийн эхний асуудал байх бөгөөд үндсэндээ бол төр үүнд шийдэл олох ёстой. Эцэст нь, хэрэв малчид малын болон бэлчээрийн бүтээмжийг дээшлүүлэхэд тусламж авбал орон нутгийн байгууллагуудын дэмжлэг, малчид өөрсдөө ойлгосны үр дүнд хэсэг хугацааны дараа малын тоогоо хязгаарлаж эхлэх сайн шинж тэмдэг харагдаж байна.



I. Оршил

Монголын бэлчээрийн мал аж ахуйн хямрал

Мал аж ахуйн салбар Монгол Улсын үндэсний нийт бүтээгдэхүүний (ҮНБ) 20.6 хувийг үйлдвэрлэж, ажиллах хүчний бараг 40 хувь нь тэнд ажиллаж байна. Тус улсад нүүдлийн болон хагас нүүдлийн чиглэлээр цөлөөс эхлээд үржил шимт ойт хээр хүртэлх экологийн бүх бүсэд төрөл бүрийн хэлбэрээр мал маллаж байна. Дэлхийн II дайны дараагаас эрчимтэй эхэлсэн аж үйлдвэрийн хөгжил, хотжих үйл явцтай зэрэгцэн хөдөөд эдийн засгийн хувьд идэвхтэй хүн амын эзлэх хувь эрс буурсан. Гэвч 1990-ээд оны эхээр төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед энэ хандлага эсрэгээр өөрчлөгдсөн байна. Улсын хөрөнгө оруулалт, хангамжийн цар хүрээ багассанаар зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед эдийн засгийн хямрал, ажилгүйдлийн төвшин эрс өсчээ. Иймд хот суурин газар амьдарч байсан олон оршин суугч амьдрахын эрхэнд мал маллахаар хөдөөг зорьж байжээ. Мөн энэ үетэй давхцан нэгдлийн тогтолцоо задран унаж, мал хувьд шилжсэн юм. Нэгдэл нь хөдөөгийн хүн амын нийгмийн халамжинд онцгой үүрэгтэй байсан бөгөөд нэгдлийн тогтолцоо задран унаснаар нийгмийн болон мал аж ахуйн салбарт үзүүлэх үйлчилгээ үгүй болж, тэр үеэс эхэлж өссөн ядуурал одоо ч буурахгүй байсаар байна. Нэгдэл нь нийгмийн үйлчилгээ, техникийн туслалцаа үзүүлээд зогсохгүй нүүдлийн мал аж ахуйг удирдах бүтэц, зохион байгуулалтын үндсэн механизм нь байлаа. Нэгдлүүд бэлчээр хуваарилах, улирлын сэлгээ хийх зэрэг бүхий л үйл ажиллагааг удирдаж байсан юм. Гэтэл энэ систем өөрчлөгдөж, урьд нь чөлөөтэй нүүх эрх нь хязгаарлагдмал байсан малчид шинэ үндсэн хуулиар дуртай газар руугаа чөлөөтэй нүүх болсноор бэлчээрийн хяналттай тогтолцооноос түүнийг дур зоргоор ашиглах тогтолцоонд шилжсэн юм. Аймаг, сум, багийн захиргааны удирдлагын дор бэлчээрийн газрыг ашиглах хууль эрх зүйн орчин бий болсон ч эдгээр оролдлогууд нь бэлчээр ашиглалтыг зохицуулах үр дүнтэй бөгөөд үр ашигтай арга байсан гэдэг нь харагдахгүй байна.

Өнөөдөр Монгол Улсад бэлчээрийн доройтол, хөдөөгийн ядуурал гэсэн хоёр хямрал зэрэг гарч ирээд байгаа нь илхэн байна (Монголын бэлчээрийн менежментийн холбоо, 2009). Ургамлын нөмрөг, тэдгээрийн нэр төрлийн талаар 1960-аад оноос хойш хийсэн судалгаа тэр үеэс хойш бэлчээрийн доройтол шугаман (ibid) хандлагатай байгааг харуулжээ. Мөн үүнтэй зэрэгцээд Монголын хэмжээнд цаг уурын дулаарал шугаман хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. Ингэхлээр, бэлчээрийн доройтолд дараах хоёр хүчин зүйл нөлөөлж байх магадлалтай юм: цаг уурын өөрчлөлт, 1990-ээд онд бэлчээрийн менежментийг зохицуулах бүтэц уналтанд орсон. Гэвч бидэнд байгаа тоон мэдээллээс үзэхэд бэлчээрийн төлөв байдалд цаг уурын өөрчлөлт илүү нөлөөлж байна уу эсвэл бүтэц, зохион байгуулалтын уналт илүү нөлөөлж байна уу гэдгийг тодорхой салгаж харах бололцоо байхгүй тул эдгээр хоёр хүчин зүйл хоёулаа нөлөөлж байна гэсэн дүгнэлтэнд хүргэх болж байна.

Ядуурлын сүүлийн үеийн хандлагуудыг харахад хөдөөд 2002/03 болон 2007/08 онуудын хооронд нэг хүний ядуурлын индекс 42.7-оос 49.7 болж 7 хувиар өссөн байгаа нь одоогийн байдлаар хөдөөгийн хүн амын тал хувь нь ядууралд байна гэсэн үг юм (Дэлхийн банк 2005, 2009). Ядуурлын тооцоог хийсэн эдгээр жилүүд нь дэлхийн эдийн засгийн хамгийн их өсөлтийн үеүдийн нэгэнтэй нь, Монголын эдийн засгийн хурдан өсөлтийн үетэй давхцаж байгааг нь тайлбарлахад нилээд бэрхшээлтэй байна (Үндэсний статистикийн газар, 2009, Монголын ядуурлын байдал). Иймд ядуурал, дэлхийн эдийн засгийн хямралын үе хоёр зэрэг тохиочихоод байгаа өнөө үед Монголд мал аж ахуйн тогтвортой тогтолцоог бий болгох нь чухал, яаралтай ажил болжээ.

Эрс тэрс уур амьсгал, цаг агаарын тогтворгүй байдал, газрын гарцыг урьдчилан харах боломж хомс, үе үе болдог ган, зуд нь Монгол орны ихэнх хэсэгт нүүдлийн болон хагас нүүдлийн мал аж ахуйг мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх хамгийн үр ашигтай хувилбар болгож байна. Нүүдлийн тоо жил жилдээ болон жилээс жилд агро-экологийн бүс бүрт өөр өөр, тухайлбал, цөл, цөлөрхөг хээрийн бүсэд хамгийн их, арай илүү чийглэг ойт хээрийн бүсэд хамгийн бага байна.



Бүтэц, зохион байгуулалтын уналтыг хэрхэн даван туулах вэ

Монголын бэлчээрийн доройтол нь ганцхан энэ улсад тохиолдож буй бэрхшээл биш юм. Бэлчээр, ой, загас, ус, агаар гэх мэт нийтийн өмчийн бүхий л нөөцийн ашиглалтыг зөв удирдахгүй бол бүгд доройтолд өртдөг. Эдийн засгийн утгаараа бол нийтийн өмчлөлд хамаарагдах нөөцийг өрсөлдөн хэрэглэдэг, хэний ч хэрэглээг ялгаж болдоггүй шинж чанартай. Энэ нь юу гэсэн үг вэ? гэхлээр хэдийгээр нөөц ашиглалт нь тухайн нөөцийг хомс (ойн хэмжээг барьж байхын тулд огтолсон модны оронд шинэ мод тарих ёстой) болгож байгаа ч нөөцийн ашиглалтыг хязгаарлах боломж муутай (жишээ нь, мод огтлолтыг). Хувьчлал нь (Хардин 1968) нийтийн өмчлөлийг арилгаж байгаа ч энэ нь гол төлөв оновчтой биш, ялангуяа мал жил бүр, заримдаа хэдэн жилээр нутаг алгасан нүүдэг Монголын бэлчээрийн хувьд хувьчлал гэдэг бол оновчтой хэлбэр биш. Гэвч ихэнх нийтийн өмчлөлийн нөөцийг хувийн эзэмшилд шилжүүлэлгүйгээр, харин нөөцийн хил хязгаарыг тодорхой болгож, ашиглах эрх, хэмжээг нь олгон, хянах тодорхой дүрмүүдийг бий болгосноор хамтын менежментээр (Остром, 1990, 2000, 2009) ашиглаж болдог.

Энэхүү ажиглалтаас бэлчээрийн тогтвортой менежментийг орон нутгийн иргэдийн хамтын хөдөлмөрөөр бий болгох зайлшгүй нөхцөлүүдийг гаргаж болох юм: (а) Хэрэглэгч болон хэрэглэгчдийн бүлэгт эзэмших, ашиглах эрхүүдийг олгох хууль, эрх зүй, бодлогын зөв орчинг бий болгох, (б) энэхүү эрхийг хуваарилах, хянах, дүрмийг хэрэгжүүлэх байгууллага, бүтцийг бий болгох, (в) нөөцийн олборлолт /хэрэглээг хэмжих найдвартай аргыг гаргаж ирэх.

Нутгийн иргэдэд түшиглэсэн бэлчээрийн менежментийг хөгжүүлэх хандивлагчдын аргууд

Малчдын хамтын үйл ажиллагааг дэмжих нь Монгол оронд нүүдлийн мал аж ахуй, бэлчээрийн менежментийг тогтвортой хөгжүүлэх арга зам гэдэгтэй олон хүн санал нэг байна. Дэлхийн банк, НҮБХХ, ШХА гэх мэт олон хандивлагч байгууллагууд малчдын хамтын үйл ажиллагааны олон хэлбэрийг туршсаар иржээ. Эдгээр төсөл, хөтөлбөрийн ихэнх нь гол төлөв орлого нэмэгдүүлэх, байгалийн нөөц хамгаалах чиглэлээр малчдын нийтлэг сонирхолд үндэслэн малчдын сайн дурын бүлгүүдийг дэмжин ажилладаг. Мөн Дэлхийн банкны Тогтвортой амьжиргаа төсөл (ТАТ) нь сумын засаг даргын тамгын газрын ажилтнууд, багийн дарга нарын чадавхыг дээшлүүлэх, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад тэдний оролцоог хангах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт төсөл нь 2004 оноос хойш орон нутгийн иргэдэд түшиглэсэн бэлчээрийн менежментийн үйл ажиллагаанууд, өвөл, хаврын тэжээл бэлтгэх, малын ашиг шимийг сайжруулах, орлого нэмэгдүүлэх хувилбаруудыг санаачлан ажиллаж байна. Ногоон алт төсөл нь орон

нутгийн захиргааны бүтцэд зүй ёсоор орсон бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн зохион байгуулалтанд малчдыг оруулах эрчимтэй аргыг туршсаар иржээ. Олон жилийн уламжлалын дагуу нэг газар нутгийн бэлчээрийг ашигладаг малчид нийлж бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийг байгуулдаг. Энэ нь холбогдох малчдыг заавал хамруулан газар нутгийн хил зааг бий болгож, сумын захиргаагаар баталгаажуулсан тогтолцоо юм. Тухайн БАХ-ийн нутаг дэвсгэрт нутагладаг бүх малчид гишүүн болох ёстой. Ингэснээрээ БАХ-ийн бэлчээрийн менежментийн чадавхад сөргөөр нөлөөлдөг гишүүн, гишүүн бусчуудын хоорондын зөрчилдөөнийг арилгадаг байна. БАХ нь нэгдэл биш, харин өөрсдийн нутаг дэвсгэрт явуулах үйл ажиллагааны БМТ-г хамтаараа хийх, хэрэгжүүлэх, хянах зорилго бүхий бие даасан байгууллага юм. БАХ-үүд орон нутгийн захиргааны дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд одоохондоо Ногоон алт төслөөс арга зүйн зөвлөгөө, хэсэгчилсэн санхүүжилтийн дэмжлэг аван ажиллаж байна. Малчид хамтын хөдөлмөр шаардсан бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг хамтаараа хэрэгжүүлсээр бүр сүүлдээ өөрийнхөө бэлчээрийн даацад малынхаа тоог тохирууж чаддаг болох тэрхүү хамгийн бэрхшээлтэй ажлыг ч хамтаараа хийж чаддаг болно гэж Ногоон алт төсөл үзэж байна. Сумын төвшинд БАХ-үүд нийлж Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн холбоо (БАХХ)-г байгуулдаг. Энэхүү БАХХ нь цөөхөн хэдэн ажилтантай бөгөөд БАХ-үүдийг арга зүйн зөвлөгөөгөөр хангах, Ногоон алт төсөл дууссаны дараа БАХ-үүдийн үйл ажиллагааг зохицуулан авч явах баталгаа болох ёстой.

Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн үр дүн, тогтвортой байдал

2009 онд Ногоон алт төслийн шинэ үе шатны төлөвлөлтийг эхлэхээс өмнө Монголын бэлчээрийн менежментийн холбоо малчдын амьжиргааны талаар дэлгэрэнгүй судалгаа хийсэн. Энэхүү судалгаагаар Монголын малчны эдийн засгийн тогтвортой амьжиргааг хэрхэн бий болгох вэ? гэдэг асуудлыг хөндсөн юм. Судалгааны тайланд бэлчээрийн доройтлыг даван туулахад зайлшгүй шаардлагатай эдийн засаг, техник, бүтэц, хууль эрх зүй, зах зээлийн орчинд анхаарлаа хандуулсан байлаа. Ялангуяа уул судалгаа нь малчид зах зээлийн болон бусад өөрчлөлтөд сүргийн бүтцээ өөрчлөх, малын тоогоо өсгөх, хөрөнгө оруулалт хийх, нүүдлийн хэмнэлээ өөрчлөх зэргээр хариу үйлдэл үзүүлдэг болохыг нотолжээ. Мөн бэлчээрийн доройтлыг бууруулах, даацыг сайжруулахад улирлын сэлгээг зөв хийх, бэлчээрийг амраах, хадлан сайн авах, алсын бэлчээрт хүрэх зам засах, шинээр гаргах гэх мэтээр олон арга байдгийг судалгаанд тэмдэглэсэн байна. Гэвч эдгээр арга зүйн шийдлүүдийн ихэнх нь бүтэц, зохион байгуулалт, хууль эрх зүйн үндэс нь одоохондоо бүрдэж амжаагүй байгаа хамтын хөдөлмөрийг зайлшгүй шаарддаг байна. Иймд хувь хүмүүсийн үйл ажиллагаанд зориулан гаргасан өнөөгийн бодлого, хөтөлбөрүүд нь хамтын хөдөлмөрийн үйл



ажиллагааны үр дүнг тодорхой хэмжээнд хязгаарлах юм. Малчдын зохион байгуулалтанд орох чадавхыг сайжруулах, малчдад зөвлөгөө өгч, техникийн туслалцаа үзүүлэх ажлыг орон нутгийн захиргаанд суулгаж өгөх нь бэлчээрийн доройтлыг сааруулах, хөдөөгийн амьжиргааны үндсийг дээшлүүлэх ганцхан арга гэж үзэж байна. Үүнийг хийх хамгийн сайн аргыг олох нь тогтвортой амьжиргааны асуудлын цөм нь болж байна.

Энэхүү судалгаа нь дээр дурдсан том судалгааны нэмэлт хэсэг нь болох юм. Энэ судалгаагаар Ногоон алт төслийн малчдыг нутаг дэвсгэрээр нь хэсгийн зохион байгуулалтанд оруулах арга нь дараах зүйлүүдэд хүргэх бололцоотой эсэхийг тодорхойлох зорилготой үүнд: (а) тогтвортой хамтын үйл ажиллагааны байгууллагуудыг байгуулах, (б) бэлчээрийн болон малын бүтээмжийг дээшлүүлэхэд эерэг нөлөө байгаа эсэх, (в) бэлчээрийн доройтлыг хянах, ингэснээрээ малчдын амьжиргаанд тогтвортой болоод ашиг тустай нөлөө үзүүлж чадах. Энэ зорилгод хүрэхийн тулд өөр хоорондоо ялгаатай

агро-экологийн бүсүүдээс зургаан чанарын нөхцөлт судалгааг нийтдээ 22 сумаас авсан.

Судалгааны үндсэн таамаглал нь *малчны бүлгийн байгууллагыг бий болгох нутаг дэвсгэрт үндэслэсэн арга нь малчны бүлгүүд дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд бэлчээрийн болон мал аж ахуйн тогтвортой менежментийг бий болгоно: (а) биеэ даасан буюу хараат бус, (б) орон нутгийн захиргаа дэмждэг, (в) өөрийн санаачилсан төслүүддээ техникийн болон санхүүгийн тусламж авах боломжтой.*

Малчдын байгууллагыг газар нутгаар нь зохион байгуулах аргачлал Монголд ердөө дөрөвхөн жил туршигдаж байгаа тул манай таамаглал дүгнэлт хийх хэмжээнд батлагдах эсвэл үгүйсгэгдэхгүй байх боломжтой. Үүний оронд тухайн байгууллагыг байгуулахад аль хэр хялбар болон хурдан болох, тэдгээр байгууллагын нэвтрүүлсэн үйл ажиллагааны эрчимжилт, хамрах хүрээ, амжилт болон тогтвортой байдлын нөхцөлүүд зэргийг судаллаа.



II. Монголд санал болгож буй нутаг дэвсгэрт тулгуурласан малчдын байгууллага

Ногоон алт төсөл анхандаа нийтлэг амьжиргааны асуудал, бэлчээрийн менежментийн сонирхлоороо нэгдсэн МБ-үүдийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлж байсан байна. Энэ нь бусад хандивлагчдын төслүүдийн хийж буй аргатай яг адилхан юм. Эдгээр сайн дурын байгууллага нь газар нутгийн хувьд тодорхой хил зааг гэж байхгүй бөгөөд тухайн нутаг дэвсгэрт байгаа бүх малчдыг оруулж чадаагүй байсан. Гэвч төдийлөн удалгүй улирлын нүүдлийг зохицуулах, нөөц бэлчээр хуваарилах, түүнийг ашиглах гэх мэт бэлчээрийн менежментийн чухал асуудлуудыг шийдэх чадваргүй болох нь харагдсан байна. Иймд Ногоон алт төсөл уламжлалаараа тухайн нутаг дэвсгэрт байдаг малчдыг бүгдийг нэгтгэсэн БАХ-ийн хэлбэр рүү шилжсэн байна.

Бэлчээр ашиглагчдын хэсгийн тогтолцоо

Олон жилийн уламжлалын дагуу нэг газар нутгийн бэлчээрийг ашигладаг малчид нийлж бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийг байгуулдаг. Энэ нь тухайн газар нутгийн малчдыг заавал хамруулан газар нутгийн хил заагийг бий болгож, сумын захиргаагаар баталгаажуулсан тогтолцоо юм. Тухайн БАХ-ийн газар нутагт байдаг бүх малчин гишүүн болох ёстой. Ингэснээрээ БАХ-ийн бэлчээрийн менежментийн чадавхад сөргөөр нөлөөлдөг гишүүн, гишүүн бусчуудын хоорондын зөрчилдөөнийг арилгадаг байна. БАХ нь нэгдэл биш, харин өөрсдийн нутаг дэвсгэрт явуулах үйл ажиллагааны БМТ-г хамтаараа хийх, хэрэгжүүлэх, хянах зорилго бүхий бие даасан байгууллага юм. БАХ-үүд орон нутгийн захиргааны дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд одоохондоо Ногоон алт төслөөс арга зүйн зөвлөгөө, хэсэгчилсэн санхүүжилтийн дэмжлэг аван ажиллаж байна. Малчид хамтын хөдөлмөр шаардсан бэлчээрийн менежментийн үйл ажиллагаануудыг хамтаараа хэрэгжүүлсээр бүр сүүлдээ өөрийнхөө бэлчээрийн даацад малынхаа тоог тохируулах чаддаг болох тэрхүү хамгийн хүнд ажлыг ч хамтаараа хийж чаддаг болно гэж Ногоон алт төсөл үзэж байна.

Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн холбоо (БАХХ)

Сумын төвшинд БАХ-үүд нийлж Бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн холбоо (БАХХ)-г байгуулдаг. Энэхүү БАХХ нь цөөхөн хэдэн ажилтантай бөгөөд БАХ-үүдийг арга зүйн зөвлөгөөгөөр хангах, Ногоон алт төсөл дууссаны дараа БАХ-үүдийн үйл ажиллагааг зохицуулан авч явах баталгаа болох ёстой. БАХХ нь БАХ-үүд сумын захиргаатай харилцах, цаг агаар муудсан үед БАХ-ийн газар нутгаас гарч нүүх гэх мэт БАХ-ийн эрх мэдлээс давсан асуудлуудыг зохицуулахад БАХ-үүдэд туслалцаа чухал үүрэг гүйцэтгэнэ. БАХХ-ууд аймаг болон улсын хэмжээнд холбоогоо байгуулан нэгдэж болно.

Орон нутгийн захиргаа, төв засгийн газрын үүрэг: БАХ-ийн тогтолцоо сайн ажиллахын тулд БАХ, БАХХ, орон нутгийн төрийн байгууллагууд, сумын төрийн болон нийгмийн үйлчилгээний байгууллагуудтай нягт уялдаатай хамтран ажиллах ёстой. Хэдийгээр БАХ-үүд өөрсдийн газар нутгийн

хил заагийг тодорхойлдог ч сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал үүнийг хүчин төгөлдөр болгож баталгаажуулна. Мөн БАХ-үүдийн БМТ-г сумын засаг дарга баталгаажуулна. Сумын засаг даргын тамгын газар тусгай хамгаалалттай газрын захиргаатай хамтран ажиллаж отрын газрыг зохицуулах үүрэг хүлээдэг байна. Цаашилбал, БАХ-үүд газрын даамал, мал аж ахуйн мэргэжилтэн гэх мэт ажилтнуудаар дамжуулж засаг даргын тамгын газраас үзүүлж буй төрийн үйлчилгээнүүдээс хүртдэг. Эцэст нь хэлэхэд сумын захиргаа бэлчээр ашиглах эрхийг хуваарилах бөгөөд ингэснээрээ тэрхүү эрх болон менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх эцсийн хариуцлагыг сумын захиргаа үүрдэг.

БАХ-ийн тогтолцооны урт хугацааны зорилго

Хууль эрх зүйн таатай орчин, орон нутгийн захиргааны дэмжлэг, мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын дэмжлэгтэй үйл ажиллагаа явуулдаг БАХ нь бэлчээрийн тогтвортой менежментийг алгуураар нэвтрүүлж, бэлчээрийн газар болон малын ашиг шимийг дээшлүүлнэ гэсэн таамаглалд БАХ-ийн тогтолцоо үндэслэгддэг. Нарийвчлан авч үзвэл БАХ-үүд нь:

- өөрийн бэлчээрийг ашиглах болон эзэмших эрхтэй;
- улирлын сэлгээ болон нүүдлийг зохицуулдаг, идэвхжүүлдэг;
- бэлчээрийн тогтвортой менежментийг бэхжүүлэхийн тулд арга зүйн болон хөрөнгө оруулалтын янз бүрийн аргуудыг хэрэглэдэг,
- сумын захиргаатай зөвшилцсөний үндсэн дээр отрын нутгийг бий болгож, сахин хамгаалдаг болох,
- хүйсийг тэгш байдлыг хангах, хөгжлийн үр шимийг ялгаваргүйгээр хуваарилдаг болох,
- зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг шийдэх,
- эдийн засгийн үйлдвэрлэлийн нэр төрлийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг хөгжүүлэх,



- шаардлагатай тохиолдолд бэлчээрийн даацд тохируулан малын тоог зохицуулах үйл ажиллагаануудыг явуулна.

БАХ болон БАХХ-ны амжилт, тогтвортой байдлын нөхцөлүүд

БМТ-г боловсруулж, хэрэгжүүлэх, эсвэл бэлчээр болон малын бүтээмж, ашиг шимийг дээшлүүлэхэд хамтын хөрөнгө оруулалт хийх гэх мэт ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэхийн тулд БАХ болон БАХХ-нд бүтэц, зохион байгуулалт, байгууллагын олон хүчин зүйлийн нөхцөл бүрдсэн байх ёстой. МБМХ-ны төсөл хэрэгжүүлсэн туршлагын талаар ажилтнуудтай нь хийсэн ярилцлага болон бусад судалгааны үр дүнгээс дараах үндсэн шалгууруудыг олж мэдсэн бөгөөд бид судалгаандаа эдгээр шалгуурын биелэлтийг үнэлсэн юм. Үүнд:

1. **Үүрэг:** БАХ өөртөө хамааралтай үүргүүдийг мэддэг, түүнийгээ зөв зохистой хэрэгжүүлэх чадавхтай байх ёстой
2. **Дүрэм, журам:** БАХ өөрийн гэсэн хуультай, дүрэм, журамтай байх ёстой
3. Гишүүн болон гишүүн бусчуудын хоорондын зөрчлийг арилгах үүднээс БАХ гишүүн болон гишүүн бусчуудын хоорондын **харилцааг** маш тодорхой болгосон байх
4. **Хэрэгжүүлэх:** Бэлчээрийн менежментийн талаар гаргасан хамтын шийдвэрүүдийг БАХ хэрэгжүүлж чаддаг байх
5. Байгууллагын удирдлагууд гишүүдийнхээ өмнө үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүний **хэрэгжилтийг хариуцдаг байх**
6. Байгууллагын удирдлагууд гишүүдийнхээ өмнө **санхүүгийн хариуцлага** хүлээдэг байх
7. **Манлайлал:** Шилдэг манлайлалтай байх бөгөөд удирдлагаа шинэчлэх ардчилсан механизмтай байх ёстой
8. **Чадавх:** Гишүүд болон удирдлагууд сургалтаар болон ажил дээрээ суралцах замаар чадавхиа дээшлүүлдэг байх
9. **Санхүүгийн тогтвортой байдал:** БАХ үйл ажиллагаагаа явуулахад санхүүгийн нөөц хэрэгтэй. БАХ өөрөө шийдэж, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны орлогоороо өөрийгөө санхүүжүүлж байх нь санхүүгийн тогтвортой байдлын үндэс болно. Мөн өөрийнхөө (хувь хүний болон бүлгийн) жижиг төслүүдийг санхүүжүүлж байхуйц эргэлтийн сан бий болгох нь маш чухал
10. **Удирдах төв байгууллага:** БАХ-үүдийн үйл ажиллагаа тогтвортой явж байхын тулд тэдгээрийг удирдах байнгын үйл ажиллагаатай удирдах төв байгууллага буюу БАХХ байх хэрэгтэй. БАХХ нь үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулж байхын тулд өөрийн ажлын байртай байх ёстой.
11. **Үйл ажиллагааны гарын авлага:** Энэхүү баримт бичигт БАХ болон БАХХ байгуулах аргачлал, тэдгээрийн үүрэг, төлөвлөлт, шийдвэр

гаргах үйл явц, санхүүжилт, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх механизм, засаг захиргаатай харилцах харилцаа, идэвхжүүлэгчид болон хандивлагчид, хариуцлагын механизм гэх мэтийг тоймлон оруулна. Энэ нь тодорхой хугацаанд шинэчлэгдэж байдаг амьд баримт бичиг байх ёстой

12. **Үр шимийг хуваарилах:** Малчдын байгууллагын бүх гишүүд байгууллагаасаа үр шим хүртэнэ. Үр шимийг хуваарилахад тэгш, шударга гэсэн энгийн зарчмууд үйлчилж байх ёстой. Эдгээр зарчмыг хууль болон дүрэм, журмууддаа тусгасан байна.
13. **Улс төрийн ар тал:** Малчдын байгууллагад төв болон орон нутгийн захиргаанаас хүчтэй ар тал, харилцаа холбоо байх хэрэгтэй
14. **Улс төрийн нөлөө:** Аймаг, орон нутгийн ИТХ-д малчдын байгууллагуудын төлөөлөл орсон байх гэх мэт

Бэлчээр ашиглагчдын хэсгийн тогтолцоонд гарах хүндрэлүүд

Нутгийн иргэдийн байгууллагад ургамлын динамикийн үзүүлэх нөлөө

Ногоон алт, НҮБХХ-ийн Бэлчээрийн тогтвортой менежмент төслүүдийн туршлагаас үзэхэд МБ-ийг орон нутгийн иргэдийн санаачлагаар хөгжүүлэх нь өндөр уул, ойт хээр, тал хээрийн бүсэд тохиромжтой байгаа нь харагдаж байна. Тэнцвэргүй бэлчээрийн тогтолцоотой цөлөрхөг хээрийн болон цөлийн бүстэй харьцуулахад эдгээр бүс нутагт ургамлын тэнцвэрт эсвэл тэнцвэрт-тэнцвэргүй тогтолцоо ноёрхож байна. Энгийнээр хэлэхэд бэлчээрийн ургамлын тэнцвэрт динамик нь жилээс жилд бэлчээрт байх ургамлын нөмрөгийг тогтмол барьж байдаг цаг уурын нөхцөлөөр тодорхойлогддог (дэлгэрэнгүйг хавсралт А1-ээс үз). Иймд ургамлын динамик нь нийгмийн байгууллагуудын хэв шинжид нөлөөлдөг бөгөөд цөлөрхөг хээрийн болон цөлийн бүсэд нилээд сөрөг нөлөө үзүүлж болох юм.

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн эрх зүйн нөхцөл

Өвөл, хаврын бэлчээрийг малчид эсвэл бүлгүүдэд ашиглуулж, эзэмшүүлж болох бололцоог одоогийн хууль, эрх зүйн актуудаар олгосон (Фернандез-Жименез нар, 2008). Бэлчээрийг хэн, ямар хугацаагаар ашиглах, эзэмших эрхийг хуваарилах эрх мэдэл нь орон нутгийн захиргаанд байдаг. Одоогоор БАХ-үүд нь бэлчээрийн менежментийг удирдан хийхэд гарах үүрэг, хариуцлагыг хүлээх хуулийн этгээд биш юм. Иймд БАХ-үүдэд үүргээ биелүүлээгүйн улмаас хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх боломжгүй тул үрдүнтэй БМТ боловсруулж, хэрэгжүүлэх боломж хомс байна. *Иймд БАХ-ийг хөгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүй, бүтэц, зохион байгуулалт, байгууллагын орчин хараахан бүрдээгүй гэж үзэж болно (мөн эх тайлангийн хууль эрх зүйн бүлгийг үз).*



III. Хамтын үйл ажиллагаа болон малчдын амьжиргаа

Монгол орны хэмжээнд мал аж ахуйн салбарын аль нэгэн асуудлаар ажилладаг олон төсөл байдаг бөгөөд тэдгээрийн ихэнх нь энэ судалгаанд хамрагдсан сумуудын наад зах нь нэг нэг суманд үйл ажиллагаагаа явуулдаг. Хүснэгт 1а-д үзүүлсэнчлэн Дэлхийн Банкны Тогтвортой амьжиргаа төсөл (ТАТ) хамгийн нийтлэг тархсан төсөл юм. 2008 оны байдлаар уг төсөл орон даяар хэрэгжиж байна. ТАТ-ийн дараа хамрах хүрээгээрээ Дэлхийн зөн (ДЗ), тэгээд Ногоон алт төсөл ордог ажээ. ЮНИСЕФ-ийн Нийгмийн үндсэн цогц үйлчилгээ (НҮЦҮ), НҮБХХ-ийн Цөлжилттэй тэмцэх газрын тогтвортой менежмент (ЦТГТМ) төслүүд хоёр бүсэд, Мэрси Кор (МК), Дэлхийн байгаль хамгаалах сан (ДБХС), НҮБХХ-ийн Алтай Соёны Эко-бүс, Жайка-гийн Газар тариалан-мал аж ахуй хосолсон систем, Баянгол сумын ЗДТГ-ын санаачлага, Нидерландийн засгийн газрын Хустайн байгалийн цогцолборт газар (ХБЦГ), ХААХОУС-ийн Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслүүд судалгаанд хамрагдсан бүс бүрт нэг нэг хэрэгжиж байна. НҮБХХ-ийн Бэлчээрийн тогтвортой менежмент төсөл 2003-2008 онд газар тариалан-мал аж ахуй хосолсон бүсэд хэрэгжиж дууссан байлаа. Хэдийгээр энэ төсөл хэрэгжиж дууссан ч уг төсөл бэлчээрийн болоод мал аж ахуйн менежментийн чиглэлээр олон зүйл хийсэн тул зарим асуудлыг оруулах үүднээс тус төслийн хэрэгжилтийн туршлагыг бас судаллаа. Төсөл тус бүрийн товч танилцуулга, хэрэгжилтийн аргыг гол төлөв орон нутгаас авч ирсэн мэдээлэлд үндэслэн доор өгүүлэв.

Хандивлагчдын төслүүд

Тогтвортой амьжиргаа төсөл

ТАТ дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй. (1) Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн удирдлага гэдэгт: бэлчээрийн менежмент, ашиглалтыг малчдын оролцоотойгоор сайжруулж, эрсдэлд бэлэн байх цогц стратегийг боловсруулан хэрэгжүүлэх замаар хөдөөгийн айл өрх, ялангуяа малчдын амьжиргааг дээшлүүлэх, байгаль, цаг агаарын бэрхшээлийг гарз хохирол багатай даван туулах чадавхийг нь бэхжүүлэх зорилготой, (2) олон нийтийн санаачлага гэдэг нь: олон нийтийн оролцоонд тулгуурласан хөрөнгө оруулалтын үр ашигтай, оролцоог хангасан, ил тод аргачлалыг бий болгож хөдөө орон нутагт орон даяар нэвтрүүлэх, (3) бичил санхүүгийн хөгжил гэдэг нь: хөдөөгийн болон санхүүгийн үйлчилгээ хязгаарлагдмал газруудад оршин сууж буй иргэдийг тогтвортой санхүүгийн үйлчилгээнд хамруулан улмаар хүрээг нь өргөтгөж, тэдэнд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах, (4) төслийн удирдлага чадавхийг бэхжүүлэх гэдэг нь: улсын хэмжээнд бүх төслийн үйл ажиллагааны хэрэгжилт, удирдлагыг цаг тухайд нь үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх чадавхыг суулгах.

Энэ төсөл бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн удирдлага гэсэн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгээрээ дамжуулан бэлчээрийн менежмент, мал аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлж ажилладаг. Энэ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд орон нутгийн захиргааны чадавхыг дээшлүүлэх, бэлчээрийн газрын зураглал хийх, багийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд үндэслэн сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө хийхэд

дэмжлэг үзүүлэх гэх мэт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилладаг байна. Төслийн хүрээнд сум болон багийн хүрээнд нутаг дэвсгэрт тулгуурласан БАХ байгуулдаггүй. Иймд бэлчээрийн менежментийн санаачлагуудыг сумын төвшинд газар, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, сум болон багийн удирдлага, багийн иргэдийн нийтийн хурлаас гаргаж ирдэг байна. Орон нутгийн санаачлан хийдэг БМТ-нөөс гадна бэлчээр болон малын ашиг шимийг сайжруулах, орлого нэмэгдүүлэх чиглэлийн сайн дурын малчны бүлгүүд байгуулагдахад нь ТАТ идэвхжүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Энэ төсөл бэлчээр хашаалах, хадлан, тэжээл бэлтгэх, усны далан, тэжээлийн агуулах барих, тэжээлийн нөөц бий болгох, булгийн эх хаших, худаг гаргах, засварлах гэх мэтийн ажлыг санхүүжүүлнэ.

ТАТ төсөлд хамрагдах сумуудыг: бэлчээрийн эрсдэлийн менежментийн загвар сум, төслийн энгийн сум гэсэн хоёр янзаар сонгодог. Цөөн сум, ойролцоогоор нэг аймгаас нэгээс хоёр сум загвар сумаар сонгогддог бол бусад сумууд нь төсөл хэрэгжүүлж буй энгийн сум болдог байна. Загвар суманд дээр дурдсан бараг бүх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бол энгийн суманд орон нутгийн санаачлагад үндэслэн дэмжлэг үзүүлнэ.

Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэгч үндсэн түншээр Бодлого судлалын төв (БСТ) ажилладаг. Хоёр төрлийн зээл (МБ, хоршоодод олгох зээл, аж ахуйн тоног төхөөрөмжийн зээл) болон буцалтгүй тусламжууд олгодог. Зээлийн шалгуур нилээд хатуу тул маш цөөн МБ-үүд зээлийн болзол хангадаг юм байна. Зээл хүсэгч нь хуулийн этгээд байх ёстой гэдэг нь шалгууруудын нэг үзүүлэлт юм. ТАТ яагаад малчдыг МБ болон ТББ байгууллага



болоход нь идэвхжүүлдэг вэ? гэвэл: (1) сайн зохион байгуулагдсан малчны байгууллага хандивлагчдаас дэмжлэг хялбархан авдаг, (2) ТАТ-ийн зээлийн нөхцөлийг хангах бололцоотой болдог учраас тэгж идэвхжүүлдэг байна.

Багийн хурал дэмжсэн төслийг буцалтгүй тусламжаар санхүүжүүлдэг бөгөөд төсөл нийт хөрөнгө оруулалтын 90 хувийг, төсөлд хамрагдагчид 10 хувийг тус тус төлнө.

Ногоон алт төсөл

Ногоон алт төсөл үйл ажиллагаагаа 2004 онд эхэлсэн. Гэвч бүс бүрт өөр өөр онд эхэлсэн байдаг. Жишээ нь, өндөр уулын болон ойт хээрийн бүсэд 2005 онд эхэлсэн байхад тал хээрийн төвийн бүсэд 2007 онд эхэлжээ. Ногоон алт төсөл нь сумын бүх малчдыг БАХ-ийн гишүүн болгодог бусад хандивлагчдаас ялгаатай. Энэ нь нутаг дэвсгэрт тулгуурласан мал аж ахуйн болон бэлчээрийн менежментийн аргыг нэвтрүүлэх бололцоо олгодог бол бусад төсөл өөрсдөө нэгдэн малчны бүлэг болох сонирхолтой цөөн малчдыг сонгон авч ажилладаг. Ингэснээр бусад төсөлд тухайн нутаг дэвсгэр дээр байгаа бүх бэлчээр ашиглагчид орж чаддаггүй болохоор тэдгээр төслүүд орон нутгийн засаг захиргаанд ихээхэн найдах хэрэгтэй болдог. Ногоон алт төсөл хэрэгждэг сум бүрт БАХ-үүдийн бэлчээрийн болон мал аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх бүх үйл ажиллагааг дэмжих зорилготой ТББ (БАХХ) байгуулагдан ажиллаж байна. Энэ утгаараа тус төсөл сум бүрт малчдыг дэмжигч байгууллага ажиллуулж байна гэсэн үг.

БАХ-үүдийн ахлагч нар сумын ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн болно. Бүх малчид газар нутгийнхаа харъяаллаар өөр өөрийн БАХ-ийн гишүүн болдог. Төрийн оролцоо тусламжийг Бэлчээрийн хамтын менежментийн хороогоор дамжуулан хийдэг. Энэ хороонд орон нутгийн захиргааны төлөөлөгчид, ТББ-ын төлөөлөгчид, БАХ-үүдийн ахлагч нарын төлөөлөл ордог. Ногоон алт төсөл нь бэлчээрийн доройтол багатай, цөөн малтай тал хээрийн зүүн бүсээс бусад таван бүсэд ажилладаг.

Цөлжилттэй тэмцэх газрын тогтвортой менежмент төсөл

НҮБХХ-ийн Цөлжилттэй тэмцэх газрын тогтвортой менежмент төсөл (ЦТГТМ) 2008 оны эцсээр үйл ажиллагаагаа тал хээрийн болон цөлөрхөг хээрийн зарим сумуудаар хэрэгжүүлж эхэлсэн. Тус төслийн ерөнхий зорилго нь ядуурлыг бууруулахад үндсэн түлхүүр болсон экосистемийг хамгаалах, нөхөн сэргээхийн тулд газрын доройтол, цөлжилттэй тэмцэх явдал юм. Төслийн нэг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бэлчээр, усны нөөцийг байгалийн нөөцийн нэгдсэн менежментийн хүрээнд орон нутгийн иргэдээр дамжуулан удирдах үйл ажиллагааг явуулдаг. НҮБХХ-ийн Бэлчээрийн тогтвортой менежмент төслийн аргачлал энэ төсөл дээр хэрэглэгдэж байна. Энэ төслийн хүрээнд сонгогдсон сумуудад МБ-үүд байгуулагдаж байна.

Бэлчээрийн тогтвортой менежмент төсөл

НҮБХХ-ийн Бэлчээрийн тогтвортой менежмент (БТМ) төсөл 2003-2007 онд хэд хэдэн аймгийн нилээд хэдэн суманд хэрэгжиж дууссан. Энэ судалгаанд тус төсөл хэрэгжсэн газар тариалан-мал аж ахуй хосолсон ойт хээрийн бүсийн сумууд хамрагдсан. Тус төслийн зорилго нь малчны бүлгээр дамжуулан бэлчээрийн болоод мал аж ахуйн менежментийг сайжруулах явдал байжээ. Баянгол сумын малчин өрхийн талаас илүү хувь нь энэ төсөлд хамрагдсан байгаа. Эхлээд зургаан МБ байгуулан ажиллаж байснаа дараа нь хоёрыг нэмж нийтдээ найман малчны бүлэгтэй ажиллаж байсан байна. Энэ үе шатанд баг тус бүрээс тодорхой тооны малчид төсөлд хамрагдаж байсан боловч нэг газар нутгийн МБ-ийн гишүүн болон гишүүн бус малчдын хоорондын бэлчээр ашиглалтын зөрчлийн улмаас нэг багийн бүх малчдыг сонгон авч төслийн хэрэгжилт үргэлжлүүлэх болсон байна. Төсөл 2008 оны эхээр хэрэгжиж дууссанаас хойш ихэнх МБ-үүд идэвхгүй болж, тэдний зарим нь байгаль хамгаалах нөхөрлөлүүд болон хувирчээ. Төрөөс дэмжлэг өгдөг тул ялангуяа ой хамгаалах нөхөрлөлүүд болсон байна.

Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр

ХААХОУС-ийн Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр (ХЯБХ) манай судалгаанд хамрагдсан бүсүүдээс зөвхөн ойт хээрийн бүсэд хэрэгжиж байна. Хөтөлбөрийн гол зорилго нь хөдөөгийн малчид, тариаланчид, хөдөөгийн эмзэг бүлгийн иргэдийн үйлдвэрлэл эрхлэх, бүтээх чадавхийг дээшлүүлэхийн зэрэгцээ боловсрол, эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нь бүрдүүлэх замаар тэдний орлогыг нэмэгдүүлэх, ядуурлаас гаргах явдал юм. Хөтөлбөр таван бүрэлдэхүүн хэсэгтэй ажилладаг үүнд: (I) мал аж ахуйн үйлдвэрлэл, байгалийн нөөцийн менежмент, (II) нийгмийн хөгжил, (III) хөтөлбөрийн менежмент, (IV) эдийн засгийн бусад үйл ажиллагаа, (V) хөдөөгийн санхүүгийн үйлчилгээ. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд малчдын бүлгийг малчдын байгалийн гамшиг, бэрхшээлийг хамтын хүчээр даван туулах, хөдөлмөрөө хоршин орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжийг нь бүрдүүлэх, ядуу малчдыг аливаа үйл ажиллагаанд татан оролцуулах, удирдан чиглүүлэх, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамруулах зорилгоор ажилладаг. 2003 онд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш төсөлд хамрагдсан аймгуудын хэмжээнд нийт 1662 МБ байгуулагджээ.

Дэлхийн Зөн

Тал хээрийн зүүн бүсийн зарим нутагт Дэлхийн зөн (ДЗ)-ийн Малчдын амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгждэг. Тус төслийн үндсэн зорилго нь байгаль орчныг сэргээхийн тулд хөдөөгийн ядуурлыг бууруулах явдал юм. Энэ хөтөлбөрөөр малчдад дараах чиглэлүүдээр дэмжлэг үзүүлдэг: (I) газар тариалангийн чиглэлээр олон настын үр, тоног төхөөрөмж, (II) мал аж ахуйн чиглэлээр малын чанарыг сайжруулах, (III) жижиг бизнесийг дэмжих



чиглэлээр тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлдэг байна. Мөн эдгээртэй холбогдох бүх сургалтуудыг зохион байгуулдаг байна. Төслийн хүрээнд сайн дурын МБ-үүдийг байгуулан, дэмжиж ажилладаг. Төсөлд хамрагдсан МБ-үүд төслийн хүрээнд явуулсан үйл ажиллагааны орлогоороо эргэлтийн сан байгуулдаг.

Хустайн байгалийн цогцолборт газар

Тахийг Монгол нутагт нь эргүүлэн нутагшуулах зорилгоор 1996 оноос хойш тал хээрийн төвийн бүсэд орших Төв аймгийн Алтанбулаг сумын газар нутаг дээр Хустайн байгалийн цогцолборт газар (ХБЦГ) төслийг хэрэгжүүлж байна. Энэ төсөл Хустайн нурууны орчмоор байдаг 3 сумын малчид иргэдийн байгаль хамгаалах үйлсэд татан оролцуулж нийгэм эдийн засгийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлдэг. Нэгдүгээрт, сумдын иргэдийн нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор буцалтгүй тусламж өгдөг. Үүний хүрээнд 195.0 сая төгрөгийг Алтанбулаг сумын дунд сургууль, цэцэрлэгийг засах, эмнэлэгт тусалцаа үзүүлэхэд зарцуулсан байна. Хоёрдугаарт, ХБЦГ-ын Орчны бүсийн зөвлөл арилжааны зээлийг цогцолборт газар орчимд нутагладаг иргэдэд жилийн 0.5 хувийн хүүтэй, хоёр жилийн хугацаатай олгодог. Нэг хүртэл сая төгрөгийн зээлийг сумын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор Сумын орчны бүсийн зөвлөл өгдөг байна. Гуравдугаарт, орчны бүсийн малчдад тэдний хамтын хөдөлмөрийг дэмжих зорилгоор бэлчээр сайжруулах, орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаануудад нь буцалтгүй тусламж олгодог.

Алтай Соёны Эко-бүс төсөл

НҮБХХ-ийн Алтай Соёны Эко-бүс төсөл (Монголын Алтай Соёны экобүсийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотой хамгаалах төсөл гэсэн нэртэй) өндөр уулын бүсийн Улаан хус суманд 2008 оноос хойш хэрэгжиж байна. Зэрлэг амьтдыг хамгаалах, гадаадын анчид, жуулчдад хөтөч хийх чиглэлээр төслийн хүрээнд хоёр МБ ажиллаж байна. Эдгээр МБ-үүд Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай ан хийх зөвшөөрлийн гэрээ байгуулж ангаас орсон орлогын тодорхой хувийг сумын захиргаагаар дамжуулж авдаг.

Дэлхийн байгаль хамгаалах сан

Дэлхийн байгаль хамгаалах сан (ДБХС)-гийн (Хөдөөгийн хөгжил ба байгаль орчны боловсрол Монголд төсөл) төсөл байгаль орчныг хамгаалах зорилгоор өндөр уулын бүсийн Дөргөн суманд хэрэгждэг. Уг төслийн санаа нь хэрэв хөдөөгийн иргэд хүрэлцээтэй орлоготой бол байгаль орчныг сүйтгэхгүй гэж үздэгт оршдог. Энэ зорилгоор ДБХС тус суманд хоёр МБ-ийг дэмжин ажиллаж байна. Тэдний нэг нь төсөл эхлэхээс өмнө өөрсдөө орлого нэмэгдүүлэх чиглэлээр байгуулагдсан байсан байна. Эдгээр МБ-үүд малын ноос, хөөвөр, арьс ширээр гэр ахуйн хэрэглэл хийдэг. Мөн ингэний сүүгээр төрөл бүрийн цагаан идээ хийж зах зээлд нийлүүлж байна.

Газар тариалан-мал аж ахуй хосолсон загвар аж ахуй

ЖАЙКА-гийн \Японы хамтын ажиллагааны нийгэмлэг\ санхүүжилтээр Газар тариалан-мал аж ахуй хосолсон эрчимжсэн аж ахуйн загвар төсөл газар тариалан-мал аж ахуй хосолсон ойт хээрийн бүсийн сумуудад хэрэгждэг. Тус төсөл нь үйл ажиллагаагаа 2006 оны 6 дугаар сард эхэлсэн бөгөөд 2009 оны 12 дугаар сард дуусгавар болсон. Хосолсон аж ахуй байгуулахын зорилго нь мал аж ахуйн салбарт тусах байгалийн эрсдэлийг бууруулах, фермерүүдийн улирлын чанартай орлогын хэлбэлзлийг арилгахад чиглэгдэж байгаа юм. Баянгол суманд уг төсөл нэг хоршоо, хоёр өрхийн аж ахуй гэсэн гурван субъектийг төсөлд хамруулсан байна. Энэ гурав гурвуулаа мал аж ахуйтай, хүнсний ногоо тариалдаг байна. Мандал суманд мөн нэг хоршоо, нэг өрхийн аж ахуй, 10 малчин өрхөөс бүрдсэн нэг МБ гэсэн гурван субьекттэй ажилладаг. Гэхдээ эдгээр малчид нь заавал хөдөөгийн малчин байх албагүй байдаг ажээ. Эдгээр нь бүгд мал, хүнсний ногоо голлосон газар тариалантай. Төсөлд хамрагдагсдын чадавхийг дээшлүүлэх зорилгоор төслөөс холбогдох сургалтуудыг зохион байгуулдаг.

Орон нутгийн захиргааны санаачлага

2009 оны 2 дугаар сард болсон Сэлэнгэ аймгийн зөвлөлгөөн дээр тус бүсийг зөвхөн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн бүс болгон хөгжүүлэх шийдвэр гарсан. Энэ нь тус аймаг Монгол Улсын хамгийн том газар тариалангийн бүс төдийгүй Эрдэнэт, Дархан, Улаанбаатар гэсэн томоохон зах зээлтэй ойр, дэд бүтэц сайтай гэсэн давуу талууд дээр үндэслэгдэн гарч ирсэн юм. Энэхүү аймгийн зөвлөгөөний дараа газар тариалан-мал аж ахуйн гол бүс Баянгол сумын захиргаа малын тоогоо хянах санаачлага гаргасан байна. Одоо байгаа 142600 толгой малыг 60000 хүртэл бууруулж, сүргийн бүтцийн нормыг сайтар мөрдөх чиглэл гаргасан. Энэхүү санаачлагаар сүргийн бүтцэд адуу 5%, үхэр 45%, хонь 35%, ямаа 15% байхаар заасан байна. Энэ зорилгод хүрэхийн тулд малын тоог жил бүр 16.5-26.4 мянган толгойгоор бууруулах юм. Мал борлуулсны орлогоос 1.2-2.0 тэрбум төгрөг орж ирэх бөгөөд үүний хагасыг нь сүүний чиглэлийн үнээ худалдан авахад зарцуулна гэж тооцжээ. Үүний үр дүнд үхрийн тоо 2100-4200 болж өснө. Хэдийгээр энэ төлөвлөгөөг эсэргүүцэх явдал байгаа ч ихэнх малчид малын тоог бууруулж, чанар, эрүүл мэндэд нь хөрөнгө оруулалт хийхийн ач холбогдлыг ойлгож байгаа ажээ.

Гишүүнчлэлтэй бусад байгууллагууд

Бүх суманд байдаг бусад хамтын байгууллагуудад ахмадын, эмэгтэйчүүдийн, залуучуудын гэх мэт тухайн орон нутгийн тодорхой бүлгийг багтаасан, зарим үед нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулдаг өөрийн гэсэн дүрэм, журамтай, бие даасан байгууллагууд орж байна. Мөн янз бүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жижиг хэмжээний, хязгаарлагдмал чадавхтай ТББ-ууд ч орон нутаг



байна. Хас банкны франчайзын үйлчилгээгээр байгуулагдсан хадгаламж, зээлийн хоршоод (ХЗХ) ихэнх суманд байлаа. Энэ нь Ногоон алт төслийн хүрээнд байгуулагддаг малчдын эргэлтийн сангаас өөр юм. Сумын ХЗХ-ны гишүүнчлэл тухайн сумын хүн бүрт нээлттэй байдаг. Элсэн орохдоо 50000 төгрөгний гишүүнчлэлийн төлбөр төлдөг ажээ.

Малчдын бүлгүүд болон Бэлчээр ашиглагчдын хэсгүүд

Бүх төслүүд хэрэгжилтийнхээ хүрээнд МБ байгуулан ажилладаг. Гэхдээ МБ-ийн үүрэг, зорилго хандивлагч бүрт өөр өөр байдаг. Дэлхийн банкны ТАТ-ийн хувьд МБ гэдэг нь тус төслийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааны шаардлагыг хангасан малчдын бүлэг юм. НҮБХХ-ийн Алтай Саян, ДБХС-ийн төслүүдийн хувьд өөр эх үүсвэрээс орлогоо нэмэгдүүлж байгаа байгаль хамгаалах зориулалт бүхий малчин өрхүүдийн нэгдэл. Ногоон алтын хувьд эдийн засгийн үйл ажиллагаагаараа нэгдсэн малчдын бүлэг байх бөгөөд тэд бүгд өөрийн бэлчээр ашиглагчдын хэсгийн гишүүн байх ёстой.

Ногоон алт төслийн бэлчээр ашиглагчдын хэсэг, малчны бүлэг хоёр нь хоорондоо ялгаатай. Бэлчээр ашиглагчдын хэсэг гэдэг нь БМТ-г хамтаараа хийх, хамтаараа хэрэгжүүлэх, хүчин төгөлдөр болгох бололцоог малчдад бий болгох зорилготой байхад малчны бүлэг гэдэг нь бэлчээр ашиглагчдын хэсгүүдийн дотор байдаг эдийн засгийн сонирхлоороо нэгдсэн малчдын жижиг бүлгүүд юм. Эхнийх буюу бэлчээр ашиглагчдын хэсэгт малчин заавал гишүүн болох ёстой бол дараагийнх буюу малчны бүлэгт малчид сайн дураараа нэгддэг. БАХ гэдэг бол олон

малчнаас бүрдсэн том бүлэг бөгөөд нэг бэлчээрийг эрх тэгш хувааж ашиглахаас өөр давхар сонирхол, нийгмийн холбоо харилцаатай байх шаардлагагүй. Малчны бүлэг гэдэг нь цэвэр сайн дураараа нэгдсэн малчдын нэгдэл бөгөөд БАХ дотроо байрладаг боловч өөр өөр БАХ-ийн гишүүд нэгдэж нэг МБ болж болдог. Энэ нь БАХ-ийн БМТ-ний нэг хэсгийг хамтран хэрэгжүүлж, эдийн засгийн үйл ажиллагаагаа хамтран явуулснаар БАХ-ийн доторх олон гишүүдийн дотор нийгмийн харилцааг бий болгож болно. Ногоон алт төсөл хэрэгжиж буй сум бүрт БАХ, МБ хоёроос гадна бэлчээрийн хамтын менежментийн хороо, Монголын бэлчээрийн менежментийн холбооны гишүүн хэрэгжүүлэгч ТББ (БАХХ), малчдын эргэлтийн сан гэж байдаг. Энэхүү эргэлтийн сангийн нэг хэсгийг малчид, нөгөө хэсгийг нь Ногоон алт төслөөс хандивлаж бий болгодог. Цэнгэл суманд эргэлтийн сангаараа малчдын хадгаламж зээлийн хоршоо байгуулаад тэндээсээ сард 2 хувийн хүүтэй, 6 сар хүртэлх хугацааны зээл олгож байна. Цэнгэл сумтай яг адил аргаар Дуут сумын малчид үйл ажиллагаагаа явуулж байна. Дуут сум газар нутгаа есөн БАХ-т хуваасан байна. МБМХ-ны гишүүн “идэвхжүүлэгч ТББ” нь Ногоон алтын сумуудад чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ ТББ нь хоёроос гурван байнгын ажилтантай. Тэнд орон нутгаас шалгаруулан авсан бэлчээрийн асуудал хариуцсан нэг хүн заавал байдаг. Энэ ТББ нь БАХХ-ны байнгын үйл ажиллагааг явуулдаг. Мөн Ногоон алтаас олгож буй санхүүгийн хуваарилалтыг удирдан зарцуулдаг. Үүнээс гадна тус ТББ нь өөр эх үүсвэрүүдээс орлогоо нэмэгдүүлж болно. Жишээ нь, өндөр уулын бүсийн Дуут сумын ТББ-ынхан аймгийн захиргаанаасаа тодорхой төсөл хэрэгжүүлэхээр тусламж авч чадсан байлаа.



IV. Судалгааны арга зүй

Нөхцөл сонгох

Энэүү судалгааг дараах агро-экологийн бүсүүдийн 22 суманд хийж гүйцэтгэлээ. Үүнд: өндөр уулын, ойт хээрийн, тал хээрийн (нэг нь малын нягтрал ихтэй тал хээрийн төвийн бүс, нөгөө нь малын нягтрал багатай тал хээрийн зүүн бүс), цөлөрхөг хээрийн бүс. Мөн газар тариалан ихээр эрхэлдэг, газар-тариалан мал аж ахуй хосолсон, газрын үржил шим нь амархан сайжирч болох ойт хээрийн нэг бүсийг сонгон авсан болно (сонгогдсон сумуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт А II-оос үз).

Судалгаанд хамрагдсан сумуудад төсөл хэрэгжүүлж байгаа дөрвөн хандивлагчдын төслүүдийн арга туршлагыг судалсан болно. Үүнд: (I) МБМХ-ны хэрэгжүүлж буй Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт төсөл, (II) Дэлхийн банкны тогтвортой амьжиргаа төсөл, (III) НҮБХХ-ийн Бэлчээрийн тогтвортой менежмент төсөл, (IV) ХААХОУС-ийн Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл. Эдгээрээс гадна Сэлэнгэ аймгийн Баянгол сумын боловсруулсан Бэлчээр, газар тариалангийн менежментийн санаачлагыг Баянгол сумтай төстэй боловч санаа санаачлага хараахан явагдаагүй сумтай харьцуулсан болно. Өнгөрсөн хоёр жилийн турш Ногоон алт төсөл агро-экологийн дөрвөн бүсийн зургаан аймагт нийгэм-эдийн засаг, социологийн судалгааг хийсэн. Судалгаанд хамрагдсан аймаг бүрт МБМХ-ны туршилтын төсөл хэрэгжүүлж буй сум, төсөл хэрэгжээгүй төстэй сумуудыг сонгон авсан байлаа. Эдгээр судалгааны үр дүнг баталгаажуулах, харьцуулах үүднээс нэг агро-экологийн бүсээс бусад бүсэд Ногоон алтын судалгаанд хамрагдсан сумуудыг сонгосон болно. Төсөлд хамрагдаагүй сумыг сонгохдоо аль болох Ногоон алт төслийн сумуудтай бэлчээрийн даац, экологи, газар зүйн байршил, бусад талаараа төстэй сумуудыг сонгосон юм.

БАХ-ийн тогтолцоо хараахан үүсээгүй байгаа газруудад бид БАХ-ийн тогтолцоонд орж болох зохион байгуулалтын ямар хэлбэрүүд үүсээд байна, эсвэл үүсэн байгуулагдсанаасаа хойш амжилттай явж байгаа малчдын тогтмолжсон хурал, уулзалт, БМ-үүд, ТББ-ууд, эргэлтийн сан гэх мэт тогтолцоонууд байна уу гэдгийг олж мэдэхийг зорилго. Сайн дурын байгууллагууд үүссэн эсэхийг хайхаас гадна малчид болоод орон нутгийн удирдлагууд БАХ-ийг аль хэр сайн мэддэгийг үнэлэх, тухайн орон нутагт БАХ-ийн тогтолцоог хөгжүүлэх бодит эрэлт байгаа эсэхийг тандахыг оролдов. Цаашилбал, БАХ-үүд ирээдүйн зорилгодоо хүрэхэд зайлшгүй хийгдэх ажлууд дотроос зарим ажлыг нь бусад байгууллага гүйцэтгэж байгааг олж мэдэхэд чиглэгдлээ.

Ярилцлагын арга, тоон мэдээллийг шинжлэх

Сум бүр дээр урьдчилан бэлтгэсэн санал асуулгыг нээлттэй ярилцлагын аргаар авлаа. Үүнд сумын удирдлагууд, суман дээрх олон нийтийн байгууллагууд, малчдын байгууллагууд, малчдаас ярилцлага авсан болно. Бүлэг хүмүүсийг цуглуулж ярилцлага авах боломжгүй үед айлаар орж ярилцлага авч байсан. Судалгааны хугацаа бага байсан тул судалгаанд хамрагдах айлуудыг таамгаар түүвэрлэн авахаасаа илүү өөрсдөө сонгон очиж байлаа. Ерөнхийдөө бол судалгаанд хамрагдсан байгууллага, удирдлагуудаас бүлгийн ярилцлага авч байсан. Хамтын үйл ажиллагааны талаар судалгаа авахад бүлгийн ярилцлага хамгийн зөв сонголт байдаг бөгөөд мэдээлэл аль болох үнэн бодит, бүрэн олддог давуу талтай байдаг. Гэхдээ бүлгийн ярилцлага авах боломжгүй үед хувь хүмүүсээс ярилцлагуудыг авсан.

Ярилцлагаар дараах мэдээллийг авахыг зорилго. Үүнд:

1. МБ болон БАХ-ийн үйл ажиллагаа

- БАХ-үүд малчдынхаа хамт нэн тэргүүнд хийх ёстой чухал ямар ажлууд байсан/байгаа вэ?
- Эдгээр ажил нэн тэргүүнд хийгдэж чадсан уу, хандивлагч төслийн тусламжтайгаар хийгдсэн үү, эдгээр ажлыг та нар өөрсдөө санаачилсан уу?
- Хаана, ямар цар хүрээнд эдгээр ажлыг хийсэн бэ?
- Аль хэр сайн хэрэгжсэн бэ?
- Тус үйл ажиллагаанаас хэн үр шим хүртсэн бэ?
- Хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд чинь аль хэр төвөгтэй байсан бэ?
- Ямар ямар хүндрэл тулгарч байсан бэ?

2. Тогтвортой байдлын шалгууруудыг ойлгож буй хэр хэмжээ

- Бүлэг бий болгох ажил эхний санаачилгаар хийгдсэн үү, Ногоон алт, орон нутгийн захиргаа, идэвхжүүлэгч ТББ-ын тусламжтай хийгдсэн үү, эсвэл малчид өөрсдөө санаачлан хийсэн үү?
- Хаана, ямар цар хүрээнд эдгээр ажлыг хийсэн бэ?
- Аль хэр сайн хэрэгжсэн бэ?
- Тогтвортой байдлыг хангах асуудлууд дээр бүлгийн гишүүд аль хэр өргөн оролцдог вэ?
- Ямар ямар хүндрэл гарч байсан бэ?

Үндсэн судлаач ярилцлагыг гурван бүсэд, туслах



судлаач хоёр бүсээс ярилцлага авсан болно. Ярилцлага авч буй хүн хариултыг урьдчилан бэлтгэсэн санал асуулгад буулгах нэг туслахтай хамт ажилласан. Үүнийг дараа нь судалгаа авсан хоёр хүн хамтдаа сууж шалгаад, эцсийн болгож байлаа. Сум бүрээс авч ирсэн мэдээллийг шинжилгээний есөн хүснэгтэнд нэгтгэн буулгаж шинжилгээнд бэлтгэж байв. Хүснэгтэнд оруулсан тоо, оноонууд нь тухайн сумын дундаж байх бөгөөд зарим тохиолдолд дундажлах боломжгүй бол шууд анхны хэлбэрээрээ орсон болно. Бүс бүрт эдгээр мэдээлэлд үндэслэсэн тайлан бэлтгэв. Ингэхдээ төсөл бүрийн үйл ажиллагааны онцлог, төсөлтэй сум, төсөлгүй сумыг харьцуулахад анхаарсан болно.

Энэ тайланд бүс бүрийн тайланг нэгтгэн оруулж, өөр өөр агро-экологийн бүсүүд, хандивлагчдын аргуудыг харьцууллаа.

Судалгаанд явахад бэлтгэх, ярилцлагын хуваарь гаргах

Судалгааны ажлаар хөдөө явахын өмнө судалгааны баг очих сумуудынхаа талаар нийт нутаг дэвсгэр, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ, малын тоо, экологи, цаг уурын нөхцөлүүдийн талаар мэдээлэл

цуглуулсан юм. Харин сумын төвшин дэх хур тундасны мэдээллийн олдоц муу байсан тул энэ тоог судалгаанд оруулсангүй. Мөн бусад хандивлагчдын бэлчээрийн менежментийн төсөлтэй холбогдох баримт, материалуудыг цуглуулсан. Судалгааг сум бүрт яг ижилхэн арга барилаар явууллаа. Нэг суманд гурван өдрийг зарцуулж байв. Эхний өдөр сумын удирдлагууд, бусад төслийн зохицуулагч нартай сумын ерөнхий байдал, бэлчээрийн нөхцөл, цаг агаарын байдал, хэрэгжиж буй төслүүд, улирлын сэлгээ болон сум хоорондын нүүдлийг хэрхэн зохицуулж байгаа талаар ярилцаж байлаа. Хоёр дахь өдөр нь ярилцлагыг багийн төвшинд хийж байлаа. Үүнд багийн дарга, зарим БАХ-ийн ахлагч, МБ-ийн гишүүд, ахлагч, харьцангуй чинээлэг, ядуу, ганц бие өрх толгойлсон малчин өрхүүдээс судалгааг авч байсан. Энд гол төлөв явуулж буй мал аж ахуй, бэлчээрийн менежментийн үйл ажиллагаанууд, орон нутгийн иргэдийн бэлчээрийн менежментийн байгууллагуудын тогтвортой байдлын талаар асууж байв. Сүүлчийн өдөр нь сумын төвдөө эргэн ирж орон нутгийн захиргаа, бусад төрийн байгууллагын удирдлагууд, БАХ болон МБ-ийн төлөөллүүдийг цуглуулан олж мэдсэн зүйлсээ асуугаад, тодруулах зүйлсээ тодруулаад судалгааг өндөрлөж байлаа.



V. Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнг долоон хэсэгт хуваан гаргалаа. Энэ долоон хэсэг нь малчны байгууллагууд болон бүс бүрийг харьцуулсан шинжилгээний хүснэгтүүдэд үндэслэгдэн бичигдсэн болно. Харин эдгээр шинжилгээний хүснэгтүүдийг бүс бүрийн тайланг бичихэд ашигласан хүснэгтүүдээс нэгтгэн гаргаж авсан юм. Илүү нарийвчилсан мэдээллийг уншигч та бүс тус бүрийн тайлангаас авч болно.

Судалгаанд хамрагдсан бүсүүдийн онцлог

Хүснэгт 1а, 1б-д бүс бүрийн шинж чанар, тэнд үйл ажиллагаа явуулдаг төслүүд, ярилцлага авахын өмнөх жилийн (2008-2009) өвөл, хаврын цаг агаарын байдал, бэлчээрийн доройтлын талаар малчид болон бусад талуудын саналыг нэгтгэн харууллаа.

Газар зүй, цаг уур

Монгол орны баруун хэсэг буюу өндөр уулын бүсийн судалгаанд хамрагдсан сумуудын төвүүд далайн төвшнөөс улсын дундаж болох 1500 метрээс дээш өргөгдсөн байна. Газар нутаг нь хуурай, чулуурхаг хөрстэй, жилийн дөрвөн улиралд агаарын температур сэрүүвтэр байдаг. Ургамлын нөмрөг маш сийрэг. Бид тэжээлийн хомсдол хамгийн их үүсдэг хаврын улиралд очсон. Газрын байдлыг хараад бод мал энд юу идэж, яаж онд ордог байна аа гэсэн сэтгэгдэл төрж байлаа. Монголын бусад хэсэгтэй харьцуулахад 2008 оны зун, намар энд нилээд хуурай байсан байна. Мал тарга хүч муутай байснаас гадна бэлчээрийн гарц тааруу байсан тул өвөл, хаврын бэлчээр маш муу байлаа. Тэжээлийн хомсдол, бэлчээр муугаас болж өвөл, хавар маш олон мал хорогдсон ажээ. Зарим суманд хонь, ямааны төлийн 85 хувь нь хорогдсон мэдээ байв. Зарим нутагт хүмүүс тэр жилийг хар зудын жил хэмээн нэрлэж байлаа. Ерөнхий газрын тогтоц нь хад асархаг өндөр уулстай тул малчид чөлөөтэй нүүж, алсын ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах боломжоор хомс байдаг юм байна. Энэ бүс нь Монголын хамгийн баруун талын ядуу бүс тул бусад бүсээс ирж суурьших явдал байхгүй ч аймаг дотроо болон хөрш аймгийн малчид нэгнийхээ нутаг руу орох явдал түгээмэл гардаг байна.

Монгол орны баруун хойд хэсгийн ойт хээрийн сумуудын төвүүд далайн төвшнөөс улсын дунжаас дээш өндөрт байдаг. Хуурай бор хөрс давамгайлсан, алсын хойд нутгуудаараа хүйтэн цаг уур зонхилсон байдалтай. Ургамлын нөмрөг төв хэсэг рүүгээ сайн байх бөгөөд баруун тийш болох тусам сийрэгждэг. 2008 оны зун нутгийн ихэнх хэсгээр сайхан болсон байна. Газар зүйн байршлаасаа хамаарч 2008 оны өвөл сайн, муу алаг цоог болсон ч баруун тийшээгээ гол төлөв муу өвөл болж, малын хорогдол гарсан байлаа. Газрын тогтцын хувьд ой бүхий уулс, хөндий, тал хээр зонхилсон тул малчид чөлөөтэй нүүж, бэлчээрийг бүрэн ашигладаг ч хэт өндөр уулсаас

болж ашиглагдахгүй бэлчээр хааяа нэг гардаг байна. Бэлчээрийн гарц сайн байдаг тул аймаг дотроо бэлчээр хайн нүүдэллэх тохиолдол ховор хэдий ч өндөр уулын бүсийн баруун аймгийнхан зах зээл бараадан төвийн хэсэг рүү нүүх нүүдлийн хөлд нэрвэгдэх нь их (гол төлөв төвийн хэсгийн ойт хээрийнхэн нүүдэлд их нэрвэгддэг).

Газар тариалан-мал аж ахуй хосолсон Улаанбаатараас хойшихноо байдаг бүс нутгийн сумын төвүүдийн далайн төвшнөөс дээш өргөгдсөн байдал нь Монгол орны дунджаас доогуур байдаг. Энэ бүс нутаг талын бор хөрстэй, зун, намартаа өтгөн ургамлын нөмрөгтэй. Бид зуны эхэн үеэр очиход ургамлын гарц боломжийн байсан ч ногоон ургамлын гарц хүлээж байснаас доогуур байлаа. Монгол орны бусад хэсгийн нэгэн адилаар 2008 оны зун, намар сайхан болсон байна. Мал тарга хүч сайн авсан байснаас гадна өвөл, хавартаа тэжээлийн олдоц сайн байсан байна. Сүүлийн 15 жилд өндөр уулын бүс болон ойт хээрийн баруун хэсгээс их олон малчид энэ бүс нутагт нүүж ирсэн байна. Энэ нь малын тооны хэт өсөлтөнд нөлөөлжээ. Аймаг доторх болон аймаг хоорондын малчдын нүүдэл хөрш зэргэлдээ сум, аймгуудаас, ялангуяа Төв, Дундговь аймгаас ихээр ирдэг байна.

Тал хээрийн төвийн бүсийн сумын төвүүд далайн төвшнөөс 1500 метрээс доош өргөгдсөн байдаг. Энэ бүс нутаг нь хуурай, тал хээрийн бор хөрс, намхан ухаа толгодтой, Монголын ердийн халуун зун, хүйтэн өвөл болдог газрууд юм. Орон нутгийн иргэдийн ярьж байгаагаар ургамлын нөмрөг багасаж, төрөл зүйл нь буурч байгаа аж. Энэ жил Монголын төв хэсгээр зун нилээд сайн эхэлсэн. Бид энэ бүс нутагт 6 дугаар сарын дундуур очиход сайхан ногоорсон байлаа. Гэвч ургамлын нөмрөг газар бүрт эрс ялгаатай байв. Зарим нутагт, ялангуяа Монголын баруун хэсэгтэй харьцуулахад өнгөрсөн өвөл нь маш сайхан байсан тул өвөл, хавар онцолж хэлэхээр малын хорогдол гараагүй байна. Газрын тогтоц нь намхан ухаа, толгод бүхий тэгш тал тул малчид юунд ч саадгүйгээр нүүх боломжтой. Энэ бүс нутаг нь нүүдлийн уулзвар нутаг тул улирлын чанартай нүүдлийг зохицуулахад маш бэрхшээлтэй. Өвөл нь цөлөрхөг хээрийн бүсээс малчид хойшоо нүүж дайрдаг бол зун нь хойноосоо урагшаа задгай усаа бараадсан их нүүдэл ирдэг байна.



Тал хээрийн зүүн бүсийн сумын төвүүд мөн л далайн төвшнөөс дээш 1500 метрээс бага өргөгдсөн байдаг. Малын тооны нягтшил хамгийн бага байдаг нутаг ажээ. Үүний нэг шалтгаан нь гүний ус хэт гүнд байдаг тул хүрэхэд хэцүүгээс болж уст цэг ховор байдагтай холбоотой. Газар нь хуурай, талын хөрстэй, жижиг толгодтой. Ургамлын нөмрөг сайтай. Бид энд 6 дугаар сарын сүүлчээр ирсэн. Хэдийгээр орон нутгийнхан бэлчээр доройтож байна гэж үздэг ч Монголын бусад газруудтай харьцуулахад онцгой ажиглагдахуйц доройтол анзаарагдсангүй. Мөн Монгол Улсад тохиосон 1999-2002 оны зуд энэ нутагт нүүрлээгүй байна. Сүүлийн жилүүдэд өвөл, хавар, зун хэвийн байсан ч биднийг очихоос хэдхэн хоногийн өмнө 6 дугаар сарын дундуур хүйтэн шуурга болсон байлаа. Энэхүү гамшигт аймгийн хэмжээнд 70,000 мал үхсэн байна. Зун оройтож эхэлсэн ч гамшигийн дараа ногоо сайхан ургаж, сайхан зун болж байлаа. Газрын тогтоц нь намхан толгод, тэгш газар тул малчид чөлөөтэй нүүх бололцоотой. Хөрш сумуудаас үе үе ирдэг малчид, Улаанбаатараас ирдэг отрын адууг эс тооцвол бэлчээрт сөргөөр нөлөөлөөд байгаа зүйл алга байна.

Цөлөрхөг хээрийн бүс нь жижиг толгодтой тэгш тал бүхий нутаг юм. Дундаж өндөрлөг нь 1400 орчим метр. Хур тундас бага ордог, халуун зун болдог байна. Бэлчээрийн ургамал сийрэг бөгөөд намхан. Ургамал сийрэг тул малчид бие биенээсээ хол амьдардаг бөгөөд нутгаасаа хол, голдуу хойшоогоо удаан хугацаагаар отроор нүүдэг. Зарим тохиолдолд удаа дараалан болсон гангийн улмаас нутагтаа эргэж ирэлгүй олон жил бусдын нутагт амьдарч буй малчид ч байна. Цөлөрхөг хээрийн бүсэд малчид өөрсдөө тэжээл бэлтгэх бололцоо муу тул өвөл, ялангуяа хатуу өвөл болбол отроор явж өвөлждөг байна.

Мал маллагаанд гарсан өөрчлөлт

Өндөр уулын бүсэд өнгөрсөн зун нь гантай байсан тул малчид өвөл болохоос өмнө малаа зарахыг оролдсон байна. Гэвч гантай зун мал нь сайн тарга хүч аваагүй тул туранхайдуу малын мах төдийлөн үнэд хүрээгүй ажээ. Мөн хүн бүр малаа ихээр зарахыг завдсан тул намартаа зах зээл дээр махны үнэ унасан байна. Махны үнэ тухайн бүс нутгийн хэмжээнд адилхан доогуур байсан нь малын хэт нийлүүлэлт зөвхөн орон нутагт нөлөөлөөд зогсоогүй бүсийн хэмжээнд нөлөөлсөн байна. Ингээд малчид малаа хангалттай зарж чадаагүй тул өвөл, хавартаа олон малаа үхүүлж, бараг төл хүлээн авч чадаагүй байна (Хүснэгт 1а).

Зарим нутагт, ялангуяа төвлөрсөн зах зээлтэй ойр тал хээрийн төв болон газар тариалан-мал аж ахуй хосолсон ойт хээрийн бүсэд муу зун болсон ч малчид төдийлөн малаа намар зарахыг хүсдэггүй байна. Намар зарахын оронд малчид төвлөрсөн зах зээлээс тэжээл худалдан авч өвөлдөө малаа тэжээгээд махны үнэ оргилдоо хүрсэн хаврын улиралд малаа борлуулахыг илүүд үздэг ажээ.

Малчид мөн мал маллагаанд өөрчлөлт гарч байгаа тухай, зарим уламжлалт мал маллагааны арга барил алдагдаж байгаа тухай өгүүлж байлаа. Ихэнх бүсүүдэд (өндөр уулын бүсээс бусад) хамгийн олон дурдагдсан өөрчлөлтөнд малын ус дагаж нэг улиралд олон нүүдэг болсныг ихээхэн дурдаж байлаа. Энэ нь малчдын амьжиргааны тухай дэлгэрэнгүй тайланд (Монголын бэлчээрийн менежментийн холбоо) дурдагдсан усны эх үүсвэр ховордож байгаа тухай мэдээлэлтэй тохирч байна. Зундаа мөнх цаст уулсын хайлсан ус элбэг байдаг тул энэ хүндрэл өндөр уулын бүсэд бага байдаг байна. Иймд БАХ-ийн нутаг дэвсгэрийг зурж тогтооход усны эх үүсвэрийг харгалзан үзэх нь ихээхэн чухал байх нь ээ.

Мал маллагаанд гарсан хоёр дахь өөрчлөлт нь уламжлалаараа ямааны бүс нутаг байгаагүй ойт хээр, газар тариалан-мал аж ахуй хосолсон бүс, тал хээрийн зүүн бүсэд сүрэгт эзлэх ямааны тоо эрс нэмэгдсэнээс сүргийн бүтэц алдагдаж ямаа голдуу малладаг болсон явдал гэж байлаа. Ямааны тоо хурдан өссөн хамгийн гол шалтгаан нь ноолуурын үнэ сүүлийн 10 жилд эрс өссөнтэй холбоотой ажээ. Гэвч малчид болон орон нутгийн удирдлагууд сүрэгт эзлэх ямааны тоо өсөөд ирэхлээр бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөө нэмэгддэг гэдгийг ойлгосон байна.

Чанартай малтай байхын ач холбогдлыг ойлгосон малчид малын эрүүл мэнд, чанарт ихээхэн анхаарах болсон байна. Ялангуяа тал хээрийн төвийн бүс, газар тариалан-мал аж ахуй хосолсон бүс, тал хээрийн зүүн бүсэд энэ нь ихээхэн ажиглагдаж байна. Эдгээр бүс нутгууд нь уламжлалаараа ямаа их өсгөдөггүй байсан тул малчид ямааны оронд илүү чанартай малыг амьдралын эх үүсвэр гэж үзэж байна.

Өндөр уулын бүсийн малчид мал маллагаанд гарсан өөрчлөлтийг хэлэхээсээ илүү түүнийг бий болгож буй шалтгааныг сонирхон хэлж байлаа. Үүнд малын тооны өсөлт, хур тундас буурсан явдал, бэлчээрийн доройтлын улмаас мал маллагаанд өөрчлөлт ороод байна гэж хариулжээ. Тал хээрийн төвийн бүсийн малчид тэжээл худалдан авч өвөл малаа тарган онд оруулаад хавар Улаанбаатарын зах зээлд тарган мал нийлүүлдэг болоод байна. Цөлөрхөг хээрийн бүсэд малчид уламжлалт мориор малаа хариулахаас илүү моторт унаагаар малаа хариулдаг болоод байна гэжээ. Техникээр малаа хариулахад малын нягтаршил бага, газар нь хавтгай зэрэг боломжууд байдгаас гадна газар нутаг томтой тул мал нь хол бэлчдэгтэй ч холбоотой ажээ.

Бүх бүс нутагт хүмүүс бэлчээрийг доройтож байна гэж үзэж байна. Ялангуяа өндөр уулын болон цөлөрхөг хээрийн бүсэд доройтлыг хэт их гэж үзэж байгаа ажээ. Хүснэгт 1а-д үзүүлсэнчлэн бэлчээрийн доройтлыг бий болгож байгаа хамгийн гол шалтгаанд сүргийн бүтцийн өөрчлөлт, ялангуяа ямааны тоо хэт өссөн явдал гэж цөлөрхөг хээрээс бусад бүх бүсэд үзсэн байхад тал хээрийн зүүн болон цөлөрхөг хээрийн бүсээс бусад нутагт малын тооны өсөлт дараагийн шалтгаанаар тодорсон байна. Тал хээрийн зүүн бүсэд малын тоо бэлчээрийн даацаас



хавьгүй доогуур байгаа тул нутгийнхан малын тоог бэлчээрийн доройтлын үндсэн шалтгаан гэж үздэггүй ажээ. Цөлөрхөг хээрийн бүс нь бэлчээрийн тэнцвэргүй нутаг тул бэлчээрийн доройтлыг малын тооноос гэхээс илүү цаг уурын хүчин зүйлтэй холбон тодорхойлох ёстой юм. Иймд эдгээр нутгийн малчид малын тоо, өөрсдийн мал маллах арга барилыг бэлчээрийн доройтлын шалтгаан гэж үзэхгүй байгааг гайхаад байх шаардлагагүй ажээ. Тал хээрийн зүүн болон цөлөрхөг хээрийн бүсэд бэлчээрийн доройтол малын тооны өсөлтөөс бус хур тундасны бууралт, усны хомсдлоос болж байна. Тал хээрийн төвийн бүсэд отор нэрээр бусад нутгаас орж ирдэг түр зуурын нүүдэл бэлчээр доройтоход ихээхэн түхэц болж байна. Эцэст нь дурдахад элсэн шуурга, он дараалсан гангийн улмаас цөлөрхөг хээрийн бүсэд бэлчээрийн доройтол ихээхэн газар авч байгаа ажээ.

Улирлын нүүдлийг бараг хийхээ больсон нь өндөр уул, газар тариалан-мал аж ахуй хосолсон бүс, тал хээрийн зүүн бүсийн бэлчээрт ихээхэн хор уршиг болж байна гэж үзсэн байна. Энэ нь мал маллагаанд гарсан өөрчлөлт дээр малчид улирлын нүүдэл их хийдэг болсон гэдэгтэй зөрчилдөж байгаа ч гол төлөв улирлаа дагаж өвсний гарцыг хайж нүүхээс эзлүү усаа дагаж нүүж байгаа тул энэ хоёр мэдээлэл хоорондоо тохирно гэж үзэж болох юм. Ус хайж нүүх нүүдэл нь усны эх үүсвэрийн орчмын бэлчээрийг их хэмжээгээр сүйтгэдэг. Бэлчээрийн доройтлын шалтгаанууд нь шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тэнцвэрт, холимог, тэнцвэргүй тогтолцоотой нилээд тохирч байна. Эхний нөхцөлд малын тооны өсөлтөөс, мөн ямааны тоо хэт өссөнөөс болж алдагдсан сүргийн бүтцээс бэлчээрийн доройтол бий болж байна гэж үзэж байхад дараагийн нөхцөлд цаг уурын өөрчлөлт, цаг агаарын эрсдлээс болж байна гэж үзсэн байна. Судалгаанд хамрагдагсдын өгсөн энэхүү хариулт нь шинжлэх ухааны үндэслэлтэй тохирч байгаа нь энэхүү судалгааны аргачлалаар судалгааны үр дүн найдвартай гарч байна гэдэг нь харагдаж байна. Нөгөө талаас бүс бүрийн нарийвчилсан тайлангаас үзэхэд бэлчээрийн доройтлын талаарх малчид болоод орон нутгийнхны үзэл бэлчээрийн даац болоод тэнд байх малын тоог шинжлэх ухааны аргаар тооцож гаргасан мэдээлэлтэй таарахгүй байгаа нь ажиглагдлаа. Энэхүү үзэл, арга хоёрын зөрүүтэй байдлыг тайлбарлахын тулд малчид бэлчээрийн төлөв байдлыг яаж үнэлдэг вэ, нутаг нутгийн байгаль орчны өвөрмөц шинжийг бэлчээрийн даацыг тодорхойлохдоо аль хэр зөв оруулж байна вэ гэдэг дээр нарийвчилсан судалгаа хийх шаарлагатай юм. Африкт хийсэн судалгаанаас үзэхэд бэлчээрийн төлөв байдлын талаар малчдын үзэл, ургамлын үнэлгээний талаарх судалгааны үр дүн (Весулс, Ланг, 2010) хоёр тохирч байсан бөгөөд нутаг нутагт бэлчээрийн нөхцөл, байгаль орчны онцлогийн талаар бүрэн мэдээлэл байдаг байна (Томас, Твимэн, 2004).

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан бүх бүсийн малчид бэлчээрийн доройтлыг нэмэгдэж байна гэж үзэж байна. Доройтлыг бий болгож буй үндсэн хүчин зүйлд цөлөрхөг хээр болон тал хээрийн зүүн бүсээс бусад бүсэд малын тооны өсөлт, ямааны тооны өсөлтөөс болж үүссэн сүргийн бүтцийн өөрчлөлт гэж хариулжээ. Бэлчээрийн доройтол, түүний шалтгааны талаар малчдын өгсөн хариулт бэлчээрийн тэнцвэрт болон тэнцвэргүй тогтолцоог тайлбарласан шинжлэх ухааны дүгнэлттэй нийцэж байна.
2. Нөгөө талаас нь авч үзвэл бэлчээрийн доройтлын талаар малчдын үзэл мал бэлчээрийн даацаас хэтрээд байгаа тухай шинжлэх ухааны үндэслэлтэй тооцооллоос зөрүүтэй байна.
3. Цөлөрхөг хээрийн малчид ус болон бэлчээр даган алс хол ойр ойрхон нүүдэг, тал хээрийн төвийн бүсийн нутаг руу тэр их нүүдэл ирдэг зэрэг нь эдгээр бүсэд нутаг дэвсгэрт үндэслэсэн бэлчээрийн менежментийн тогтолцоог бий болгоход хүндрэл учруулж байна.
4. Мал маллах арга барилд гарсан үндсэн өөрчлөлт нь малын ус дагаж ихээр нүүдэг болсноос гадна бэлчээрээ зөв ашиглах чиглэлээр улирлын сэлгээ, бэлчээрээ өнжөөдөг ажлууд бараг хийгдэхээ больсон явдлууд юм.
5. Томоохон зах зээлтэй ойр төвийн бүсүүдэд малын, ялангуяа ямааны тоог өсгөхийн оронд малын чанарыг дээшлүүлэхийг эрхэмлэж байна. Төв суурингийн ойролцоох малчид тэжээл зах зээлээс худалдан авч малаа онд сайн оруулж байна. Ингэснээр тэд малын хорогдлыг бууруулаад зогсохгүй намар малын үнэ хямд байх үед биш, харин хавар махны үнэ хамгийн өндөр байхад малаа борлуулах боломжтой болж байна. Алслагдмал нутгийн малчид 2008 онд хуурай зун болсны дараа өвөл мал хорогдоно гэсэн болгоомжлолоор намар малаа ихээр борлуулах гэж оролдон зах зээл дээр малын хэт нийлүүлэлтийг бий болгосон байна. Энэ стратеги нь үнийн уналтанд хүргэж байна.
6. Үнэ хэт унасан нь өндөр уулын бүсэд муу зун болсны дараа малаа борлуулах боломжгүй болгосон байна. Ингэснээр өвөл, хавар том мал ихээр хорогдсон төдийгүй хавар бараг төл авахгүйд хүргэжээ.



Хүснэгт 1а: Цаг уурын нөхцөл, мал маллагаанд гарсан өөрчлөлт, бэлчээрийн доройтол

Бүс	Ямар байсан бэ?		Малын хорогдлын хувь (%)	Сүүлчийн муу зуны дараа мал борлуулах боломж	Хамгийн чухал гурван өөрчлөлт		Одоо байгаа төслүүд, хэдэн оноос хойш
	Өнгөрсөн зун	Өнгөрсөн өвөл			Мал маллагаанд гарсан өөрчлөлт	Бэлчээрийн доройтлын шалтгаан	
Өндөр уул	Хуурай, бороо багатай	Цаг агаар муу байгаагүй харин бэлчээ-рийн өвс хомс байлаа	1.0-50.0	Маш муу	- Малын тоо өссөн, - Хур тундас буурсан, - Бэлчээр доройтсон,	- Малын тоо өссөн, - Сүргийн бүтэц өөрчлөгдөж, ямаа давамгайлсан, - Улирлын сэлгээ бага болсон	- ТАТ --- 2002 - МК---2004 - НА ---2005 - НҮЦҮ---2005 - ДЗ---2006 - ДБХС---2007 -Алтай Саян-2008
Ойт хээр	Сайн, гэхдээ Идэр, Өндөр-Улаан сумуудад нилээд хуурай байсан	Эхлэл нь сайхан, төгсгөл нь хүйтэн болсон, хатуу өвөл гэж дүгнэнэ	Малын хорогдол гараагүй. Идэрт 15% нь хорогдсон	Доогуур	- Ямааны тоо өсөж, сүргийн бүтэц өөрчлөлт орсон - Малын ус хайж их нүүдэг болсон - Отроор их нүүх боллоо	- Малын тоо өссөн - Сүргийн бүтэц өөрчлөгдөж, ямаа давамгайлсан - Тэлмэн, Идэр сумуудад царцаа, хортон мэрэгч их болсон	- ХЯБХ-2003 - ТАТ---2002 - НА---2005 - ДЗ---2005
Газар тариалан-мал аж ахуй хосолсон	Орой эхэлсэн, гэхдээ сайн болсон	Муугүй, гэхдээ төгсгөл нь салхитай байсан	Үгүй	Муу, гэхдээ зарах гэж оролдоо-гүй	- Бэлчээр, усны олдоцыг дагаж их нүүх болсон - Сүргийн бүтэц өөрчлөгдөж, ямаа давамгайлсан - Малын чанар, эрүүл мэндийг дээшлүүлэх	- Малын тоо өссөн - Сүргийн бүтэц өөрчлөгдөж, ямаа өссөн - Улирлын сэлгээ бага болсон	- БТМ 2003-2007 - ТАТ---2002 - ДЗ---2004 - ЖАЙКА---2006 - ОНЗС---2009
Тал хээрийн төв	Маш сайн зун болсон, харин нэг суманд эрт хуурайш-сан	Цас багатай сайхан өвөл болсон	Үгүй	Муу, гэхдээ зарах гэж оролдоо-гүй	- Малын эрүүл мэндийг сайжруулах - Өвлийг давахын тулд тэжээл их бэлтгэдэг, хавар мал бордож борлуулдаг болсон - Ус дагаж их нүүдэг болсон	- Малын тоо өссөн - Гаднаас отрын малчид их ирдэг болсон - Сүргийн бүтэц өөрчлөгдөж, ямаа давамгайлсан	- ХДЦГ---1994 - ТАТ---2003 - НА---2007 - ЦТГТМ---2008
Тал хээрийн зүүн	Эхлэл нь хуурай байсан ч сайн зун болсон	Сайхан өвөл болсон	Үгүй	Хэзээ ч зарах гэж үзээгүй	- Малын ус хайж их нүүх болсон - Малын чанарыг сайжруулах - Ямааны тооны өсөлтөөс болж сүргийн бүтэц алдагдсан	- Сүргийн бүтэц өөрчлөгдөж, ямаа давамгайлсан - Хур тундас буурч, малын ус хомсодсон - Улирлын сэлгээ бага болсон	- ТАТ---2003 - НҮЦҮ---2003 - ДЗ---2007
Цөлөрхөг хээр	Нэг сумаас бусдад нь маш хуурай зун болсон	Сайхан өвөл болсон, гэхдээ бэлчээ-рийн өвс хомс байсан	Үгүй	Муу, гэхдээ зарах гэдэггүй	- Ус, бэлчээр хайж өөрийн суманд төдийгүй хөрш сум, аймаг руу оторлодог - Моторт унаагаар малаа хариулдаг болсон - Гэргүй отор хийдэг болсон	- Олон жил дараалсан зуд - Элсний нүүдэл, элсэн шуурга - Малын ус хомс	- МК---1998-2008 - ТАТ---2002 - НА---2004 - ДЗ---2006 - ЦТГТМ---2009

Хүснэгт 1б: БАХ-тэй сумуудын бэлчээрийн нөхцөл, доройтол

Бэлчээрийн доройтол	Өндөр уул		Ойт хээр		Газар тариалан-мал аж ахуй	Тал хээрийн төв	Цөлөрхөг хээр
	Цэнгэл	Дуут	Их тамир	Тэлмэн	Баянгол	Өндөр ширээт	Өлзийт
Доройтол малчдын бодлоор	Маш их	Маш их	Доройтож байна	Доройтож байна	Доройтож байна	Доройтож байна	Маш их
Бэлчээрийн даацын тооцоогоор	18% хэтэрсэн	39% хэтэрсэн	118.5% хэтэрсэн	хэтрээгүй	90% хэтэрсэн	1.5% хэтэрсэн	27% хэтэрсэн



Малчдын байгууллага байгуулах, ажиллуулахад гардаг хүндрэл

Хүснэгт 2-т малчдын байгууллага байгуулах, ажиллуулахад гардаг хүндрэлийг үзүүлээ. БМ болон БАХ-ийг тус тусад нь харуулсан болно.

Малчны бүлэг

Хэдийгээр МБ гэсэн ойлголт нь хандивлагчаас хандивлагчид, нэг газраас нөгөө газарт өөр өөр байдаг ч МБ-ийг санаачлан байгуулах, үйл ажиллагааг нь явуулахад гардаг хүндрэлүүдийн талаар өөр өөр МБ-үүдэд ижилхэн асуулт тавьсан болно. Дөрвөн бүсийн гуравт нь (өндөр уулын бүсээс бусад) хамгийн их дурдсан хүндрэлд төслийн үйл ажиллагаа дууссаны дараа тэднийг идэвхжүүлэн авч явах байгууллага байхгүй гэдэг санаа орж байлаа. Өндөр уул, тал хээрийн төв болон зүүн бүсэд арга зүйн зөвлөгөө ихээхэн дурдагдаж байсан. Энэ хоёр хүчин зүйл төсөл дууссаны дараа МБ-үүд яагаад амархан сулардгийг харуулж байна. Энэ хоёроос гадна санхүүгийн тусламж, гишүүдийн санаачлага, оролцооны хомсдол, малын түүхий эдийн үнийн уналт, гишүүн, гишүүн бусчуудын хоорондын зөрчил МБ-үүдийг цаашид хэрхэн оршин тогтнохыг шийддэг байна.

Бэлчээр ашиглагчдын хэсэг болон холбоо

БАХ байгуулж, үйл ажиллагааг нь явуулахад гардаг хүндрэлүүд маш олон төрөл бөгөөд нэг нийтлэг хүндрэл олоход бэрхшээлтэй байлаа. Газар тариалан-мал аж ахуй хосолсон бүсэд БАХ-ийн тогтолцоо байхгүй, харин бэлчээрийн болон мал аж ахуйн менежмент хийж буй орон нутгийн санаачлага бий. Гишүүдийн санаачлага, оролцооны хомсдол МБ болон БАХ-т түгээмэл хүндрэл болж байна. Хамтын үйл ажиллагаанд оруулахад орон нутгийн иргэдийн санаачлага, оролцоог эрчимжүүлэх илүү хөшүүрэг, цаг хэрэгтэй гэдэг нь эндээс харагдаж байна. Тал хээрийн төвийн бүсэд БАХХ-ны болон БАХ-ийн ахлагч нарыг зөв сонгох нь хамгийн чухал гэж хариулсан байгаа нь малчдын байгууллагын ирээдүйн хувь тавиланд оновчтой удирдлага чухал гэдгийг нотолж байна. Ойт хээр болон цөлөрхөг хээрийн бүсэд усны хомсдол тэргүүнд дурдагджээ. БАХ-ийн газар нутгийн тогтолцоо БАХ-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх нь тухайн газар нутагт ус хэр зэрэг элбэг байгаагаас болдог байна. Тал хээрийн төвийн бүсийн судалгаанд хамрагдагсад гадны малчид манай нутагт отроор ирээд хэл ам гарахад манай БАХ-ийн болон БАХХ-ны удирдлагуудын үгийг хэн ч тоодоггүй. Орон нутгийн удирдлагууд, ялангуяа аймгийн удирдлагууд БАХ-ийн удирдлагуудтай огт ярилцалгүй гадны нүүдлийн асуудлыг шийдчихсэн байдаг гэж байлаа. Зарим малчид хэлэхдээ төрийн бодлого заримдаа Ногоон алт төслийн үйл ажиллагааны эсрэг байгаад байх шиг санагдах юм гэж байв.

Дүгнэлт

1. Малчдын байгууллагыг байгуулах нь тийм ч хүндрэлтэй биш, харин үр бүтээлтэй ажиллах нь нилээд хүндрэлтэй ч тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулсан хугацаа, байршлаас хамаараад янз янз байдаг байна.
2. МБ-ийн үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө үргэлж хэрэгтэй байдаг байтал төсөл дууссаны дараа идэвхжүүлэгч байгууллага байхгүй болчихдог явдал түүний тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг байна. Үүнээс малчдын хамтын үйл ажиллагаанд байнгын тусалцаа үзүүлдэг байгууллага нэн чухал болох нь харагдаж байна.
3. БАХ-ийн үйл ажиллагааг явуулахад гардаг хүндрэлүүд янз янз байдаг нь тухайн орон нутгийн онцлогоос хамаардаг гэдгийг харуулж байна. Тал хээрийн төвийн бүсийн хариултаас харахад чадвартай удирдлагатай байх, орон нутгийн засаг захиргаатай ойрхон ажиллах нь БАХ-ээс бэлчээрийг нийтээр өмчлөх явдлыг зөв удирдахад чухал хүчин зүйл болдог байна.

Хүснэгт 2а: МБ байгуулахад гардаг хүндрэл

Бүс	Хамгийн их дурдагдсан гурван хүндрэл (дурдагдсан тооны дарааллаар)
Өндөр уул	- санхүүгийн хүндрэл, - арга зүйн тусалцаа хомсдолтой, - гишүүдийн санаачлага, оролцоо муу, - хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн уналт
Газар тариалан-мал аж ахуй, орон нутгийн захиргааны санаачлаггүй	- төсөл дууссангуут идэвхжүүлэгч байгууллага байхгүй болчихдог, - зах зээлийн чадавх муу, - гишүүн, гишүүн бусчуудын хоорондын зөрчил
Газар тариалан-мал аж ахуй, орон нутгийн захиргааны санаачлагатай	- төсөл дууссангуут идэвхжүүлэн удирдах байгууллага байхгүй болчихдог, - гишүүдийн санаачлага, оролцоо муу, - МБ-ийн ахлагч нарыг буруу сонгодог
Тал хээрийн төв	- арга зүйн тусалцаа хомсдолтой, - гишүүдийн санаачлага, оролцоо муу, - төсөл дууссангуут идэвхжүүлэн удирдах байгууллага байхгүй болчихдог, - зөрчил
Тал хээрийн зүүн	- санхүүгийн хүндрэл, - арга зүйн тусалцаа хомсдолтой, төсөл дууссангуут идэвхжүүлэн удирдах байгууллага байхгүй болчихдог, - хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн уналт

Хүснэгт 2б: БАХ байгуулахад гардаг хүндрэл

Бүс	Хамгийн их дурдагдсан гурван хүндрэл (дурдагдсан тооны дарааллаар)
Өндөр уул	- гишүүдийн санаачлага, оролцоо муу, - царцаа, хортон мэрэгч их, - арга зүйн тусалцаа хомс, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ хэт хэлбэлзэлтэй
Ойт хээр	- цаг уурын эрсдэл их - гишүүдийн санаачлага, оролцоо муу, - усны олдоц муу, малчид өөрийн БАХ-ээ үгүйсгэдэг
Тал хээрийн төв	- БАХ болон БАХХ-ны тэргүүнүүдийг буруу сонгодог, - "НА төсөл малчдын тархийг хангалттай угаахгүй байна", өөрөөр хэлбэл төсөл малчдад бэлчээрийн доройтлын мөн чанар, түүнтэй тэмцэх талаар бүрэн ойлгуулахгүй байна, -БАХ-ийн ахлагч нарын үгийг сонсдог хүн байхгүй
Цөлөрхөг хээр	- малын ус хомс, - орон нутгийн захиргааны хүнд суртал, - зөрчил



Малчид өөрсдийн байгууллагаа хэрхэн ойлгож байна вэ

Малчдын бүлэг

Хүснэгт 3а, 3б-д үзүүлснээр бүлгүүдийг санаачлан бий болгосноос хойш бүх бүсэд гишүүдийн идэвхтэй оролцоо ерөнхийдөө өндөр байж байгаад эргээд буурдаг нь ажиглагдаж байна. Өндөр уулын болон тал хээрийн төвийн бүсэд МБ-үүд идэвх муутай болсон байхад газар тариалан-мал аж ахуй хосолсон болон тал хээрийн зүүн бүсүүдэд гишүүдийн оролцоо янз бүр байна. Ийнхүү гишүүдийн оролцоо сайн, эсвэл идэвхгүй байдал руу буурч байгаа хандлага нь одоогийн байдлаар МБ-үүд хүлээж байгаа хэмжээнд хүртэл ажиллахгүй байгааг харуулж байна. Судалгаанд хамрагдагсад хэлэхдээ малчид гол төлөв хандивлагчдаас материаллаг тусламж авна гэсэн хүлээлттэйгээр бүлэг болдог. Хэрэв тэрхүү материаллаг дэмжлэг хүлээж байсан хэмжээнд ирэхгүй бол бүлгийн үйл ажиллагаа зогсдог боловч нэрээ хадгалаад байж байдаг гэжээ. Малчид албан ёсоор МБ-ээсээ гарчихдаггүй нь, бас идэвхгүй байдал хоёр нь сэтгэл гутралаас болдоггүйг харуулж байгаа ажээ. МБ-үүд гишүүн бусчуудтай бэлчээр ашиглах талаар зөрчилд ордог байна.

Бэлчээр ашиглагчдын хэсэг

БАХ-үүдийн хувьд гишүүдийн оролцоо ерөнхийдөө хангалттай биш байна. Хүснэгт 3б-д үзүүлсэнчлэн гишүүдийн анхны оролцоо гурван бүсэд сайн байхад малын нүүдэлд их нэрвэгддэг газар тариалан-мал аж ахуй хосолсон (БАХ биш, орон нутгийн захиргаа нь санаачлага гаргагч болсон) болон тал хээрийн төвийн бүсүүдэд янз бүр байна. Гэтэл одоогийн оролцоо сайн байна. Харин цөлөрхөг хээрийн бүсэд малчид нь БАХ-ийн тогтолцоо тэдэнд тулгараад буй бэрхшээлийг шийдэхэд төдийлөн тохиромжтой гэж үзэхгүй байгаа тул оролцоо сайжрахгүй байсаар байна. Хамгийн олон чинээлэг малчинтай тал хээрийн төвийн бүсэд анхны оролцоо янз бүр байсан

байна. Чинээлэг малчид БАХ-т нэгдэхийг хүсдэггүйн нэгэн адил БАХ-ийн гишүүд ч олон малтай чинээлэг өрхүүдийг эгнээндээ авахыг хүсдэггүй ажээ. Цөлөрхөг хээрийн бүсэд гишүүдийн анхны оролцоо сайн байсан ч тодорхой цаг хугацааны дараа янз бүр болж байгаа нь одоогийн тэнд байгаа БАХ-ийн тогтолцоог тэдний нүүдлийн арга барилд тохируулах шаардлагатайг харуулж байна. Хүснэгт 3б-ээс цөлөрхөг хээрийн зарим малчид БАХ-ийн тогтолцоо нэвтрүүлэх явдлыг эсэргүүцэж байгааг ч харж болох юм.

БАХ-ийн дотоодод зарим зөрчил илэрдэг байна. Үүнд өндөр уулын бүсийн малчид хадлангийн талбай дээр гардаг маргаан, ойт хээр, тал хээрийн төвийн бүсэд газар нутгийн маргаануудыг нэрлэж болох юм. Иймэрхүү зөрчлүүд нь малчид БАХ-ийн нутаг дэвсгэр хуваах эхний хурлуудад, эсвэл урт хугацааны стратегийн шинж чанартай яриануудад оролцоогүйгээс үүсдэг байна.

БАХ-ийн тогтолцоонд ч үл зөвшилцөл гарч байна. Газар тариалан-мал аж ахуй хосолсон бүсэд сумын засаг даргын гаргасан бэлчээрийн менежментийн санаачлагыг зарим малчид хүлээн зөвшөөрөхгүй байна.

Дүгнэлт

1. МБ-ийн гишүүдийн оролцоо бага байгаа нь энэ тогтолцоо тийм ч тохиромжтой биш байгааг харуулж байна.
2. МБ-үүд гишүүн бусчуудтай зөрчилд ордог.
3. Зарим гишүүд эхний хурлуудад оролцоогүйгээс БАХ-үүд зарим тохиолдолд газар нутгийн хилийн маргаанд өртдөг.
4. БАХ-ийн одоогийн тогтолцоо цөлөрхөг хээрийн бүсэд төдийлөн тохирохгүй байна.
5. Газар тариалан-мал аж ахуй хосолсон бүсэд дээрээсээ санаачилсан бэлчээрийн менежментийн үйл ажиллагаанд хангалттай оролцоо бүрдээгүй байна.

Хүснэгт 3а: МБ-ийн талаар малчдын бодол

Сум	Анхны оролцоо	Одоогийн оролцоо	Одоогийн эсэргүүцэл	Зөрчил	Сэтгэл гутрал
Өндөр уул	Сайн	Идэвхгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Газар тариалан-мал аж ахуй	Сайн	Янз бүр	Үгүй	Бэлчээр ашиглалт дээр гишүүн бусчуудтай	Үгүй
Тал хээрийн төв	Сайн	Идэвхгүй	Үгүй	Бэлчээр ашиглалт дээр гишүүн бусчуудтай	Үгүй
Тал хээрийн зүүн	Сайн	Янз бүр	Үгүй	Бэлчээр ашиглалт дээр гишүүн бусчуудтай	Үгүй

Хүснэгт 3б: БАХ-ийн талаар малчдын бодол

Сум	Анхны оролцоо	Одоогийн оролцоо	Одоогийн эсэргүүцэл	Зөрчил	Сэтгэл гутрал
Өндөр уул	Сайн	Сайн	Үгүй	Явцын дунд гарч ирсэн (үр ашиг хуваахад)	Үгүй
Ойт хээр	Сайн	Сайн	Үгүй	Явцын дунд гарч ирсэн (бэлчээр ашиглалт)	Үгүй
Тал хээрийн төв	Янз бүр	Сайн	Үгүй	Явцын дунд гарч ирсэн (БАХ-т хуваарилсан бэлчээр дээр)	Үгүй
Цөлөрхөг хээр	Сайн	Янз бүр	Заримдаа	Заримдаа	Үгүй
Газар тариалан-мал аж ахуй	Янз бүр	Янз бүр	Үгүй	Гишүүн бусчуудтай	Үгүй



Эдийн засаг, бэлчээрийн менежментийн үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан бүсийн онцлогоос хамаарч нийтдээ бэлчээр, мал аж ахуйн менежментийн 25 хүртэл үйл ажиллагааг ярилцлагын явцад бүртгэлээ. Бэлчээрийн менежмент, мал аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх бүх үйл ажиллагааг гурван бүлэг болгон хувааж шинжлэв. Үүнд: газар хуваарилалт, нүүдэл (сум бүрт 8 хүртэл үйл ажиллагаа), хамтын үйл ажиллагаагаар бүтээмж дээшлүүлэх (9 үйл ажиллагаа), хамтын үйл ажиллагаагүйгээр бүтээмж дээшлүүлэх. Үйл ажиллагааг ингэж ангилах нь ямар үйл ажиллагааг бүх газар нутгийг хамарсан БАХ-ийн тогтолцоогоор, ямар үйл ажиллагааг МБ гэх мэт заавал нутаг дэвсгэрт үндэслэгдээгүй жижиг бүлгүүд, хувь хүмүүс хийж болох вэ гэдгийг харах бололцоо олгож байгаа юм. Эдгээр үйл ажиллагаануудын жагсаалт, тэдгээрийн тогтвортой амьжиргаатай ээрхэн холбогдохыг доор харууллаа.

Газар хуваарилалт, нүүдэл:

- БАХ-ийн газар нутгийг хуваарилж, хилийн шугам татах;
- Малчдад өвөл, хаврын бэлчээр хуваарилах;
- Хувь хүмүүст өвлийн бэлчээр хуваарилах;
- Зун, намрын бэлчээр хуваарилах;
- Бүх улирлын бэлчээр хуваарилах (Газар нутгаас хамаарч зуны бэлчээрийг хуваарилах шаардлага байхгүй. Гэхдээ зарим газар хуваарилах шаардлагатай гэдэг нь харагдаж байгаа).
- Улирлын сэлгээ хийх: Тухайн жилд бэлчээрийг зөв амраахад зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа юм.
- Сум хоорондын нүүдлийг зохицуулах;
- Баг хоорондын нүүдлийг зохицуулах;
- Зөрчлөөс урьдчилан сэргийлэх.

Эдгээр үйл ажиллагааны зарим нь газар хуваарилалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд, ялангуяа хатуу жилүүдэд ихээхэн ач холбогдолтой.

Хамтын үйл ажиллагаагаар бүтээмж дээшлүүлэх үйл ажиллагаа. Үүнд:

- Отрын нутаг бий болгох;
- Хадлангийн талбайг тогтоох, хувь хүмүүс болон бүлгүүдэд хуваарилах;
- Өнжөөх бэлчээрийг тодорхойлох;
- Хувь хүний болон бүлгийн бэлчээрийг хашаалах;
- Дарш, тэжээл хамтаараа тариалах;
- Бэлчээр болон хадлангийн талбайд үр цацах;
- Услалтын системийг сайжруулах, шинээр барих;
- Хамтаараа мод, бут сөөг тарих;
- Үүл буудах;
- Малын тоог бууруулах талаар ярилцах;
- Уулын замыг сайжруулах, шинэ зам гаргаснаар ашиглагддаггүй бэлчээрт хүрэх;

- Ашиглагддаггүй бэлчээрт худаг гаргах;
- Царцаа, бусад хортон, мэрэгчидтэй тэмцэх.

Хамтын үйл ажиллагаагүйгүйгээр бүтээмж дээшлүүлэх үйл ажиллагаанууд:

- Дарш тариалах;
- Хадлангийн талбайн чулуу түүх;
- Мал вакцинжуулах;
- Малын чанарыг сайжруулах;
- Мод, бут сөөг тарих.

Хадлан тэжээл бэлтгэх гэх мэт зарим үйл ажиллагааны эрчимжилтийн тодорхой дүр төрхийг харахын тулд эрчимжилт тооцож болох үйл ажиллагаанууд дээр эрчимжилтийн 1-3 хүртэл оноог өглөө. Нэг гэвэл эрчимжилт тааруу, хоёр гэвэл эрчимжилт дунд зэрэг, гурав гэвэл эрчимжилт сайн гэсэн үг болно.

Хийсэн, хийгээгүй гэдгээр тодорхойлогдох газар хуваарилах, нүүдэл гэх мэт үйл ажиллагаанууд дээр эрчимжилтийг тооцсонгүй. Газар хуваарилалт, нүүдлийн талаарх мэдээлэл ойт хээр болон цөлөрхөг хээрийн бүсийн МБ-үүд дээр олдоогүй бол газар тариалан-мал аж ахуй хосолсон бүсэд БАХ байхгүй гэдгийг энд тэмдэглэх хэрэгтэй. Иймд өндөр уул, тал хээрийн төвийн МБ, БАХ-үүдийн үйл ажиллагааг хооронд нь харьцууллаа. Хүснэгт 4а-д үзүүлсэнчлэн, МБ-үүд нийтдээ 5-13 үйл ажиллагаа явуулж байгаагийн хамгийн цөөн нь тал хээрийн зүүн бүсийн Матад суманд, хамгийн олон нь өндөр уулын Улаан хус, тал хээрийн зүүн бүсийн Булган суманд явагдаж байна. БАХ-ийн явуулж буй үйл ажиллагааны тоо нь МБ-ийн явуулж буй үйл ажиллагааны тооноос харьцангуй олон байгаа нь ажиглагдаж байлаа. Харин Дуут сумын хувьд судалгаа авах үед үйл ажиллагаа нь дөнгөж эхлээд байсан бөгөөд санхүүжилт нь орж ирээгүй байсан тул төдийлөн олон үйл ажиллагаа явуулж амжаагүй байлаа (Хүснэгт 4б).

Дээр дурдсан хооронд нь шууд харьцуулж болох хоёр нөхцөлийн хувьд БАХ-үүд МБ-үүдийг бодоход улирлын сэлгээ, бусад бэлчээрийн менежментийн үүргүүдийг сайн гүйцэтгэж байна. Өндөр уулын бүсийн хувьд БАХ-үүд найман үйл ажиллагаа явуулж байхад МБ-үүд дөнгөж хоёрыг явуулж байлаа. Тал хээрийн төвийн бүсэд БАХ-үүд тавыг явуулж байхад МБ-үүд 3-5-тай байх жишээтэй. Бэлчээрийн менежмент, улирлын сэлгээ бүхий нүүдэлтэй холбоотой үйл ажиллагааны талаар БАХ-үүдийг хооронд нь харьцуулахад өндөр уулын бүсийн бэлчээрийн тэнцвэрт орчинд явуулж буй үйл ажиллагааны тоо тал хээрийн холимог болон цөлөрхөг хээрийн тэнцвэргүй орчинд явуулсан үйл ажиллагаанаас харьцангуй олон байна. Энэхүү харьцуулалт нь бэлчээрийн тэнцвэрт болон холимог орчинд нутаг дэвсгэрт тулгуурласан малчдын байгууллага бэлчээрийн болон нүүдлийн үйл ажиллагааг илүү сайн гүйцэтгэж байхад холимог болон тэнцвэргүй орчинд ихээхэн хүндрэлтэй учирч буй нь харагдаж байна.

Хамтын үйл ажиллагаагаар бүтээмж сайжруулах үйл ажиллагааны хувьд бүсийн онцлогоос хамааран МБ-



үүд 2-7, БАХ-үүд 2-11 үйл ажиллагаа явуулж байна. Эрчимжилтийн төвшинг оруулахгүйгээр харахад хамтын үйл ажиллагаагаар бүтээмжийг дээшлүүлэхэд бүлгийн загвар тохиромжтой эсэх талаар их зөрүү ажиглагдахгүй байна. Харин хамтын үйл ажиллагаанд бүлгийн ажил шаардагдахгүй хэсэгт МБ-үүд 1-4, БАХ-үүд 2-5 үйл ажиллагаа явуулж байгаа нь БАХ болон МБ-ийн хооронд төдийлөн ялгаа харагдсангүй.

Эдгээр мэдээллээс үзэхэд МБ-үүд хамтаараа харьцангуй олон үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа ч бэлчээрийг нийтээр эзэмших явдлыг хянахад хамгийн чухал хэрэгсэл болох бэлчээрийн менежмент, улирлын нүүдлийг удирдахад нилээд сул байгаа нь харагдаж байна. Харин БАХ-үүд хамтын үйл ажиллагаа шаардсан болон шаардаагүй бүтээмжийг дээшлүүлэх, бэлчээрийн менежмент, нүүдлийн асуудлууд дээр илүү сайн, жигд үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 4а: МБ-ийн эрхэлж буй үйл ажиллагааны тоо

Үйл ажиллагааны тоо, төрөл	Өндөр уул	Газар тариалан-мал аж ахуй		Тал хээрийн төв			Тал хээрийн зүүн			
	Улаан хус	Мандал	Баянгол	Эрдэнэсант	Баян-Өнжүүл	Алтан-булаг	Матад	Баян-Уул	Цагаан-Овоо	Булган
Нийт	13	12	11	10	6	10	5	6	10	13
Бэлчээрийн менежмент, нүүдэл	2	3	3	3	3	5	2	1	5	5
Хамтын үйл ажиллагаагаар бүтээмж дээшлүүлэх	7	5	4	4	2	4	2	3	4	5
Хувиараа бүтээмж дээшлүүлэх	4	4	4	3	1	1	1	2	1	3

Хүснэгт 4б: БАХ-ийн эрхэлж буй үйл ажиллагааны тоо

Үйл ажиллагааны тоо, төрөл	Өндөр уул		Ойт хээр		Тал хээрийн төв	Цөлөрхөг хээр
	Цэнгэл	Дуут	Их тамир	Тэлмэн	Өндөр ширээт	Өлзийт
Нийт	24	12	17	22	11	10
Бэлчээрийн менежмент, нүүдэл	8	8	8	7	5	6
Хамтын үйл ажиллагаагаар бүтээмж дээшлүүлэх	11	2	7	10	3	2
Хувиараа бүтээмж дээшлүүлэх	5	2	2	5	3	2

Хүснэгт 4в, 4г-д хувиараа явуулж буй үйл ажиллагаануудыг харууллаа. Өмнө нь дурдсанчлан, МБ-ийн бэлчээрийн менежмент, нүүдлийн үйл ажиллагаанууд орон нутгийн захиргааны удирдлага, дэмжлэгтэйгээр хийгддэг. Иймд МБ-тэй сум бүр өөрийн гэсэн БМТ-тэй байдаг. Мөн МБ-үүд сумын БМТ-нд тусгагдаагүй хамтын үйл ажиллагаануудыг явуулж байдаг. Жишээ нь, ямаа самнах, нүүж суухад нь бие биедээ туслах үйл ажиллагаанууд сумын БМТ-нд ордоггүй, харин тухайн МБ-ийн БМТ-нд ордог байна.

Энэ талаараа БАХ-ийн тогтолцоо МБ-ийнхээс ялгаатай байдаг. БАХ нь бүх малчдаа төлөөлдөг бөгөөд хамтын үйл ажиллагаа нь БАХ-ийн санаачлагаас хамаардаг. Амьдрал дээр бол сумын БМТ нь БАХ-үүдийн БМТ-нүүдийн нэгтгэл юм.

Хүснэгт 4в-д БАХ болон МБ-үүдийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын ерөнхий чиглэлийг харуулсан. Эндээс үзэхэд БАХ-тэй суманд БАХ-гүй сумыг бодоход харьцангуй өргөн хүрээний үйл ажиллагаа явуулжээ. Жишээ нь, зун, намрын бэлчээрийг

хуваарилаад зогсохгүй бэлчээрийг нийтээр эзэмших явдлыг хянах, баг хоорондын болон сум хоорондын нүүдлийг зохицуулж байна.

Хүснэгт 4д, 4е-д БАХ болон МБ-үүдийн хамтын үйл ажиллагаагаар хийгддэг бүтээмжийн үйл ажиллагаануудыг жагсаан харууллаа. Энэ хүснэгтэнд мөн бүтээмж дээшлүүлэх үйл ажиллагааны эрчимжилтийн 1-3 гэсэн оноог тооцож оруулсан болно. Гэхдээ дөнгөж санаачилж байгаа биш, харин эхлээд эрчимжилт нь 2 буюу 3 дугаар төвшинд хүрчихсэн үйл ажиллагаануудыг жагсаасан болно. Хэдийгээр үйл ажиллагааны тоог жагсааж хоёр тогтолцоог харьцуулж болох ч эрчимжилтийн төвшин хоёроос дээш гараад ирэхэд жинхэнэ ялгаа нь ажиглагдаж байна. МБ-үүд гол төлөв гурван үйл ажиллагааг хоёр буюу түүнээс дээш төвшинд гүйцэтгэсэн байхад БАХ-үүд 11 хүртэл үйл ажиллагаа гүйцэтгэсэн байна. Орон нутгийн иргэдийг идэвхжүүлж эхэлснээс хойших өнгөрсөн хугацаа нь үйл ажиллагааны хэрэгжилтийн төвшинд чухал нөлөө үзүүлж байгаа бөгөөд энэ ялгааг өндөр уулын бүсийн Цэнгэл, Дуут суман дээр харж болно. Дуут сумын хувьд үйл ажиллагаа нь эхлээд есхөн



сар болж байгаа бөгөөд санхүүжилт нь орж ирээгүй байсан бол Цэнгэл суманд үйл ажиллагаа нь эхлээд гурван жил болсон байлаа. Өөр нэг жишээ гэвэл тал хээрийн төвийн бүсийн Алтанбулаг сум ХБЦГ төсөлтэй 1994 оноос хойш хамтран ажиллаж байгаа. Гэтэл энд хамгийн олон үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд эрчимжилт нь хоёр буюу түүнээс дээш байх жишээтэй. Үүний адил Их тамир, Тэлмэн сум Ногоон алт төсөлтэй хамгийн удаан хамтран ажиллаж байгаа бөгөөд үйл ажиллагааны эрчимжилт нь бас л өндөр байна.

Хамтын үйл ажиллагаагаар явуулсан ажлуудын эрчимжилт тал хээрийн зүүн болон цөлөрхөг хээрийн бүсэд доогуур байгаа нь эдгээр бүсэд хамтын үйл ажиллагааны эрэлт бага байгааг харуулж байна.

Хамтын бус үйл ажиллагаагаар буюу хувиараа хийж болох ажлуудыг Хүснэгт 4е, 4ж-д үзүүлээ. Эдгээр үйл ажиллагаануудыг БАХ болон МБ-үүд нилээд муу хэрэгжүүлж байна. Гэхдээ БАХ-үүд бэлчээрийн болон хадлангийн талбайд үр цацах, хадлангийн талбайн чулуу түүх гэх мэтээр арай илүү үйл ажиллагаа явуулж байгаа нь ажиглагдлаа.

Хүснэгт 4в: МБ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд

Үйл ажиллагааны тоо, төрөл	Газар тариалан-мал аж ахуй			Тал хээрийн төв			Тал хээрийн зүүн				
	Өндөр уул	Улаан хус	Баянгол	Мандаг	Эрдэнэсант	Баян-Өнжүүл	Алтанбулаг	Матад	Баян-Уул	Цагаан-Овоо	Булган
	2	3	3	3	3	3	5	2	1	5	5
Бэлчээрийн менежмент, нүүдэл	1.МБ, сумын БМТ бий	1.МБ, сумын БМТ бий	1. МБ, сумын БМТ бий	1.МБ, сумын БМТ бий	1.МБ, сумын БМТ бий	1.МБ, сумын БМТ бий	1.МБ, сумын БМТ бий	1.МБ, сумын БМТ бий	1. МБ, сумын БМТ бий	1. МБ, сумын БМТ бий	1. МБ, сумын БМТ бий
	2.Улирлын сэлгээ хийдэг	2.Улирлын сэлгээ хийдэг	2. Зун, нам-рын бэлчээрийг хуваарилсан	2. Улирлын сэлгээ хийдэг	2. Улирлын сэлгээ хийдэг	2. Улирлын сэлгээ хийдэг	2. Өвөл, хаврын бэлчээр хуваарилдаг	2. Улирлын сэлгээ хийдэг		2.Өвөл, хаврын бэлчээр хуваарилдаг	2. Өвөл, хаврын бэлчээр хуваарилдаг
		3. Зөрчлийг бууруулдаг	3.Улирлын сэлгээ хийдэг	3. Зөрчлийг бууруулдаг	3.Өвөл, хаврын бэлчээр хуваарилдаг	3.Улирлын сэлгээ хийдэг	3.Улирлын сэлгээ хийдэг			3. Зун, намрын бэлчээр хуваарилсан	3. Зун, намрын бэлчээр хуваарилсан
							4.Сум хоорон-дын нүүдлийг зохицуулахад оролцдог			4.Улирлын сэлгээ хийдэг	4. Улирлын сэлгээ хийдэг
							5.Зөрчлийг бууруулдаг			5.Зөрчлийг бууруулдаг	5.Зөрчлийг бууруулдаг

Дээрх үйл ажиллагаануудын ихэнхийг орон нутгийн захиргаа санаачилж, хэрэгжилтэнд нь оролцдог. МБ-ийн БМТ-өөс бусад аль ч үйл ажиллагааг МБ өөрсдөө бие даан хийдэггүй байна.

Хүснэгт 4г: БАХ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд

Үйл ажиллагааны тоо, төрөл	Өндөр уул		Ойт хээр		Тал хээрийн төв	Цөлөрхөг хээр
	Цэнгэл	Дуут	Их тамир	Тэлмэн	Өндөр ширээт	Өлзийт
	8	8	8	7	5	6
Бэлчээрийн менежмент, нүүдэл	1. БАХ, сумын БМТ бий	1. БАХ, сумын БМТ бий	1. БАХ, сумын БМТ бий	1. БАХ, сумын БМТ бий	1. БАХ, сумын БМТ бий	1. БАХ, сумын БМТ бий
	2. БАХ-ийн газар нутгийг тодорхойлсон	2. БАХ-ийн газар нутгийг тодорхойлсон	2. БАХ-ийн газар нутгийг тодорхойлсон	2. БАХ-ийн газар нутгийг тодорхойлсон	2. БАХ-ийн газар нутгийг тодорхойлсон	2. БАХ-ийн газар нутгийг тодорхойлсон
	3. Өвөл, хаврын бэлчээрийг БАХ-үүд хуваарилсан	3. Өвөл, хаврын бэлчээрийг БАХ-үүдэд хуваарилсан	3. Өвөл, хаврын бэлчээрийг БАХ-үүдэд хуваарилсан	3. Өвөл, хаврын бэлчээрийг БАХ-үүдэд хуваарилсан	3. Өвөл, хаврын бэлчээрийг БАХ-үүдэд хуваарилсан	3. Өвөл, хаврын бэлчээрийг БАХ-үүдэд хуваарилсан
	4. Зун, намрын бэлчээрийг хуваарилсан	4. Зун, намрын бэлчээрийг хуваарилсан	4. Зун, намрын бэлчээрийг хуваарилсан	4. Зун, намрын бэлчээрийг хуваарилсан	4. Зун, намрын бэлчээрийг хуваарилсан	4. Зун, намрын бэлчээрийг хуваарилсан
	5. Улирлын сэлгээ хийдэг	5.Улирлын сэлгээ хийдэг	5. Улирлын сэлгээ хийдэг	5. Улирлын сэлгээ хийдэг	5. Улирлын сэлгээ хийдэг	5. Сум хоорондын нүүдлийг зохицуулсан
	6.Сум хоорондын нүүдлийг зохицуулсан	6. Сум хоорондын нүүдлийг зохицуулсан	6. Сум хоорондын нүүдлийг зохицуулсан	6. Сум хоорондын нүүдлийг зохицуулсан	6. Сум хоорондын нүүдлийг зохицуулсан	6. Зөрчлийг бууруулдаг
	7. Баг хоорондын нүүдлийг зохион байгуулдаг	7. Баг хоорондын нүүдлийг зохион байгуулдаг	7. Баг хоорондын нүүдлийг зохион байгуулдаг	7.Зөрчлийг бууруулдаг	2	
	8. Зөрчлийг бууруулдаг	8. Зөрчлийг бууруулдаг	8. Зөрчлийг бууруулдаг			
	Орон нутгийн захиргааны дэмжлэгтэйгээр БАХ-үүд өөрсдөө ихэнхийг нь хийдэг.					



Хүснэгт 4д: МБ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд

Үйл ажиллагааны тоо, төрөл	Өндөр уул	Газар тариалан-мал аж ахуй		Тал хээрийн төв			Тал хээрийн зүүн			
	Улаан хус	Баянгол	Мандал	Эрдэнэсант	Баян-Өнжүүл	Алтанбулаг	Ма-тад	Баян-Уул	Цагаан-Овоо	Бул-ган
Хамтын үйл ажиллагаагаар бүтээмж дээшлүүлэх Эрчимжилтийн төвшин 2-оос дээш гарсан үйл ажиллагаануудыг оруулав.	7 1. Отрын бэлчээр бий болгосон	4 1. Хадлангийн талбай бий болгосон	5 1. Хадлангийн талбай бий болгосон 2. Дарш, тэжээл тариалсан	4 1.Отрын талбай бий болгоход ихээхэн оролцдог 2. Хадлангийн талбайг хашсан 3.Худаг засварлаж, шинээр гаргасан	3 1.Хадлангийн талбай бий болгосон 2.Худаг засварлаж, шинээр гаргасан 3.Царцаа, хортон, мэрэгчтэй тэмцсэн	4 1. Отрын бэлчээр бий болгосон 2.Хадлангийн талбай бий болгосон 3.Царцаа, хортон, мэрэгчтэй тэмцсэн 4.Худаг засварлаж, шинээр гаргасан	2	3	4	5

Хүснэгт 4е: БАХ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд

Үйл ажиллагааны тоо, төрөл	Өндөр уул		Ойт хээр		Тал хээрийн төв	Цөлөрхөг хээр
	Цэнгэл	Дуут	Их тамир	Тэлмэн	Өндөр ширээт	Өлзийт
Хамтын үйл ажиллагаагаар бүтээмж дээшлүүлэх Эрчимжилтийн төвшин 2-оос дээш гарсан үйл ажиллагаануудыг оруулав	11 1. Отрын бэлчээр бий болгосон 2. Хадлангийн талбай бий болгосон 3. Хадлангийн талбайг хашсан 4. Услалтын системийг сайжруулж, шинээр бий болгосон 5. Өнжөөх талбайг тодорхойлсон 6. Бэлчээрт мод, бут тарьсан 7. Худаг засварлаж, шинээр гаргасан 8. Уулын замыг сайжруулсан, шинээр гаргасан 9. Үүл буудаж бороо оруулсан 10. Малын тоог хязгаарлах тухай ярилцсан 11. Царцаа, хортон, мэрэгчтэй тэмцсэн	2 Бүх үйл ажиллагааны эрчим-жилтийн төвшин 1 дээр байна	7 1. Отрын бэлчээр бий болгосон 2. Хадлангийн талбай бий болгосон 3. Хадлангийн талбайг хашсан 4. Өнжөөх талбайг тодорхойлсон 5. Бэлчээрт мод, бут тарьсан 6. Худаг засварлаж, шинээр гаргасан 7. Уулын замыг сайжруулсан, шинээр гаргасан	10 1. Отрын бэлчээр бий болгосон 2. Хадлангийн талбай бий болгосон 3. Хадлангийн талбайг хашсан 4. Услалтын системийг сайжруулж, шинээр бий болгосон 5. Өнжөөх талбайг тодорхойлсон 6. Бэлчээрт мод, бут тарьсан 7. Худаг засварлаж, шинээр гаргасан 8. Уулын зам шинээр гаргасан 9. Царцаа, хортон, мэрэгчтэй тэмцсэн	3 1. Хадлангийн талбай бий болгосон 2. Хадлангийн талбайг хашсан 3.Царцаа, хортон, мэрэгчтэй тэмцсэн	2

Хүснэгт 4е: МБ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд

Үйл ажиллагааны тоо, төрөл	Өндөр уул	Газар тариалан-мал аж ахуй		Тал хээрийн төв			Тал хээрийн зүүн			
	Улаан хус	Баянгол	Мандал	Эрдэнэсант	Баян-Өнжүүл	Алтанбулаг	Матад	Баян-Уул	Цагаан-Овоо	Булган
Хувиараа бүтээмж дээшлүүлэх Эрчимжилтийн төвшин 2-оос дээш гарсан үйл ажиллагаануудыг оруулав	4	4	4	3	1	1	1	2	1	3
		1.Хадлангийн талбайн чулуу түүх		1. Мал вакцинжууах 2. Малын чанарыг дээшлүүлэх 3. Тэжээлийн ургамал тариалах	1.Мал вакцин-жууах	1.Мал вакцинжууах	1.Мал вакцин-жуулах			



Хүснэгт 4ж: БАХ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд

Үйл ажиллагааны тоо, төрөл	Өндөр уул		Ойт хээр		Тал хээрийн төв	Цөлөрхөг хээр
	Цэнгэл	Дуут	Их тамир	Тэлмэн	Өндөр ширээт	Өлзийт
Хувиараа бүтээмж дээшлүүлэх Эрчимжилтийн төвшин 2-оос дээш гарсан үйл ажиллагаануудыг оруулав	5 1. Хадлангийн талбайн чулуу түүх 2. Мал вакцинжуулах	2 Бүх үйл ажиллагаануудын эрчимжилтийн төвшин 1 дээр байна	2 1. Мал вакцинжуулах	5 1. Хадлангийн талбайн чулуу түүх 2. Тэжээлийн ургамал тариалах 3. Бэлчээр болон хадлангийн талбайд үр цацах 4. Мал вакцинжуулах 5. Малын чанарыг дээшлүүлэх	3 1. Тэжээлийн ургамал тариалах 2. Бэлчээр болон хадлангийн талбайд үр цацах 3. Мал вакцинжуулах	2

Хүснэгт 4з: МБ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд

Бүс	Хамгийн их дурдагдсан гурван хүндрэл (дурдагдсан тооны дарааллаар)
Өндөр уул	- мөнгө, - гишүүдийн санаачлага, оролцоо – арга зүйн зөвлөгөө болон орон нутгийн захиргааны туршлагагүй байдал
Тал хээрийн төв	- мөнгө, - арга зүйн зөвлөгөө - гишүүдийн санаачлага, оролцоо, байгаль өөрөө шахаж байна, зах зээлийн боломж муу, суманд отрын болон хадлангийн талбай хомс, усны хомсдол
Тал хээрийн зүүн	- мөнгө, - арга зүйн зөвлөгөө, - үнийн уналт, төсөл дууссаны дараа идэвхжүүлэгч байгууллага байхгүй болдог
Орон нутгийн захир-гааны санаачлагатай газар тариалан-мал аж ахуй	- арга зүйн зөвлөгөө, - мөнгө, - гишүүдийн санаачлага, оролцоо
Орон нутгийн захиргаа-ны санаачлагатай газар тариалан-мал аж ахуй	- гишүүдийн санаачлага, оролцоо, - гишүүдийн доторх зөрчил, - арга зүйн зөвлөгөө

Хүснэгт 4и: БАХ-ийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд

Бүс	Хамгийн их дурдагдсан гурван хүндрэл (дурдагдсан тооны дарааллаар)
Өндөр уул	- гишүүдийн санаачлага, оролцоо, - мөнгө, арга зүйн тусалцаа, орон нутгийн захиргааны туршлагагүй байдал, нэмэгдэл бэлчээрийн хомсдол
Ойт хээр	- арга зүйн тусалцаа, - гишүүдийн санаачлага, оролцоо, цаг, багаль орчны нөлөө, орон нутгийн захиргааны хүнд суртал, бэлчээр болон хадлангийн талбай хүрэлцээгүй, бэлчээрийн доройтол
Тал хээрийн төв	- арга зүйн тусалцаа, - гишүүдийн санаачлага, оролцоо, - усны хомсдол, орон нутгийн засаг даргын гэрээг зөрчдөг
Цөлөрхөг хээр	- усны хомсдол, - гишүүдийн санаачлага, оролцоо, - бэлчээрийн доройтол

Хүснэгт 4з, 4и-д малчдын байгууллагын үйл ажиллагаанд гардаг хүндрэлүүдийг харуулав. Малчдын байгууллагыг байгуулж, үйл ажиллагаагаа явуулахад нь гардаг ерөнхий хүндрэлүүд дотроос бэлчээрийн менежмент, малын ашиг шимийг дээшлүүлэхэд гардаг хүндрэлүүд нь нилээд нийтлэг байдаг байна. Үүнд бүх бүсэд арга зүйн зөвлөгөө үгүйлэгдэж байхад түүний дараа гишүүдийн идэвх, оролцоо орж байна. Бүс бүрийн өөрийн онцлогоос хамаарч зарим бэрхшээл өөр өөр байна. Өндөр уулын болон тал хээрийн төвийн бүсийнхэн мөнгө чухал гэж үзэж байхад тал хээрийн төвийн болон зүүн, газар тариалан-мал аж ахуй хосолсон бүсүүдэд малын усны хомсдол, малын гаралтай бүтээгдэхүүний үнийн уналт, төсөл дууссаны дараа идэвхжүүлэгч байгууллага үгүй болдог, гишүүн бүсчүүдтэй үүсдэг зөрчил гэж нэрлэжээ.

БАХ-ийн үйл ажиллагааг явуулахад гардаг хүндрэлүүд нь БАХ байгуулахад гардаг хүндрэлүүдтэй харьцуулшгүй нийтлэг байна. Энэ нь БАХ байгуулахаас түүний үйл ажиллагааг удирдан авч явах нь илүү хэцүү гэдгийг харуулж байна. Гишүүдийн санаачлага, арга зүйн зөвлөгөөний хомсдол БАХ болон МБ-ийн аль алины үйл ажиллагаанд муугаар нөлөөлдөг ажээ. Мөнгө өндөр уулын бүсийн хүндрэл байхад байгалийн гамшиг ойт хээрийн бүсэд ихээхэн

хүндрэл учруулдаг гэж судалгаанд хамрагдагсд үзжээ. Харин усны хомсдол тал хээрийн төв болон цөлөрхөг хээрийн бүсийн хүндрэл болж байна.

Дүгнэлт

1. Малчдын сайн дурын бүлэгтэй харьцуулахад БАХ бэлчээрийн менежмент, нүүдлийн асуудлыг зохицуулахад илүү тохиромжтой.
2. БАХ-үүд эдийн засгийн үйл ажиллагаанаас илүү бэлчээрийн менежментийн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулдаг байхад МБ-үүд эдийн засгийн үйл ажиллагаанд илүү анхаардаг байна.
3. Хэдийгээр БАХ-үүд эдийн засгийн үйл ажиллагаанаас илүү бэлчээрийн менежментийн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулдаг ч хэрэгжүүлж буй эдийн засгийн цөөхөн үйл ажиллагааных нь эрчимжилтийг аваад үзэхэд МБ-ийнхээс хавьгүй илүү байна.
4. МБ, БАХ-ийн хэрэгжүүлсэн ажлын тоо нь түүний ажилласан хугацаанаас шууд хамаарч байна.
5. Цөлөрхөг хээрийн бүсэд хамтын үйл ажиллагаагаар хийсэн ажил бага байгаа нь тус бүсэд БАХ-ийн тогтолцоо тохиромж муутайг харуулж байна. Иймд цаашид энэ бүсэд БАХ-



ийн анхаарч ажиллах асуудлуудыг дахин тодорхойлж, тал хээрийн төвийн бүсийн сум болон аймаг хоорондын холбоог сайжруулах шаардлагатай байна.

6. Хамтын үйл ажиллагаа шаарддаг ажлууд дээр орон нутгийн захиргааны идэвхжүүлэх дэмжлэгийг хүлээх нь хүрэлцээтэй нөхцөл болж чадахгүй.
7. Хамтын үйл ажиллагааны тогтолцооноос үл хамаарч малчдын байгууллага байгуулахаас түүний үйл ажиллагааг авч явах нь илүү бэрхшээлтэй байдаг байна.

Байгууллагын үр дүн, тогтвортой байдалд гарсан дэвшил

Энэ хэсгийн хүснэгтүүдэд МБ болон БАХ-үүдийн ажлын үр дүн, тогтвортой байдлыг Хоёрдугаар бүлэгт тодорхойлсон 13 шалгуурт үндэслэн үнэллээ. Эдгээрээс гадна тухайн МБ, БАХ зах зээлд гарах чадвараа дээшлүүлэх чиглэлээр хамтран ажилласан эсэхийг шалгалаа. Үр дүн, тогтвортой байдлыг дөрвөн өөр түвшнээр тодорхойлсон юм. Үүнд: хүчтэй, сайн, үүсэж байгаа, үгүй (хэрэв ямар ч хамтын үйл ажиллагаа хийгдээгүй бол). Үр дүн, тогтвортой байдлын ойлголтыг судалгаанд оролцогсдод өгсний дараа тэдний хариултанд үндэслэн үнэлгээ өглөө. Хүчтэй, сайн гэсэн хоёр үзүүлэлтийг хангалттай гэж үзлээ.

Малчдын бүлэг

Хүснэгт 5а-д үзүүлсэнчлэн бүсийн онцлогоос хамааран нэгээс гурван шалгуур хангалттай биелсэн байна. Хамгийн бага нь өндөр уулын бүсэд, хамгийн өндөр нь тал хээрийн зүүн бүсэд байлаа. Хамгийн нийтлэг хангалттай биелсэн шалгууруудад МБ-ийн журам, дүрэм, тэдгээрийн биелэлт, үр шимээ хэрхэн хуваарилах талаар бүх гишүүд зөв бөгөөд жигд ойлголттой эсэх, улс төрийн ар тал орж байна. Хэдийгээр МБ-үүд өөр өөр суманд байдаг боловч үр ашгаа хуваах талаар ойлголт сайтай байлаа. Харин маш цөөхөн, ялангуяа тал хээрийн зүүн бүсийн, МБ-үүд орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлсэн байлаа.

Нилээд хэдэн суманд МБ-үүд 4-11 гэсэн тогтвортой байдлын нөхцөлүүд дээр үүсэж байгаа гэсэн үзүүлэлттэй гарч байлаа. Энэ нь МБ-үүд эдгээр үзүүлэлтийг хангах талаар наад зах нь бага сага юм хийж байна гэсэн үг юм. Үүсэж байгаа гэдэг дээр МБ-үүдийн дүрэм журам, эргэлтийн сан, улс төрийн ар тал болон улс төрийн нөлөө гэсэн шалгуурууд орж байна. Улс төрийн ар тал гэдэг нь МБ-үүд орон нутгийн иргэдийн хуралд МБ-үүдийг дэмждэг төлөөлөлтэй эсэх, харин улс төрийн нөлөө гэдэгт аймгийн ИТХ болон УИХ-ын гишүүдээс дэмжлэгтэй эсэх асуудлуудыг хэмжлээ.

Үүсэж байгаа гэсэн үнэлгээ хамгийн их авсан бүсэд тал хээрийн зүүн болон газар тариалан-мал аж ахуй хосолсон бүсүүд орж байна. Өндөр уулын бүс энэ үнэлгээнд хамгийн дор орсон байна. МБ-үүдийн

хамгийн сул байгаа үзүүлэлтүүд нь төлөвлөгөө болон үйл ажиллагаандаа хүлээж буй хариуцлага, гишүүн бусчуудтай харилцах тодорхой харилцаа, санхүүгийн хариуцлага орж байгаа бөгөөд зах зээлд хамтран нэвтрэх боломж ялангуяа өндөр уулын бүсэд доогуур байлаа. Эдгээр үнэлгээний үр дүнд гарч буй хэлбэлзлийг тайлбарлах боломж хомс байна.

Бэлчээр ашиглагчдын хэсэг

Хүснэгт 5б-д үзүүлсэнээр БАХ-үүдийн хувьд харьцангуй олон үзүүлэлт хангалттай гэсэн үнэлгээ авлаа. Тал хээрийн төвийн бүсэд 2, ойт хээрийн бүсэд 12, араас нь өндөр уулын бүс, дараа нь цөлөрхөг хээрийн бүс орж байна. БАХ-ийн тогтолцоо хэрэгжиж эхлээд нэг их удаагүй бол энэ тогтолцоо олон жил хэрэгжиж буй газруудаасаа харьцангуй цөөн үзүүлэлтүүд дээр хангалттай гэсэн үнэлгээ авч байна. Ногоон алтын БАХ-ийн тогтолцоо 2005 оноос эхлэн хэрэгжиж байгаа боловч тал хээрийн төвийн болон өндөр уулын Дуут суманд хоёр жилээс бага хугацаагаар хэрэгжиж байгаа юм. Харин Дуут суманд тогтвортой байдлын үнэлгээ хүлээж байснаас сайн гарч байгаа нь тэдний удирдлага нилээд хүчтэйд оршиж байна гэж үзэж байна. Манай шинжилгээнээс үзэхэд удирдлага нь хүчтэй, мөн орон нутгийн захиргаатайгаа (улс төрийн ар талыг үз) сайн хамтран ажиллаж чадвал БАХ-ийн үр дүн, тогтвортой байдлын үзүүлэлтэнд эерэг нөлөөтэй гэж дурдаж байсныг баталж байна. Тал хээрийн төвийн бүсэд БАХ-ийн тогтолцоо үүсэж эхлээд хоёрхон жил болж байгаа бөгөөд ихэнх үзүүлэлт үүсэж байгаа гэж гарч байгаа тул тогтвортой байдлын шинжилгээнд үндэслэн энэ бүсэд БАХ-ийн тогтолцоо тохиромжтой эсэхийг хэлэхэд бэрхшээлтэй юм.

Бүх бүсэд хамгийн муу биелэгдэж буй шалгуурт санхүүгийн хариуцлага, гишүүн бусчуудтай харилцах тодорхой харилцааны арга, зах зээлд хамтран гарах асуудлууд орж байна. Иймд төслүүд эдгээр асуудалд илүү анхаарах шаардлагатай нь тодорхой юм. Ойт хээрийн бүсийн Тэлмэн сум ихэнх шалгуурыг хангаж байгаа төдийгүй бусад БАХ-үүд унаад байгаа санхүүгийн хариуцлага, тогтвортой байдал, удирдлагын чадавхийн шалгууруудыг ч хангаж байна.

Дүгнэлт

1. Цөлөрхөг хээрийн бүсээс бусад бүсэд үр дүн, тогтвортой байдлын шалгууруудыг БАХ-үүд МБ-үүдээс хавьгүй илүү хангаж байна.
2. БАХ болон МБ-т гарч буй нийтлэг дутагдалд санхүүгийн хариуцлага, гишүүн бусчуудтай харилцах харилцаа, зах зээлд нэвтрэх боломж гэсэн үзүүлэлтүүд орж байна.
3. Сайн манлайлал, орон нутгийн захиргаатай ажлын сайн харилцаатай байх нь БАХ-ийн тогтвортой байдалд эерэг нөлөөтэй.
4. Ойт хээрийн бүсийн Тэлмэн сум ихэнх шалгуурыг, ялангуяа бусад БАХ-үүд унаад байгаа шалгууруудыг хангаж байгаа тул үзүүлэх (үлгэр жишээ) БАХ болгож болох юм.



Хүснэгт 5а: МБ-ийн үр дүн, тогтвортой байдал

Үр дүн, тогтвортой байдлын шалгуур	Өндөр уул		Газар тариалан-мал аж ахуй		Тал хээрийн төв			Тал хээрийн зүүн			
	Улаан хус	Дөргөн	Баян-гол	Мандал	Эрдэнэсант	Баян-Өнжүүл	Алтан-булаг	Матад	Баян-Уул	Цагаан-Овоо	Булган
Сайн	1	1	2	1	1	2	2	1	2	3	3
Үүсэж байгаа	4	5	10	9	9	8	8	9	8	8	7
Байхгүй	9	8	3	4	4	4	4	4	4	3	4
Үүргээ гүйцэтгэх	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Дүрэм, журам	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Сайн	Сайн	Үүсэж байгаа	Сайн	Сайн	Сайн
Гишүүн бусчуудтай тодорхой харилцаа	Байхгүй	Байхгүй	Сайн	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Үүсэж байгаа	Байхгүй
Төлөвлөгөө, үйл ажиллагааны хариуцлага	Байхгүй	Байхгүй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй
Санхүүгийн хариуцлага	Байхгүй	Байхгүй	Үүсэж байгаа	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй
Манлайлал	Байхгүй	Байхгүй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Чадавх	Байхгүй	Байхгүй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Санхүүгийн тогтвортой байдал	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Эргэлтийн сан	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Үйл ажиллагааны гарын авлага	Байхгүй	Байхгүй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Үр шимийг хуваах	Тэнцүү	Тэнцүү	Тэнцүү	Тэнцүү	Тэнцүү (оруулсан хувь)	Тэнцүү	Тэнцүү	Тэнцүү	Тэнцүү	Хөдөлмөрөөр	Хөдөлмөрөөр
Улс төрийн ар тал	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Сайн	Сайн
Улс төрийн нөлөө	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Байхгүй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Зах зээлийг дээшлүүлэх	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй

Хүснэгт 5б: БАХ-ийн үр дүн, тогтвортой байдал

Үр дүн, тогтвортой байдлын шалгуур	Өндөр уул		Ойт хээр		Тал хээрийн төв	Цөлөрхөг хээр
	Цэнгэл	Дуут	Их тамир	Тэлмэн	Өндөр ширээт	Өлзийт
Сайн	10	8	7	12	2	5
Үүсэж байгаа	3	2	6	1	9	6
Байхгүй	1	4	1	1	3	3
Үүргээ гүйцэтгэх	Сайн	Сайн	Сайн	Хүчтэй	Үүсэж байгаа	Сайн
Дүрэм, журам	Хүчтэй	Сайн	Сайн	Хүчтэй	Сайн	Сайн
Гишүүн бусчуудтай тодорхой харицаа	Сайн	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Сайн
Төлөвлөгөө, үйл ажиллагааны хариуцлага	Сайн	Сайн	Сайн	Хүчтэй	Үүсэж байгаа	Байхгүй
Санхүүгийн хариуцлага	Үүсэж байгаа	Байхгүй	Сайн	Хүчтэй	Байхгүй	Үүсэж байгаа
Манлайлал	Хүчтэй	Хүчтэй	Үүсэж байгаа	Хүчтэй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Чадавх	Хүчтэй	Хүчтэй	Сайн	Сайн	Үүсэж байгаа!	Үүсэж байгаа!
Санхүүгийн тогтвортой байдал	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Хүчтэй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Эргэлтийн сан	Сайн	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Сайн	Үүсэж байгаа	Сайн
Үйл ажиллагааны гарын авлага	Үүсэж байгаа	Байхгүй	Сайн	Сайн	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Үр шимийг хуваах	Тэнцүү ба оролцоо	Тэнцүү	Хөдөлмөрөөр	Хөдөлмөрөөр	Тэнцүү	Тэнцүү
Улс төрийн ар тал	Хүчтэй	Хүчтэй	Үүсэж байгаа	Хүчтэй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа
Улс төрийн нөлөө	Сайн	Сайн	Үүсэж байгаа	Хүчтэй	Үүсэж байгаа	Байхгүй
Зах зээлийг дээшлүүлэх	Байхгүй	Байхгүй	Үүсэж байгаа	Үүсэж байгаа	Байхгүй	Байхгүй



Хүндрэлтэй үед БАХ-ийн нутаг дэвсгэрээс гадагш нүүх

Цаг хэцүү болоход бусдын бэлчээр рүү нүүх нь чухал боловч хүндрэлтэй асуудлууд гардаг. Монголын зарим газар нутаг, ялангуяа тал хээрийн төвийн бүс нутаг нүүдлийн хөлд ихээр дарагдах болжээ. Хүснэгт ба, 6б-ээс үзэхэд жилийн дөрвөн улирлын аль ч улиралд сумын дотор болон сум хооронд нүүхэд бараг зөвшөөрөл шаардагддаггүй бөгөөд зөвхөн өвөл, хавар хоёрт өвөлжөө, хаваржааны эзнээс зөвшөөрөл авах тохиолдол хааяа нэг гарч байсан байна. Зарим нөхцөлд сум хоорондын нүүдлийг зохицуулахад холбогдох сумын засаг дарга нар жил жилээр гэрээ байгуулан ажилладаг байна. МБ болон БАХ-ийн аль аль нь нүүдлийг хянаж чадахгүй байна. Харин Дуут сумын хувьд БАХ-үүд нь хөрш дөрвөн сумаас орж ирдэг нүүдлийг сумын захиргаатайгаа хамтран зогсоох тал дээр ажилласан байна. Ингэсний үр дүнд гурван сумын орж ирдэг нүүдлийг зогсоож, нэг сумтай нь харилцан улирлын чанартай нүүдлийг солилцон хийх гэрээ байгуулж чаджээ. Ногоон алтын бусад суманд БАХХ энэ асуудлыг зохицуулах гэж орон нутгийн захиргаатайгаа маш их хамтарч ажилладаг ч Дуутаас бусад нь ямар ч шийдэлд хүрээгүй байна.

Судалгаанд хамрагдагсад хариулахдаа МБ болон БАХ-ийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө бэлчээр муудаж, ус ховордож хол нүүх шаардлага гарсан үед өөрийн нутгийн хилээс гарч нүүхэд хүндрэл

учруулна гэж үзэж байна. Энэ талаар санаа зовохгүй байгаа малчид бол Дуут сумын малчид юм. Хамгийн их санаа зовоож буй зүйл бол гамшиг тохиосон үед бидний мөрдөх ёстой хууль дүрэм нүүдэлд садаа болох явдал юм гэжээ. Гэвч судалгаанд хамрагдагсад үүнийг зохицуулах олон арга зам байж болно гэдэгт итгэлтэй байна. Жишээ нь гэхэд орон нутгийн захиргаад хоорондоо гэрээ хийж суурин болон хагас суурин аж ахуйнуудыг өөрийн бэлчээрийн даацад тохируулан хөгжүүлбэл мал аж ахуйн салбарыг бага эрсдэлтэй авч явж болох юм.

Дүгнэлт

1. Сум хоорондын нүүдэл ихэнх газарт хүндрэлтэй асуудал болдоггүй бөгөөд нүүхэд бараг зөвшөөрөл шаардагддаггүй байна. Сум хоорондын нүүдэл Дуут суманд ихээхэн хүндрэл авчирдаг байсан боловч орон нутгийн захиргаад хэлэлцсэний үр дүнд БАХХ-ны оролцоотойгоор шийдэгдсэн байна.
2. Гаднаас малчид нүүж ирэх нь бэлчээрийн доройтлыг бий болгодог тул нилээд ноцтой асуудал гэж малчид үзэж байна.
3. Ихэнх суманд малчид ирээдүйд нүүхэд улам хүнд болно гэж байгаа ч энэ байдлыг зохицуулж болно гэж үзэж байна.
4. Аймаг, сумын засаг дарга нарын оролцоо зарим тохиолдолд улирлын нүүдлийг зохицуулахад ихээхэн чухал ач холбогдолтой байна.

Хүснэгт 6а: Хэцүү үед МБ-ийн нутаг дэвсгэрээс гадагш нүүх

Бүс	Сум	Гадны малчид зун, намарт нүүж ирэх		Гадныхан өвөл, хаварт нүүж ирэх			Ирээдүйд нүүхэд хэцүү болох уу?		Нүүхэд гардаг асуудлуудыг яаж зохицуулах вэ?
		Зөвшөөрөл	Хүндрэл	Зөвшөөрөл	Хүндрэл	Яаж шийдсэн	Тийм, үгүй	Яагаад	
Өндөр уул	Улаан хус	Үгүй	Үгүй	Гадныхан ирдэггүй	Үгүй	Байхгүй	Тийм	Нүүх газар байхгүй	Нүүдэл хийхгүй
	Дөргөн	Баг/сумын засаг дарга ярьдаг	Үгүй, зундаа бид бас тэдний нутаг руу нүүдэг	Баг/сумын засаг дарга зөвшөөрөл өгдөг	Үгүй	Байхгүй	Тийм	Бэлчээр байхгүй	Сумын дарга бусадтай ярьж зохицуулна
Газар тариалан-мал аж ахуй хосолсон	Мандал	Үгүй	Баруун талаас малчид нүүж ирж байнга суурьшдаг	Үгүй	Бэлчээр ашиглалт	Шийдэл байхгүй. Аймгийн дарга гадны малчдыг аймгийн нутаг руу оруулахгүй байхыг тушаасан	Тийм	Баруун талаас малчид нүүж ирж байнга суурьшдаг	Асуугаагүй
	Баянгол	Үгүй	Баруун талаас малчид нүүж ирж байнга суурьшдаг	Үгүй	Бэлчээр ашиглалат	Шийдэл байхгүй. Малчдыг малгүй нүүж ирээд орон нутгаас мал авахыг зөвшөөрдөг	Тийм	Баруун талаас малчид нүүж ирж байнга суурьшдаг	Бүгд эрчимжсэн фермер болно
Тал хээрийн төв	Эрдэнэсант	Үгүй	Отрын нүүдэл дамжин өнгөрдөг	Үгүй	Бэлчээр ашиглалтад муу. Отрын шилжилтийн нутаг	Орон нутгийн захиргаанд гомдол гаргадаг	Тийм	Бусдын нутагт бидэнд бэлчээр байхгүй	Мэдэхгүй
	Баян-Өнжүүл	Үгүй	Бид бас бусдын нутаг руу нүүдэг болохлоор тэдэнтэй найрсаг байдаг	Манай болон хөрш сумуудын малчид зөвшөөрөлгүй шууд нүүж ирдэг	Тэд бэлчээрийг муутгадаг	Зарим нь ойлгоод буцдаг ч зарим нь тэр чигээрээ удаан хугацаагаар байдаг	Тийм	Тэд бусдын малыг бэлчээр дээрээ мэдээж байлгахгүй	Бэлчээрээ сайн хамгаалах ёстой. Манай суманд бэлчээр хуваарилах бололцоо байхгүй
	Алтанбулаг	Үгүй	Отрын нүүдэл дайрдаг тул бэлчээр доройтож байна	Үгүй	Бэлчээр доройтож байна	Бидэнд мэдэгдэхгүйгээр багийн дарга гадны малчдыг оруулдаг	Тийм	Бусдын бэлчээр рүү нүүх бололцоо байхгүй	Малчид зөвшилцөж чадахгүй бол орон нутгийн захиргаанаас нь зөвшөөрөл авах ёстой болно.



Тал хээрийн зүүн	Матад	Үгүй	Бэлчээр доройтуулдаг	Үгүй	Бэлчээр доройтуулж, зөрчил үүсгэдэг	Шийдэгдээгүй	Тийм	Тэд бэлчээрээ ашиглуулахгүй	Мэдэхгүй
	Баян-Уул	Үгүй	Маш олон адуу ирж бэлчээр доройтуулдаг	Үгүй	Бэлчээр доройтуулдаг	Шийдэгдээгүй	Тийм	Тэд бэлчээрээ ашиглуулахгүй	Асуудал биш
	Цагаан-Овоо	Үгүй	Бэлчээр доройтуулж, малчидтай зөрчил үүсгэдэг	Үгүй	Бэлчээр доройтуулдаг	Шийдэгдээгүй	Тийм	Тэд бэлчээрээ ашиглуулахгүй	Орон нутгийн захиргаанаас тусламж эрнэ
	Булган	Үгүй	Бэлчээр доройтуулдаг	Үгүй	Бэлчээр доройтуулдаг	Шийдэгдээгүй	Тийм	Тэд бэлчээрээ ашиглуулахгүй	Малын тоог бэлчээрийн даацад нь тохируулах ёстой. Суманд нөөц бэлчээр байх ёстой.

Хүснэгт 66: Хэцүү үед БАХ-ийн нутаг дэвсгэрээс гадагш нүүх

Бүс	Сум	Гадны малчид зун, намарт нүүж ирэх		Гадныхан өвөл, хаварт нүүж ирэх			Ирээдүйд нүүхэд хэцүү болох уу?		Нүүхэд гардаг асуудлуудыг яаж зохицуулах вэ?
			Хүндрэл	Зөвшөөрөл	Хүндрэл	Яаж шийдсэн	Тийм үгүй	Яагаад	
Өндөр уул	Цэнгэл	Үгүй	Үгүй	Гадныхан ирдэггүй	Тэд бэлчээр ашигладаг	Маргана, амаар зөвшилцөнө	Тийм	Бүх бэлчээр эзэнтэй болсон	Орон нутгийн малчидтай ярилцана, аймгийн захиргаа зохицуулалт хийнэ
	Дуут	Нэг сумаас бусад нь нүүж ирэхээ больсон	Тэд бэлчээр их сүйтгэдэг	Сумын төвшинд зөвшилцдөг	Манай малчдын бэлчээрийг идэж, доройтол үүсгэдэг	Сумын захиргаа гэрээ хийсэн	Үгүй	Бүх юм зохицуулалт-тай болчихно.	Асуудалгүй
Ойт хээр	Их тамир	Үгүй	Мэдэхгүй	Үгүй	Бидний газраас хадлан хаддаг	Шийдэл олоогүй байна. Нүүж ирсэн малчид хүний эрх ярьдаг	Тийм	Өөрийн мал өөрийн бэл-чээр дээр байх ёстой	Тэдний бэлчээрт төлбөр төлнө. Аймаг, сумын удирдлагууд ярих ёстой
	Тэлмэн	Үгүй	Мэдэхгүй	Үгүй	Бид өөрсдөө бэлчээргүй байхад тэд ирдэг	Буцаж нүүхийг шаарддаг ч амжилт байхгүй	Тийм	Өвөл л хэцүү байх	Бусадтай гэрээ хийнэ
Тал хээрийн төв	Өндөр ширээт	Үгүй	Бэлчээр ихээр доройтуулж зөрчил үүсгэдэг	Бидэнтэй зөвшилцөхгүйгээр аймгийн болон бусад том удирдлагууд зөвшөөрөл өгчихдөг	Бэлчээр муутгадаг, зөрчил үүсгэдэг	Шийдэл байхгүй, зарим нь буцаад нүүдэг ч зарим нь нүүдэггүй	Тийм	Улам их зөрчил үүсэх болно	Орон нутгийн захиргаатай нь ярина
Цөлөрхөг хээр	Өлзийт	Үгүй	Бидний бэлчээрийг сүйтгэдэг	Үгүй	Үгүй	Тэдэнтэй учраа олохыг хичээдэг	Тийм	Нийтийн бүх бэлчээр хуваарилагдчихна	Гэрээ хийгээд төлбөр төлнө

Малын тоог хянах

Одоогийн бэлчээрийн доройтлын асуудлыг шийдэхэд малын тоогоо бэлчээрийн даацдаа тохируулан барих явдал хамгийн чухал асуудал юм гэж үзэж байна. Энэ чиглэлээр ажилладаг талуудын саналыг авахын тулд холбогдох асуултыг БАХ үйл ажиллагаа явуулдаг газруудад тавилаа. Учир нь бид БАХ бий болсноор бэлчээрийн доройтлыг хэрхэн шийдэх вэ? гэдгийг ихээхэн сонирхож байгаа юм. Асуултыг дараах байдлаар асуусан болно. БАХ бэлчээрийн менежментийн үйл ажиллагаа явуулаад бэлчээрийн чанарыг сайжруулсан ч бэлчээрийн даац малдаа хүрэлцээгүй байсаар байвал малын тоогоо малчид хязгаарлах болов уу? Өндөр уулын болон ойт хээрийн бүсэд судалгаанд хамрагдагсад ерөнхийдөө БАХ бий болсноор малын тоо буурна гэдэгт итгэж байгаа бол тал хээрийн болон цөлөрхөг хээрийн бүсэд малын тоо өснө гэжээ. Ногоон алтын долоон сумын тавд нь малчид малын тоог бууруулна, гэхдээ урьд нь байсан олон малаас олдог орлогыг орлох ямар нэгэн зүйл бий

болбол гэж үзэж байна. Харин бэлчээрийн доройтол малын тооноос болж байна гэж үздэггүй цөлөрхөг хээрийн бүсийн малчид малын тоог бууруулахгүй гэж бодож байна. Мөн БАХ байгуулагдаад удаагүй байгаа Дуут сумынхан малын тоог бууруулахгүй гэж үзжээ. Малын тоог бууруулна гэж байгаа газруудад малын тоог бууруулсны дараах ач холбогдол нь юу юм бэ? гэдэг мэдээллийг ихээхэн түгээх хэрэгтэй. Ингэснээр малчид малын тоог бууруулна гэсэн амлалтаа сайн дагаж мөрдөх болно гэж үздэг ажээ. Зарим тохиолдолд орон нутгийн захиргаа, хашир туршлагатай малчдын зөвлөгөө хэрэгтэй гэж үзэж байгаа газар ч байна.

Малын тоог бууруулах, зарим хэцүү жилүүдэд өвөл болохоос өмнө малаа ихээр борлуулах хоёр нь өөр өөр ойлголтууд юм. Сүүлчийнх нь өвөл мал ихээр хорогдох эрсдэлийг бууруулах механизм болдог. Гэсэн хэдий ч ингэж малын тоог бууруулах нь зах зээл дээр хэт нийлүүлэлтийг бий болгож малын үнийг унагадаг.

**Дүгнэлт**

1. БАХ-ийн тогтолцоо сайн хөгжсөн газруудад малын тоог бууруулна гэсэн санааг сайн хүлээж авч байна. Харин цөлөрхөг хээрийн бүсэд байдал өөр байна.
2. Малчид малын тоог бууруулах санааг хүлээн авч, түүнийгээ дагаж мөрддөг болгохын тулд тэдний дунд малын тоог бууруулахын ач холбогдлын талаарх мэдээллийг түгээх, туршлагатай малчид, орон нутгийн захиргааны дэмжлэгийг авах хэрэгтэй.

Хүснэгт 7: Малын тоог хязгаарлах

Бүс	Сум	БАХ-ийн тогтолцоо хөгжснөөр малын тоо	Малын тоог хязгаарлах		
			Малын тоог хязгаарлах уу?	Яаж хэрэгжүүлэх вэ?	Хүлээн зөвшөөрүүлэхийн тулд яах вэ?
Өндөр уул	Цэнгэл	Буурна	Тийм	Малчидтай гэрээ хийнэ	Төрийн бодлого хэрэгтэй
	Дуут	Буурна	Үгүй	Мэдэхгүй	Мэдлэг, мэдээлэл сайн өгөх
Ойт хээр	Их тамир	Буурна	Тийм	Малчидтай ярьж ойлгуулах хэрэгтэй	Туршлагатай малчдаас дэмжлэг авах хэрэгтэй
	Тэлмэн	Буурна	Тийм	Малчидтай ярьж ойлгуулах хэрэгтэй	Туршлагатай малчдаас дэмжлэг авах хэрэгтэй
Тал хээрийн төв	Өндөр ширээт	Өснө	Тийм	Малчидтай ярьж ойлгуулах хэрэгтэй	Мэдлэг, мэдээлэл сайн өгөх
Цөлөрхөг хээр	Өлзийт	Өснө	Үгүй	Бидэнд том газар бий	Ятгаж, хүлээн зөвшөөрүүлэх гээд хэрэггүй



Ном зүй

Фернандез-Жименез, Мариа Е, Акира Камимура, Батбуян Батжавын, 2008, “Монгол улсын газрын хуулийг хэрэгжүүлэх нь: Дэвшил, холбогдох асуудлууд” Ногоон алт төсөлд өгсөн эцсийн тайлан.

Гордон. Х, С, (1954). Нийтийн өмчлөлийн нөөцийн эдийн засгийн онол: Загас. Улс төрийн эдийн засгийн сэтгүүл, 62 (2):124–142.

Хардин, Г. (1968). Нийтийн эмгэнэл. Шинжлэх ухаан сэтгүүл, 162:1243–1248.

Монголын бэлчээрийн менежментийн холбоо, 2009. Монголын малчдын амьжиргааны судалгаа, Улаанбаатар хот.

Монгол улсын Үндэсний статистикийн газар, (2009), Монголын ядуурлын судалгаа

Остром, Е. (1990). Нийтийг удирдах нь: Хамтын үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын хувьсал. Кэймбрижийн их сургуулийн хэвлэл, Кэймбриж, Нью Ёрк.

Остром, Е. (2000). Хувийн болон нийтийн өмчийн эрх. хуудас 332–379. Эдвард Ийглар, Челтенхам, Англи улс.

Остром, Е. (2009). Нийгэм-экологийн тогтолцоо: нийгэм-экологийн тогтолцооны тогтвортой байдлыг судлах ерөнхий хүрээ, Шинжлэх ухаан сэтгүүл, 325:419.

Томас, Твимэн, (2004), Сайн бэлчээр үү, муу бэлчээр үү? Калахарагийн ургамлын динамикийн талаарх орон нутгийн ойлголт, мэдлэг, шинжлэх ухааны хосолмол. Газрын доройтол ба хөгжил сэтгүүл, 14:215-231.

Весулс, Ланг (2010). Малчдын үзэл, шинжлэх ухааны үнэлгээ: Намибигийн хагас хуурай нутгийн бэлчээрийн байдлын үнэлгээ, Хүний экологи сэтгүүл.

Дэлхийн Банк, (2006). Монголын ядуурлын үнэлгээ, Тайлан. No 35660-MN. Улаанбаатар.

Дэлхийн Банк, (2009). Монголын ядуурлын байдал. Улаанбаатар.

Хавсралт

А I: Бэлчээрийн ургамлын динамикийн тэнцвэрт, тэнцвэрт бус экологийн загвар

(Clements 1936; Ellison 1960)-ын **ургамлын нөмрөгийн өөрчлөлтийн тэнцвэрийн загвар болон** (Caughley 1979)-ын ургамал-өвсөн тэжээлтний динамикийн сонгодог загвар нь өвсөн тэжээлтний тооны өсөлт, ургамлын үржил шим, нэр төрлийн бүтцийн хоорондын харилцааг нягт харуулдаг. Өвсөн тэжээлтний бэлчээрлэх эрчимжилт болон ургамлын нөмрөгийн энэхүү харилцаа нь ургамлын динамикийн бэлчээрийн нөхцөл (БН)-ийн загварыг (Dyksterhuis 1949) бий болгодог. БН-ийн загвараар бол өвсөн тэжээлтний тоо өсөхөд ургамлын биомасс болон нөмрөг буурч нэр төрөл нь олон наст өвс, луулийн давамгайлалаас нэг наст амт, үнэр муутай шарилж/лууль болон хогийн ургамлын давамгайлалаар солигддог. Өвсөн тэжээлтнийг бэлчээрлэхээ больвол ургамлын биомасс болон нөмрөг нэмэгдэж, нэр төрөл нь хуучин байсан хэлбэртээ удаан хугацааны дараа ордог.

Дараагийн загвар нь (Ellis&Swift 1988)-ын бэлчээрийн газрын динамикийн **тэнцвэртэй бус үргэлжлэх (ТБҮ) загвар** юм. Энэ загвар нь ургамал болон өвсөн тэжээлтний тооны динамикт биологийн бус хүчин зүйлүүдийн үр нөлөө ямар байгааг харуулдаг. Бэлчээрийн динамикийн ТБҮ загвараар бол ихэнх бэлчээрийн экосистем нь түүн дээрх амьтны нягтаршил болон биологийн харилцаанаас гэхээсээ илүү нягтаршлын бус болоод биологийн бус хүчин зүйлүүдээс хамаардаг. Жилээс жилд, улирлаас улиралд бэлчээрийн бүтээмж болон өвсөн тэжээлтний тоо маш их хэлбэлздэг нөхцөлөөс үл хамааран эдгээр экосистем болон түүн дээр байгаа бэлчээрийн амьтад байнга үргэлжлэн оршдог.

Тэнцвэрт загвар нь ургамал ургах нөхцөл жилээс жилд харьцангуй тогтвортой, түүн дээр нятаршлаасаа хамаарч хязгаарлагдах хүртэл малын тоо байнга өсөж байх бололцоотой нөхцөлд оршдог. Гэвч ихэнх бэлчээрт хур тундасны болон ургамлын үр шимийн хэлбэлзэл, түүнчлэн урт хугацааны ган, зуд маш их тохиолддог. Тийм нөхцөлүүдэд ургамлын нөмрөгийн нэр төрөл, тоо хэмжээнд нь томоохон өөрчлөлт ордог нь малын тооны өөрчлөлттэй уялддаггүй. Иймд ургамлын биомасс, нөмрөг, нэр төрөл нь цаг уурын өөрчлөлтийн хүчин зүйлээс хамаардаг болохоос биш түүний үржил шим, нэр төрөлд өвсөн тэжээлтний гүйцэтгэх үүрэг маш бага юм.

Тэнцвэртэй бус бэлчээрийн экосистемийн үед: (I) ургамал-өвсөн тэжээлтний хоорондын харилцаа маш сул; (II) өвсөн тэжээлтний тоо тэдгээрийн нягтаршлын бус хүчин зүйлүүдээс хамаардаг; (III) бэлчээрийн даац нь малын тоотой харьцуулахад маш их өөрчлөлттэй; (IV) ургамлын биомасс нь биологийн бус хүчин зүйлүүдээс хамаардаг; (V) ургамлын нөмрөгийн өрсөлдөөн нь түүн дээр байгаа ургамлын бүтцийг тодорхойлоход чухал хүчин болж чаддаггүй. Харин үүний эсрэгээр **тэнцвэртэй бэлчээрийн экосистемийн загварын үед** (I) ургамал-өвсөн тэжээлтний хоорондын харилцаа маш нягт; (II) өвсөн тэжээлтний тоо нягтаршлаасаа шууд хамаардаг; (III) бэлчээрийн даац өөрчлөгдөхөд малын тоо өөрчлөгддөг; (IV) өвсөн тэжээлтэн ургамлын биомассыг тодорхойлдог; (V) ургамлын нөмрөгийн өрсөлдөөн нь түүн дээрх ургамлын бүтцийг тодорхойлоход чухал хүчин болдог.

Эх үүсвэр: Мариа Е. Фернандез, Барбара Аллен-Диаз, 1999.

**A II: Судалгаанд хамрагдсан сумууд**

Бүс	Аймаг	Сум	Хандивлагчдын төслүүд*
Өндөр уул	Баян-Өлгий	Цэнгэл	НА 2005 оноос хойш
		Улаан хус	ТАТ 2002 оноос хойш
	Ховд	Дуут	НА 2008 оноос хойш
		Дөргөн	Төсөл байхгүй
Ойт хээр	Завхан	Тэлмэн	НА 2005 оноос хойш
		Идэр	Төсөлгүй
	Архангай	Их тамир	НА 2005 оноос хойш, ХААХОУС 1996 оноос хойш
		Өндөр-Улаан	1996 оноос хойш ХААХОУС
Газар тариалан-мал аж ахуй хосолсон ойт хээр	Сэлэнгэ	Баянгол	Орон нутгийн захиргаа (БТМ)
		Мандал	Төсөлгүй (БТМ)
Тал хээрийн төв	Төв	Өндөрширээт	НА 2007 оноос хойш
		Баян-Өнжүүл	ТАТ 2002 оноос хойш (ЦТГТМ)
		Эрдэнэсант	ТАТ 2002 оноос хойш
		Алтанбулаг	ХДЦГ 1994 оноос хойш
Малын нягтаршил багатай тал хээрийн зүүн	Дорнод	Матад	ТАТ 2002 оноос хойш
		Баян-Уул	ТАТ 2002 оноос хойш
		Булган	Төсөлгүй
		Цагаан-Овоо	Төсөлгүй
Цөлөрхөг хээр	Дундговь	Өлзийт	НА 2005 оноос хойш
		Хулд	Төсөлгүй
		Гурвансайхан	ТАТ 2002 оноос хойш
	Дорноговь	Өргөн	Төсөлгүй (ЦТГТМ)

*Судалгаанд голчлон авч үзсэн дөрвөн донорын бэлчээрийн менежменттэй холбоотой төслүүдэд үндэслэв (ДБ, ШХА, НҮБХХ, ХААХОУС).